**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

/2022 оны жилийн эцсийн байдлаар/

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв | Зорилтот түвшин 2022 | Хэрэгжилт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. НЭГ. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | |
| 1 | 1.1.1. Ковид-19 шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ. | 1. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний болон нөөцийн бэлэн байдлыг хангах | 2021 - 2024 | | 16 | КОВИД-19” шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн шуурхай штабын тохиолдлын удирдлагын тогтолцооны багийг аймгийн Засаг даргын захирамжаар 6 баг 21 бүлэг 118 төрийн албан хаагчийн бүрэлдэхүүнтэй томилон салбар дундын оролцоог ханган иргэдэд эмнэлгийн тусламж үйлчилгээг газар дээр нь түргэн шуурхай, чанартай хүргэх шуурхай хариу арга хэмжээний 16 эрүүл мэндийн байгууллагын 32 баг бэлэн байдлыг ханган хариу арга хэмжээг авч ажиллаж байна. Ковид -19 халдварын 44 батлагдсан ор байгаа бөгөөд цаашид эмнэлгийн бус нөхцөлд дэлгэх боломжтой 250 орыг төлөвлөн ажиллаж байна.<br>2022 оны 11 дүгээр сарын байдлаар Эм тариа- 678,2 сая төгрөг / 21-30 хоног/, Антибиотик -32,8 сая төгрөг / 10-14 хоног/, Эмнэлгийн хэрэгсэл- 20 сая төгрөг /14-21 хоног/, Хамгаалах хувцас хэрэгсэл-542 сая төгрөг /14-21 хоног/, Ариутгал халдваргүйтгэлийн бодис- 23,2 сая төгрөг / 7-10 хоног/-ийн нөөцтэй байна.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийг ашиглалтанд орлуулан аймагт хүчилтөрөгч үйлдвэрлэх асуудлыг шийдвэрлээд байна. | 100 |
| 2 | | 2. Аймгийн нэгдсэн эмнэлэгт PCR шинжилгээ хийх орчин нөхцөл бүрдүүлэх, урвалж оношлуураар хангах | 2021 - 2024 | | 1500 | Коронавируст халдварыг илрүүлэх PCR-ийн шинжилгээ хийх орчин нөхцөлийг бүрдүүлж, 2021 оны 05 дугаар сарын 16-наас эхлэн АНЭ-т шинжилгээг хийж эхэлсэн. 2022 оны 11 дүгээр сарын 22-ны байдлаар пгу-3766, тодорхойлох 4042, ялгах 2740 оношлуурыг татан тасралтгүй бэлэн байдлыг хангаж ажилласан | 100 |
| 3 | | 3. Бичигт хилийн боомтод тандалтын нэгж байгуулах | 2022 - 2024 | | 1 | Бичигт боомтод хилийн нэвтрэх цэгийн хариу арга хэмжээг сайжруулах, тандалтын нэгж байгуулах нэгжийн байрыг гарган засвар болон тохижилт, эмч ажилчдын амьдрах байрыг бэлтгэх санхүүгийн тооцооллыг гарган аймгийн Онцгой комиссын хурлаар хэлэлцүүлэн эмчийг Эрдэнэцагаан сумын ЭМТ-с 1 их эмч, 1 бага эмч ажиллуулахаар шийдвэрлэн бэлтгэл ажлыг хангаад байна.ЭМЯ-аас явуулын эмнэлэг, тоног төхөөрөмж шийдвэрлэгдсэн тохиолдолд нэгж байгуулах бэлтгэл аймгийн зүгээс бэлтгэл хангагдсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | 1.1.2. Ковид-19 цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилт, нөөц хангалтыг нэмэгдүүлнэ. | 1. Гамшгийн эрсдэлийн сангийн нөөцийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 542 сая | 75 | 2022 оны 11 дүгээр сарын 22-ны байдлаар Эм тариа- 678,2 сая төгрөг / 21-30 хоног/, Антибиотик -32,8 сая төгрөг / 10-14 хоног/, Эмнэлгийн хэрэгсэл- 20 сая төгрөг /14-21 хоног/, Хамгаалах хувцас хэрэгсэл- 542 сая төгрөг /14-21 хоног/, Ариутгал халдваргүйтгэлийн бодис- 23,2 сая төгрөг / 7-10 хоног/-ийн нөөцтэй байна. АНЭ, УАУ-ны эмнэлэг, ӨСЭМТ-үүдэд 109,7 сая төгрөгийн өртгөг бүхий тоног төхөөрөм, 567,6 сая төгрөгийн оношлуур, эм эмнэлгийн хэрэгслээр хангаж ажилласан. " | 100 |
| 5 | | 2. Бараа материал, хувцас хэрэглэл, эм, эмнэлгийн хэрэгсэл,ариутгал халдваргүйтгэлийн бодис хэрэгсэл, өвс тэжээл, тоног төхөөрөмжийн нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 677.3 сая | 25 | АНЭ, УАУ-ны эмнэлэг, ӨСЭМТ-үүдэд 109,7 сая төгрөгний өртгөг бүхий тоног төхөөрөмж, 567,6 сая төгрөгийн оношлуур, эм эмнэлгийн хэрэгслээр хангасан. Нийт - 677,3 сая төгрөгний эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, тоног төхөөрөмжөөр хангаж нөөцийн хангалтыг нэмэгдүүлж ажилласан. | 100 |
| 6 | | 3. Аймгийн төв дэх зочид буудал, сургуулийн дотуур байруудыг тусгаарлан ажиглах байр болгох, бэлтгэлийг хангаж тоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 70 | Аймгийн засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/294 тоот тушаалаар ОБГ, МХГ, ЭМГ, БОАЖГ, Стандарт хэмжилзүйн газрын хамтарсан баг аймгийн засаг даргын орлогчоор ахлуулан Баруун-Урт сумын 9 буудалд КОВИД-19 халдварын сэргийлэлт хяналт, буудлын стандарт, эрүүл ахуй халдвар хамгаалал галын аюулгүй байдлын чиглэлээр ажиллаа. Аймгийн хэмжээнд 19 буудал үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд шаардлагатай тохиолдолд тусгаарлан ажилглах байраар ашиглах боломжтой. | 100 |
| 7 | | 4. Тусгаарлах байранд шаардлагатай эд зүйл, хэрэгслийг бэлтгэх | 2021 - 2024 | | | | |
| 2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ | | | | | | | |
| 8 | 2.1.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, оношилгоо, шинжилгээний | 1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, зөв дадал хэвшлийг бий болгоход чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах | 2021 - 2024 | 7.8 сая | | Халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр элэгний хавдар, зөв зохистой хооллолт, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа, идэвхитэй дасгал хөдөлгөөнийг дэмжих, дархлаажуулалтын ач холбогдлыг таниулах, оюутны эрүүл мэндийг дэмжих зэрэг 116 арга хэмжээнүүдийг зохион байгуулж давхардсан тоогоор 263620 иргэнийг хамруулсан байна. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүд /BBS телевиз, Sb info сайт, Сүхбаатарын өнгө сонин/ -тэй хамтран ажиллах гэрээг 7.8 сая төгрөгөөр байгуулж иргэдэд тогтмол эрүүл мэндийн чиглэлээр зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | 3. Эрүүл ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 300.0 төгрөг | | Эрүүл ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын захирамжаар "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах комисс"-ыг байгуулан ажилаж жил бүр комсисст ирүүлсэн материалыг хянаж Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу шалгаруулж хэвшсэн бөгөөд 2021 онд Эрүүл мэндийг дэмжигч байгууллага болох зорилт тавин ажиллаж тайлангаа ирүүлсэн байгууллагуудынг журмын дагуу үнэлж 1 байгууллагад Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын 3-р зэргийн гэрчилгээ олгож мөнгөн урамшууллыг Засаг даргын нөөц сангаас гаргалаа. Мөн "Ажлын байрны эрүүл мэнд" сургалтыг зохион байгуулж 40 ААН, байгууллагын 60 албан хаагчдыг хамруулж Эрүүл ажлын байрыг нэмэгдүүлэх зөвлөмж зөвлөгөөг хүргэлээ.Эрүүл ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр 3 удаагийн сургалтын 132 төрийн байгууллагуудын 458 ажилтан албан хаагчдад танхимын сургалтыг зохион байгуулж одоогоор 5 байгууллага эрүүл мэндийг дэмжигч байгууллагын материалаа ирүүлэхээр саналаа ирүүлээд байна. | 100 |
| 11 | | 4. ХДХВ/ДОХ, БЗДХ, сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог сум, баг, байгууллагуудын түвшинд зохион байгуулах | 2021 - 2024 | 51.3 сая | 70 хувь | Эрүүл мэндийн сайдын батасан “Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө”-г баримтлан ажиллаж ХДХВ/БЗДХ-ыг илрүүлэх үзлэг шинжилгээг зохион байгуулж ОНТ-өөс 37 сая, аймгийн Засаг даргын үйл ажиллгааг хэрэгжүүлэх зардлаас 14.3 сая төгрөгийг гарган зорилтот бүлгийн хүн аамын 73 хувийг хамруулсан байна. Глобал сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн хүрээнд сүрьеэгийн хавьтлын илрүүлэг зохион байгуулах хамтран ажиллах гэрээний дагуу Баруун-Урт, Асгат, Халзан, Мөнххаан, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдад ЭМГ, АНЭ хамтарсан баг ажиллаж 1467/хавьтал-728/ иргэнийг үзлэгт хамруулснаас 8 шинэ тохиолдлыг илрүүлж ажилласан байна. Мөн Глобал сангийн дэмжлэгтэй Эрдэнэцагаан суманд зорилтот бүлэгт чиглэсэн Сүрьеэгүй сум төсөл хэрэгжиж байна. Мөнххаан, Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Асгат, Түмэнцогт сумдын Сүрьеэг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 276 иргэнд идэвхтэй хяналт, рентгенд- 1193 иргэдийг хамруулан, сорьцын шинжилгээнд 35 илгээснээс шинэ 3 батлагдаж эмчилгээнд хамруулан ажиллаж байна. Эрсдэлт бүлгийн хүн амыг БЗДХ-ыг илрүүлэх идэвхтэй илрүүлгийн үзлэгт хамруулах ажлыг Мөнххаан, Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Асгат, Түмэнцогт, Онгон сумдын зорилтот бүлгийн 5044 хүн амыг ХДХВ /ДОХ/ БЗДХ урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулснаас хуучин-280, шинэ -12 тэмбүү өвчнийг илрүүлж хавьтлын эмчилгээг 100 хувь хийлгэсэн байна. Сүрьеэг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 276 иргэнд идэвхтэй хяналт, рентгенд- 1193 иргэдийг хамруулан, сорьцын шинжилгээнд 35 илгээснээс шинэ 3 батлагдаж эмчилгээнд хамруулан ажиллаж байна.2022 оны 10 дугаар сарын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлаар нийт 4173 халдварт өвчний тохиолдол бүртгэгдсэн 10000 хүн амд 640.5 тохиолдол ногдож байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн тоо өнгөрсөн оны мөн үеэс 1344,6 промилиор буурсан байна. Нийт бүртгэгдсэн халдварт өвчнөөс 3827/91 хувь ковид-19 10000 хүн амд 586, бэлгийн замаар дамжих халдвар нь нийт халдвар өвчний 172 буюу 4,6 , сүрьеэ өвчний 52 тохиолдол бүртгэгдсэн 1,2 тус тус эзэлж байна | |
| 12 | | 5. Артерийн даралт ихсэх, чихрийн шижин болон хөх, умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг үзлэгийг жил бүр хийж хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 70 | Эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ аймгийн хэмжээнд артерийн гипертензи 20715/13428 64 хүн хамрагдсанаас өвчлөл 92/0,6 , чихрийн шижин хэв шинж-2 24790/15162 61 хүн хамрагдсанаас өвчлөл 13/0,1 , умайн хүзүүний өмөнгийн шинжилгээнд 4683/2221 47 хүн хамрагдсанаас 217/11,2 өөрчлөлттэй 2/0,1 БЗДХалдвартай, хөхний үзлэгт 13413 /8375 62 хүн хамрагдсанаас өвчлөл хөхний эмнэл зүйн шинжилгээгээр эерэг гарсан -106/1,3 байна. | 90 |
| 13 | | 6. “Хавдрын эсрэг хамтдаа” арга хэмжээг жил бүр зохион байгуулах | 2021 - 2024 | 547 сая | | Эрүүл Сүхбаатарчууд төслийг эхлүүлэн зоритот 4 сумын эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй иргэдэд ВС вирүсийн илрүүлэг шинжилгээний оношлуурын зардлаг аймгийн Засаг даргын үйл ажиллагааг хэрэгжүүлэх өхтөлбөрийн зардлаас гарган мөн хавдрын эсрэг арга хэмжээний хүрээнд Гепатитгүй Монголчууд төсөл Олон улсын Ротари клубын 535 сая төгрөгний санхүүжилттайгаар хэрэгжүүлэгч Файр төрийн бус байгууллагатай хамтран 13 суманд 3458 хүнийг В, С вирус илрүүлэх үзлэг шинжилгээнд, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт – 6095 хүнийг хамруулсан. Үзлэгээр хавдрын сэжигтэй 43 тохиолдлыг илрүүлж С вирустэй 202, В вирустэй 452 хүнийг илрүүлж 3-р шатлалд илгээх, вирусын ачааллыг тоолуулж эмчилгээнд хамруулах арга хэмжээг зохион байгууллаа. хавдрын шалтгаант нас барат өмнөх оны төн үеэс 22 тохиолдлоор буурсан байна. | 90 |
| 14 | | 7. Элэг бүтэн Сүхбаатар хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 535 сая | | Элэг бүтэн хөтөлбөрийг үргэлжлүүлэн гүйцэтгэж С вирус илэрсэн 1980 тохиолдоын судалгааг сум багаар гаргаж вирусын ачааллыг тоолуулж эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. | 90 |
| 15 | | 8. "Эрэгтэйчүүдийн өвчлөл, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлийг судалж, Эрчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх " | 2021 - 2024 | - | - | Хүн амын өвчлөл нас баралтын 10 жилийн мэдээлэлд дүгнэлт хийж Эрүүл Сүхбаатарчуудыг төслийг бичиж эрэгтэй эмэгтэйчүүдийн дундаж наслалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх үзлэг аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд нийт 4728 иргэн, 1-12 ангийн 457 хөвгүүдийг үзлэгт хамрагдсан. В вирус илрүүлэх шинжилгээнд 1933 хүн, В гепатитын эсрэг вакцинд 1173 хүн хамрагдсан. Эрэгтэйчүүдэд Эрт илрүүлгийн үзлэгийн ач холбогдол, архи тамхины хэрэглээний хор уршиг, дасгал хөдөлгөөн, зохистой хооллолтын чиглэлээр 75 удаагийн сургалтыг 2860 хүнд хийсэн. Үзлэгийн үр дүнд Чихрийн шижин-27, Цусны даралт ихсэх өвчин -41, давсагны үйланхай -1, Бамбайн хордлого-1, Бөөрний судасны гаралтай даралт ихсэлт -1, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Элэгний хорт хавдар -7, Ходоодны хорт хавдар -1, Элэгний в вирус -31, С вирус -9 хүнийг илрүүлж дараагийн шатлалд онош тодруулах, эмчлэх, хяналтанд авах арга хэмжээг авч ажилласан. | |
| 16 | 2.1.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд орон нутагтаа оношлогдон, эмчлүүлэх боломжийг бүрдүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ. | 1. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэвлийн хөндийн дурангийн мэс заслын тусламж үйлчилгээг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | | Улсын төсвийн 296,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвлийн хөндийн дурангийн мэс заслын аппарат нийлүүлэгдэж цөсний бүхий л төрлийн хагалгаа, мухар олгойн хагалгаа, өрцний ивэрхий, ивэрхий нөхөх, болон эмэгтэйчүүдийн хагалгаа хийх бүрэн боломжтой болсон. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар чулуутай цөсний хүүдий авах 21 хагалгааг амжилттай хийгээд байна. | 100 |
| 17 | | 3. Нүдний эвэрлэг болон салстын мэс заслыг орон нутагт хийх | 2021 - 2024 | 39.5 | | Аймгийн нэгдсэн эмнэлэгт нүдний мэс заслын багаж 39.5 сая төгрөгний хөрөнгө оруулалт хийгдсэн . Одоогоор нүдний салстын мэс засал -11 хүнд хийсэн байна. | 100 |
| 18 | | 2. Анхан шатны эрүүл мэндийн бүх байгууллагуудад мобайл технологийг нэвтрүүлэх | 2021 - 2024 | 99 сая | | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд мобайл технологиор 100 хувь хангагдсан.Үүнд ДЭМБ-аас 2 сумын ЭМТ, аймаг орон нутгийн хөгжлийн сангаас 10 сум, 3 ӨЭМТ-ийг хангажээ . ДЭМБ-ын санхүүжилтээр анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх сургалтын хүрээнд анхан шатны 15 эрүүл мэндийн байгууллагуудын 45 эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд мобайл технологийг ашиглалтыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 19 | | 4. Алслагдсан хөдөөгийн хүн амд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүлэх | 2021 - 2024 | 48.5 сая-ОНТ | 9 сум | Тайлант хугацаанд Мөнххаан, Баяндэлгэр, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Асгат, Түмэнцогт, Онгон сумдад явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг 5-8 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын нийт давхардсан тоогоор 19127 иргэд, зорилтот бүлгийн 5044 хүн амыг ХДХВ /ДОХ/ БЗДХ урьдчилан сэргийлэх шинжилгээнд хамруулан хуучин-280, шинэ -12 тэмбүү өвчнийг илрүүлэн хавьтлын эмчилгээг 100 хувь хийлгэсэн байна. Сүрьеэг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 276 иргэнд идэвхтэй хяналт хийж рентгенд- 1193 иргэдийг хамруулан, сорьцын шинжилгээнд 35 илгээснээс шинэ 3 батлагдаж эмчилгээнд хамруулан ажиллаж байна.<br>Нийт 48.5 сая төгрөгийг зарцуулсан байна. | 100 |
| 20 | | 5. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт гэмтлийн тасгийг шинээр байгуулж, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 2022 - 2024 | | 1 1 | АНЭ -т гэмтлийн тасгийг шинээр байгууулах зорилгоор бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж байна . Үүнд гэмтлийн нарийн мэргэжлийн эмч -3 бэлтгэн, төсөл хөтөлбөрийн хүрээнд 280.0 сая төгрөгний багаж төхөөрөмжөөр хангаад байна /CRM/ Одоогоор гэмтлийн чиглэлээр 9 төрлийн тусламж үйлчилгээг үзүүлж байна Шинээр 3 төрлийн тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн байна Үүнд үе солих мэс засал- 4, шууны ясны дундуур хагас ил аргаар яс хадах мэс засал -3 | 70 |
| 21 | | 6. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт андрологи, урологи, герантологийн | 2021 - 2024 | УТХО-313.7 сая | | Аймгийн нэгдсэн эмнэлэгт уралогийн дурангийн хагалгааг шинээр нэвтрүүлж шээсний сүвийн нарийсал зүсэх хагалгаа-3, стент гуурс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тусламж үйлчилгээний кабинет байгуулж эмч мэргэжилтнээр хангах | | | | тавих хагалгаа 3, түрүү булчирхай дурангийн мэс засах хагалгаа 13 хүнд хийгээд байна. | |
| 22 | | 7. Сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх жишиг сумын Эрүүл мэндийн төв байгуулж эмч, мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах | 2021 - 2024 | - | - | Монголын Дотрын Сувилагчдын нийгэмлэгтэй хамтран Баяндэлгэр сумын эрүүл мэндийн төвийн сувилахуйн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, яаралтай тусламжийн чиглэлээр жишиг сувилахуйн эрүүл мэндийн төв болгох зорилгоор үнэлгээ судалгаar Эхний ээлжинд тоног төхөөрөмжийн судалгаа хийсний дагуу сувилагчийн тэргэнцэр 2, дуслын штатив 2, яаралтай тусламжийн биксүүд 4 зэргийг аваад байна. 1 сувилагчийг УГТЭ-ийн яаралтай тусламжийн эрэмбэлэн ангилалт, Эмчлүүлэгчийг унах эрсдлээс сэргийлсэн аюулгүй ажиллагаа, Ижил савлагаатай болон эм тарианы дуусах хугацаа, ялгах тэмдэглэгээ, Blue cod / эмнэлзүйн тохиолдол дээр ажиллах/ зэрэг сургалтад хамруулсан. | 90 |
| 23 | | 8. Баруун-Урт хотод сувилахуйн төв байгуулах төсөл хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 1 | Сувилахуйн “Од” жишиг төв байгуулах төсөл дэмжигдэж, ажлын байрны үнэлгээ хийгдэн тэнцсэн. Үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн материалаа бүрдүүлэн ЭМГ-ын дэргэдэх тусгай зөвшөөрлийн комисст хүргүүлсэн. | 70 |
| 24 | 2.1.3. Эх, хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах, өвчлөл, эндэгдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, нялхсын эндэгдлийг өмнөх 4 жилийн дундажтай харьцуулахад 1000 амьд төрөлтөд 3.4 промилиор бууруулж, эхийн эндэгдэлгүй ажиллана. | 1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, сум дундын эмнэлэгт эх, хүүхдийн өвчлөлийг бууруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах төрөлжсөн мэргэжлийн эмч нараас бүрдсэн “Эх хүүхдийн баг”-ийг жил бүр ажиллуулах | 2021 - 2024 | | | Эх, хүүхэд, нярайн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах, нялх, бага насны хүүхэд, хөхүүл жирэмсэн эхэд хооллолтын зөвлөгөө өгөх ур чадварыг нэмэгдүүлэх, өрх, сумдын эмч мэргэжилтний мэдлэг, ур чадварыг сайжруулах, иргэдийн эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг сайжруулж эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Эх хүүхдийн чанарыг сайжруулах баг” Сүхбаатар суманд ажилласан. Сургалтад 50 эцэг эх, асран хамгаалагчид, 17 эмч эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. 11 сарын 28-ны өдрөөс Баяндэлгэр, Дарьганга, Онгон, Асгат, Халзан сумдад ажиллахаар төлөвлөж зардлыг ЭМГ-аас гаргаад байна.ЭМС-ын 2022 оны 5-р сарын 06 ны өдрийн А/263 дугаар тушаалын дагуу бүртгэгдсэн 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдлуудын хурлыг 2022 оны 04-сарын 21нд, 2-р улирлын магадлан хэлэлцэх комиссын хурлыг 2022 оны 08-р сарын 19-нд нийт 10 эндэгдлийн хурлыг Эрүүл мэндийн газрын сургалтын өрөөнд хийж дүгнэлт гаргаж Зөвлөмж хүргүүлсэн. Материалыг ЭХЭМҮТ-ийн ТСА-нд хүргүүлсэн. Хуралд ЭМГ-ын эх хүүхдийн багийн гишүүд , АНЭ-ийн удирдлага, хүүхдийн эмч нар, холбогдох СЭМТ-ын дарга нар, сумдын хүүхэд хариуцсан эмч нар, эмгэг судлалын эмч нар оролцсон. | 90 |
| 25 | | Суурь өвчлөлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуны сувилалд хамруулах ажлыг зохион байгуулах | 2022 - 2024 | | 50 | Суурь өвчлөлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийн зуны сувиллыг нийт 5 суманд зохион байгуулж 173 хүүхдийг хамруулсан. Үүнд :АНЭ-60, Баяндэлгэр сумын ЭМТ -54, Дарьганга Сумын ЭМТ-24,Түвшинширээ-15,Онгон -20 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 26 | | 3. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүүхдийн мэдрэлийн кабинет байгуулж ЭЭГ-ээр хангах | 2021 - 2024 | | 1 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүүхдийн мэдрэлийн кабинет байгуулж нийт 768 үзлэг хийгдэж 178 хүүхдийг хяналтад авсан байна.ЭЭГ - 6 хүүхдэд хийгдсэн байна | 100 |
| 27 | | 4. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулах | 2021 - 2024 | | | Эрт илрүүлэг үзлэгт 18-45 насны 1006 эмэгтэйчүүд хамрагдсан байна. Дарьганга, Наран, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Баяндэлгэр сумдад явуулын амбулаторийн урьдчилан сэргийлэх үзлэгээр 421 эмэгтэйчүүд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж зорилтот бус 44 эмэгтэйд эсийн шинжилгээ хийгдэж хавдрын сэжигтэй тохиолдол нэг бүртгэгдсэн. Анхан шатлалын эрүүл мэндийн төвүүдэд 2301 эмэгтэйчүүд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. | 90 |
| 28 | | 5. Жирэмсний нэрийн хяналтыг нэвтрүүлэх чиглэлээр сайн туршлага судалж хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | ЭМС-ийн 2020 оны А/318 тоот тушаалын дагуу жирэмсэн эмэгтэй бүрийг анхан шатны эрүүл мэндийн төвийн эмч болон лавлагаа шатлалын эмч давхар хянаж байна. Жирэмсний цахим нэрийн хяналтыг нэвтрүүлэхээр төсөл боловсруулан хянагдаж байна. | 90 |
| 29 | | 6. Эх, хүүхдэд ээлтэй байгууллага, орон нутаг болох хөдөлгөөн өрнүүлж засаг захиргааны байгууллагын манлай ллыг дэмжих | 2021 - 2024 | | | Ажлын байранд "Эх хүүхдэд-Ээлтэй орчин бүрдүүлэх" 1 сарын аяныг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулж байна. | 90 |
| 30 | | 7. Ургийн перинаталь оношилгоог сайжруулах чиглэлээр эмч мэргэжилтнийг сургах урвалж бодис тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | | | Өрх сумын эрүүл мэндийн төвүүд Билиметр-11, Дулаан ширээ-12, Фотоаппарат-10, Нярайн пульсоксиметр-15, 36,9 сая төгрөгний өртгөг бүхий Ургийн доплер, Хүчилтөрөгч өтгөрүүлэгч, Пульсоксиметр бусад шаардлагатай тоног төхөөрөмжийг олгосон байна.Мөн АНЭ-ийн төрөх тасгийг "Link Hands for Hope" ТББ-ын 213.1 сая төгрөгийн өртөг бүхий төрөх, нярайн техник тоног төхөрөмжөөр хангалаа. | 100 |
| 31 | 2.1.4. Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухааны ололттой хослуулан хөгжүүлж, эмчилгээний төрлийг нэмэгдүүлнэ. | 1. Уламжлалт анагаах ухааны төвийг бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | 61.4 сая | | 2022 оны оны 5 сараас эхлэн Уламжлалт анагаах ухааны эмнэлгийг тусгай зөвшөөрөл болон магадлан итгэмжлэлд хамруулан үйл ажиллагаагаа бие даан явуулж эхэлсэн.Уламжлалт анагаах ухааны эмнэлгийн орчин нөхцлийг сайжруулах, эмчилгээний төрлийг нэмэгдүүлэхэд анхаарч ОНТ-өөс 61.4 сая төгрөгийг зарцуулсан байна. | 100 |
| 32 | | 2. Хөдөлгөөн засалчийг бэлтгэх | 2021 - 2024 | | 1 | Уламжлалт анагаах ухааны эмнэлэг үйл ажиллагаагаа эхлэн хдөлгөн засалчийг орон тоогоор ажиллуулахаар төлөлөн цалингийн санг батлуулсан. Улсын хэмжээнд хөдөлгөөн засалчийг бэлтгэж эхэлсэн болоч хомсдолтой байгаагийн улмаас орон нутагт ажиллах боловсон хүчин дутагдалтай хэвээр байна. 2023-2024 онд хөдөлгөөн засалчийг бэлтгэхээр төлөвлөн судалж байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 33 | | 3. Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх хүрээнд гадаад харилцааг өргөжүүлэх | 2021 - 2024 | | | ӨМӨЗОрны Хөлөнбуйр хотын Монголын уламжлалт анагаах ухааны эмнэлэгтэй хамтран ажиллах уулзалтыг цахимаар хийсэн | 100 |
| 34 | | 4. Уламжлалт болон сэргээн засах эмчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 1 | Уламжлалтын нэгдсэн эмнэлэг нь харшлын хануур засал эмчилгээг шинээр нэвтрүүлж халуун эмчилгээг шинээр нэвтрүүлэхэд бэлэн болсон. | 100 |
| 35 | 2.1.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, зайлшгүй шаардлагатай эмийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэн, бүртгэл хяналтыг тогтмолжуулна. | 1. Эмийн чанар аюулгүй байдалд хяналт тавих, эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг орон нутагт чанартай зохион байгуулж зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | - | 2 | Сүхбаатар аймгийн хэмжээнд ЗШЭ-ийн хангалт- 80,6 хувь, Амин чухал эмийн хангалт- 94,8 хувьтай байна. /Дундаж хангалт- 87,7 / АНЭ-т 2022 онд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторын урвалж бодис худалдан авах тендерт нийт 14 компани оролцож, 15 багцад 577,5 сая төгрөгний гэрээ байгуулан ажиллаж байна. 2022 оны 11 сарын байдлаар Ерөнхий гэрээгээр 418.6 сая төгрөг, тендерээр 319 сая төргөг, тендер бусаар буюу шууд худалдан авалтаар 724.7 сая төгрөг нийт 1 тэр бум 462 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэлийг татан авсан. ЭМГ-ын даргын баталсан удирамжийн дагуу АНЭ-ийн 2021 онд худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуур, тендерийн гэрээний гүйцэтгэл, хэрэгжилтэд явцын хяналт хийн дүгнэлт, тайланг ЭЭХХЗГ-т хүргүүлсэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэнд хяналт тавих тухай хууль, бусад дагалдах стандарт, журам, тушаал, шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд 2022 оны 9 сарын 30-нд ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу МЭЙК Баруун-Урт эм хангамж, I-р зэрэглэлийн эмийн санд тус тус хяналт хийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | 100 |
| 36 | | 2. Тусгай зөвшөөрөл бүхий эмийн сангуудад цахим жорыг нэвтрүүлж эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг тогтмолжуулах | 2021 - 2024 | | | Сүхбаатар аймгийн хэмжээнд 2022 оны 10 дугаар сарын 31-ны байдлаар 29 эмийн сангаас 22 эмийн сан цахимаар 956 сая төгрөгний энгийн болон С вирусийн эм, В вирусийн 43,2 сая төгрөгний хөнгөлөлттэй эмийг Е-баримтын хамт иргэдэд олгож, цахим бүртгэл хяналтыг тогтмолжуулан ажиллаж байна. | 90 |
| 37 | | 3. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, иргэд олон нийтэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах | 2021 - 2024 | | | " “Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, бичил биетний тэсвэржилт үүсэхээс сэргийлэх” нь сэдэвт нэг сарын аяныг 2022 оны 10 сарын 01-ээс 11 сарын 01-ны хооронд зохион байгууллаа. Тус аяны хүрээнд ЭМБ-ууд нийт 83 заалттай төлөвлөгөө гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн . - Бичил биетний эсрэг Антиботик эмийн хэрэглээний мэдээлэл болон зохистой хэрэглээний сургалтыг 115 эмч, сувилагч, 43 эмнэлгийн ажилтан нийт 158 хүнд хийсэн. - Амбулаториор болон хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгч нарт давхардсан тоогоор 350 хүнд сургалт зохион байгуулж, 12 төрлийн боршур, 18 төрлийн 250ш гарын авлага, материал хэвлэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчлүүлэгчдэд тараасан . - 2022 оны хагас жилд хэрэглэсэн Антибиотик эмийн хэрэглээнд судалгаа хийж үзэхэд цефатаксим эмийн хэрэглээ өндөр гарсан байна. | |
| 38 | 2.1.6. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг сайжруулан, нийгмийн хамгааллыг бэхжүүлнэ. | 1. Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гад аад улсад суралцах, туршлага судлахад дэмжлэг үзүүлэх | 2022 - 2024 | | 1 | Сүхбаатар сумын ЭМТ-ийн дарга БНСУ-д Нээлттэй эмч нарын нийгэмлэгийн хамтын ажиллагааны хүрээнд 5 хоног туршлага судласан. | 90 |
| 39 | | 2. Эмч, эмнэлгийн ажилтан, анагаахын салбарын оюутнуудыг дэмжих, урамшуулал олгох журам боловсруулан хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, чадавхыг сайжруулах бодлогоор аймгийн "**Засаг даргын нэрэмжит эмч эмнэлгийн ажилчдын урамшууллын багц"-**ыг бий болгож 2022 онд Засаг даргын нөөц сангаас 18 сая төгрөгийг зарцуулан эмч, мэргэжилтнийг урамшууллаа.Аймгийн засаг дарга, сумын засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор тухайн орон нутгаас анагаах ухааны их дээд сургуульд суралцаж буй оюутнуудад сургалтын төлбөрийн тэтгэлэгийг Сүхбаатар сум 2, Түвшинширээ сум 1, Эрдэнэцагаан сум 1 оюутанд тус тус олгосон байна. | 100 |
| 40 | | 3. Эрүүл мэндийн байгууллагын ажилчдыг орон сууцаар хангах, урьдчилгаа төлбөрт хөнгөлөлт үзүүлэх, урт хугацааны зээлд хамруулах боломжийг судалж хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | 2022 онд эрүүл мэндийн байгууллагын 3 ажилтан урт хугацааны зээлд хамрагдсан. | 90 |
| 41 | | 4. Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах | 2022 - 2024 | - | 2 | Эрүүл мэндийн яамны дэргэдэх ёс зүйн салбар хорооноос Гамшгийн үеийн сэтгэл зүйн сургалтыг эрүүл мэндийн салбарын 372 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 2 багц цагийн сургалт зохион байгуулсан. Хүний эрхийн аймаг дахь төлөөлөгчтэй хамтран 100 хүний эрх, хөдөлмөрлөх эрхийн цаашид анхаарах асуудлын талаах 1 өдрийн 1 багц цаг сургалтыг 200 албан хаагчдад хүргэсэн. Нийт ёс зүйн багц сургалтыг зохион байгуулсан. Эмч, сувилагч нар 100 хувь ёс зүйн багц цагаа бүрдүүлсэн. Мөн эрүүл мэндийн газрын албан хаагчийг ёс зүй харилцаа хандлага, зөрчил дутагдлыг шийдвэрлэх ЁС зүйн зөвлөлийг байгуулан, журмыг нь батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |
| 42 | 2.1.7. Эрүүл мэндийн байгууллагуудын барилгын | 1. Өрхийн эрүүл мэндийн төвийн барилгуудыг шинээр барих | 2021 - 2022 | ОНТХО-1.6 тэр бум | 1 | Орон нутгийн 1,6 тэр бум төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 оноос эхлэн Энхлэн Ачтан өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилга угсралтын ажил хийгдэж байна. Ажлын явц 95 хувь | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | шинэчлэл, засвар, үйлчилгээг хийж, стандартын шаардлага хангасан барилгын хувийг 94.4, техник тоног төхөөрөмжийн хангалтыг 85 хувьд тус тус хүргэж, яаралтай тусламжийн автомашины парк шинэчлэл хийж 8-аар нэмэгдүүлнэ. | 2. Мөнххаан сумын ЭМТ-ийн барилга шинээр барих | 2021 - 2024 | УТХО-2,0 тэр бум | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Мөнххаан сумын ЭТМ-ийн барилгын ажил хийгдэж байна. Ажлын явц-92 хувь | 90 |
| 44 | | 4. Аймгийн Нэгдсэн эмнэлгийг нүдний мэс заслын микроскоп, дурангийн мэс заслын багажаар, гэмтэл болон угаалгын тасгийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2022 - 2024 | 857.5 сая | 3 | Аймгийн нэгдсэн эмнэлэгт хүчилтөрөгчийн үйлдвэр байгуулагдсан. Хүчилтөрөгчийн үйлдвэртэй болсноор аймгийн бусад эрүүл мэндийн байгууллагуудын хүчилтөрөгчийн болланыг цэнэглэн хүчилтөрөгчөөр хангаж байна. Улсын төсвийн 296,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвлийн хөндийн дурангийн мэс заслын аппарат нийлүүлэгдэж цөсний бүхий л төрлийн хагалгаа, мухар олгойн хагалгаа, өрцний ивэрхий, ивэрхий нөхөх, болон эмэгтэйчүүдийн хагалгаа хийх бүрэн боломжтой болсон. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар чулуутай цөсний хүүдий авах 21 хагалгааг амжилттай хийгээд байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт Өвдөгний үе солих мэс заслын хагалгааг шинээр нэвтрүүлж 4 хүнд хагалгаа хийгээд байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт нүдний мах авах хагалгааг шинээр нэвтрүүлж 11 хүнд хагалгаа хийгээд байна. Болорын хагалгаанд АНЭ-ийн их эмч, сувилагч нарыг сургаж байгаа. Цаашид болорын хагалгаа хийхээр төлөвлөж байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт уралогийн дурангийн хагалгааг шинээр нэвтрүүлж шээсний сүвийн нарийсал зүсэх хагалгаа-3, стент гуурс тавих хагалгаа 3, түрүү булчирхай дурангийн мэс засах хагалгаа 13 хүнд хийгээд байна. | 100 |
| 45 | | 5. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум дундын эмнэлэг, сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүдийг нэн шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах | 2021 - 2022 | | | АНЭ-т Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны 6-р сард Урологийн дурангийн аппарат, 2022 оны 5 дугаар сард 296,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэвлийн хөндийн дурангийн мэс заслын аппарат, Хүчилтөрөгчийн үйлдвэр нийлүүлэгдсэн. АНЭ, УАУ-ны эмнэлэг, ӨСЭМТ-үүдэд 109,7 сая төгрөгийн өртгөг бүхий тоног төхөөрөмжийг олгож, хангалтыг нэмэгдүүлэн ажилласан. | 100 |
| 46 | | 6. Халзан, Уулбаян, Баяндэлгэр, Түмэнцогт, Мөнххаан, Наран, Онгон сумдыг болон өрхийн Эрүүл мэндийн төвүүдийг мобайл технологиор хангах | 2021 - 2024 | | | Орон нутгийн 99,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7 сум, 3 өрхийн эрүүл мэндийн төвүүдийг алсын зайн оношилгооны Мобайл технологийн аппаратаар хангасан. Нийт 12 сум, 3 өрхийн эрүүл мэндийн төвүүд мобайль технологиор хангагдан үйл ажиллагаандаа ашиглаж байна. | 90 |
| 47 | | 7. Аймгийн Нэгдсэн эмнэлгийг дурангийн мэс заслын тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | 296.5 сая/УТХО/ | | Улсын төсвийн 296,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвлийн хөндийн дурангийн мэс заслын аппарат нийлүүлэгдэж цөсний бүхий л төрлийн хагалгаа, мухар олгойн хагалгаа, өрцний ивэрхий, ивэрхий нөхөх, болон эмэгтэйчүүдийн хагалгаа хийх бүрэн боломжтой болсон. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар чулуутай цөсний хүүдий авах 21 хагалгааг амжилттай хийгээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 48 | | 8. Эрүүл мэндийн байгууллагуудыг яаралтай тусламжийн авто машинаар хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 1.1 тэр бум | 14 | 2022 онд Улсын төсвийн 31,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Уулбаян сумын ЭМТ-д Уаз Пургон автомашин,АНЭ-т ЛАНД -78, Орон нутгийн төсвийн 115,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн нэгдсэн эмнэлэгт Хайсей, Приус-30 маркын 2 автомашин, Дарьганга, Уулбаян сумдын ЭМТ Приус-30 автомашинууд, иргэдийн 44,0 сая төгрөгийн хандиваар Халзан, Түвшинширээ сумдын ЭМТ приус-20 маркын автомашинуудын парк шинэчлэлт хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 6 суманд туулах чадвар сайтай Ланд-76 маркын автомашины тендер шалгаруулалтыг зохион байгуулан Таван богд групп шалгарсан. Дээрхи автомашинууд 12-р сард нийлүүлэгдэнэ. | 100 |
| 49 | 2.2.2. Өсвөр үе, залуучуудыг спортын олон төрлөөр хичээллэж бие бялдраа хөгжүүлэх, спортын амжилт гарах нөхцөлийг бүрдүүлнэ. | 1. Өсвөрийн шигшээ багийг спортын 8 төрлөөр байгуулах | 2021 - 2024 | ЗДМХ 38,0 сая | | 2021 оны А/216 дугаар захирамжаар Өсвөрийн шигшээ багийг спортын 8 төрлөөр засаг даргын ивээл доор байгуулсан. /сагсан бөмбөг, волейбол, шатар, дугуй, жудо бөх, буудлага, үндэсний бөх, хөл бөмбөг/ Спортын тэмцээн уралдаанд амжилт үзүүлсэн өсвөрийн тамирчдад журмын дагуу 3,0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Хөл бөмбөгийн аварга шалгаруулах Зүүн бүсийн 2 тэмцээнд нийт 4,0 сая, МУСМ Ш.Энх-Амарын нэрэмжит уулын дугуйн УАШТ-д 4,0 сая, Өсвөрийн жүдо бөхийн тамирчдын хамтарсан бэлтгэлд 2,0 сая, ОУХМ Н.Ганхуягийн нэрэмжит холимог насны тэмцээнд 10,0 сая, тэмцээн уралдааны дэмжлэгт нийт 20,0 сая төгрөг зарцуулсан. Шигшээ багийн хувцас, хэрэгслийн шинэчлэлд 15,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 100 |
| 50 | | 2. Стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмж, мэргэжлийн чадварлаг багш дасгалжуулагчаар хан гах арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 15 сая /ЗДМХ / | | Өсвөрийн шигшээ багийг дэмжих зорилтыг хангах ажлын хүрээнд жудо, волейбол, сагсан бөмбөгийн спортын төрөлүүдэд 15 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. БТСГ нь шаардлага хангасан мэргэжлийн багш, дасгалжуулагчаар 100 хувь хангагдсан. Уулбаян, Мөнххаан сумд фитнесийн тоног төхөөрөмж авсан ба наран сум сурын спортын клуб байгуулж 5 сая төгрөгийн 8 ширхэг бэлтгэлийн нум авч бэлтгэл сургуулилт хийх нөхцлийг бүрдүүлсэн. | 100 |
| 51 | | 3. Улс, бүсийн чанартай тэмцээн уралдааныг орон нутагтаа зохион байгуулах | 2021 - 2024 | ЗДМХ 18,0 сая | | Усан спортын УАШТ, ОУХМ Н.Ганхуягийн нэрэмжит олон хотын нээлттэй тэмцээн, ОУХМ Ш. Энх-Амарын нэрэмжит Уулын дугуйн УАШТ, Хөл бөмбөгийн насанд хүрэгчдийн Зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн, Хөвгүүдийн цом-2022 бүсийн АШТ, нийт УАШТ 3, бүсийн АШТ 2 зохион байгуулагдсан. АЗДМХ хэрэгжүүлэх зардлаас тус тэмцээнүүдэд нийт 18,00сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 100 |
| 52 | 2.2.3. Нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлнэ. | 2. Стандартын шаардлага хангасан спортын гадаа талбайн тоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | Улсын төсөв ОНХС | | Баруун Урт сумын төвд үндэсний баяр наадам тэмдэглэхээс гадна 400 метрийн 5 замтай гүйлтийн зам, хөл бөмбөгийн ногоон талбай бүхий1800 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн ашиглалтанд орсон. Мөн ХААН банкны хөрөнгө оруулалтаар 3х3 сагсан бөмбөгийн талбай баригдсан. Сүхбаатар, Дарьганга, Эрдэнэцагаан сумдад тус бүр 1, Баяндэлгэр сумано 2 нийт 6 гадаа талбай баригдсан. Аймгийн хэмжээнд спортын гадаа талбай нийт 8 баригдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 53 | | 3. Спортын барилга байгууламжууд шинээр барих | 2021 - 2024 | Спорт цогцолбор: 2022 онд 5,263,0 2023 онд 1,563,0 Цэнгэлдэх хүрээлэн 2,350,0 | | Улсын төсвийн 6,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 700 хүний суудалтай Спорт цогцолборын барилга баригдаж байна. Тус спорт цогцолборын эргэн тойронд 2.1 га талбайд орчны тохижилт, өндөржилт, зай хэмжээ, зам талбайн хучилт, автомашины төлбөртэй зогсоол, ногоожуулалт, цэцэрлэгжүүлэлт, гадаргын ус зайлуулах арга хэмжээний төлөвлөлтийг хийсэн байна. Үндэсний баяр наадам, үндэсний спортын төрлөөр тэмцээн уралдаан зохион байгуулахаас гадна хөнгөн атлетикийн 4 төрлийн стандарт талбай бүхий улсын төсвийн 2,3 тэрбум төгрөгийн 1800 хүний суудалтай цэнгэлдэх хүрээлэн Баруун Урт сумын 8-р багт баригдсан. | 90 |
| 54 | | 4. Нийтийг хамарсан спортын эвент арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | | | Засаг даргын А/96 дугаар захирамжаар “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аяныг бүх сум, ААНБ хэрэгжүүлэх, иргэдийг дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, чөлөөт цагаа өнгөрөөх нөхцөл боломжоор хангахыг үүрэг болгосон. Аяны хугацаанд бүх спорт заал, усан спорт чийрэгжүүлэлтийн төв, фитнес клуб, Соёлын төв иргэдэд заал танхимыг боломжтой байдлаар төлбөргүй ашиглуулсан. БТСГ-ын даргын тушаалаар ажлын хэсэг "Илүүдэл жингүй-Эртэч Монгол" аяныг бүх нийтийн хүртээл болгох, "Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил" авах, "Биеийн жингийн индекс тодорхойлох аргачлал"-ыг сургах, "Олимпийн боловсрол-Бие бялдрын хүмүүжил" болзолт уралдааны галт бамбарыг аялуулах зэрэг ажлаар 13 суманд ажилласан. Сум, байгууллагууд гүйлт, алхалт, дасгал хөдөлгөөн, нийтийн бүжиг, тэмцээн уралдаан зэрэг арга хэмжээнүүдийг өөр өөрийн онцлог байдалтай зохион байгуулсан. Засаг даргын А/236 дугаар захирамжийн дагуу "Эрүүл мэндийнхээ төлөө-Алхангаа ярилцья" аяныг зохион байгуулж, эрүүл идэвхитэй хөдөлгөөн, амьдралын зөв хэмнэлд уриалсан арга хэмжээнүүдийг сум, байгууллага бүр өөрийн онцлог, нөхцөл боломжид тулгуурлан зохион байгуулсан. Аяны хүрээнд идэвхитэй хөдөлгөөн, алхалтын ач холбогдлыг сурталчлах, хэвшил болгох сургалт сурталчилгаа нөлөөллийн ажил, алхалтыг төрөл бүрийн сонирхолтой байдлаар зохион байгуулах, насны онцлогт тохирсон хөдөлгөөн дасгалуудыг зааж сургах зэрэг ажил арга хэмжээнүүд зохиогдсон. Арга хэмжээний хүрээнд Нийтийн бүжгийн холбоо, Эртэч клуб, фитнес клуб зэрэг клуб холбоодтой хамтран ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч иргэдийн хамрагдалтын нэмэгдүүлэх талаар хамтран ажилласан. арга хэмжээний талаарх мэдээллийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын цахим хуудас, орон нутгийн телевиз зэргээр тогмол сурталчилан иргэдэд мэдээлж ажилласан. | |
| 55 | | 5. Засаг даргын нэрэмжит тэмцээн, уралдаан зохион байгуулах | 2021 - 2024 | 10 сая АЗДМХ | | Аймгийн Засаг даргын нэрэмжит “Ахмад-2022” спортын олон төрөлт тэмцээн шатар, ширээний теннис, дартс, софьт волейбол, граунд гольф, хавчаахай харваа, шугаман бүжиг зэрэг төрлүүдээр зохион байгуулагдсан. Наадамд 13 сумын 15 багийн 300 гаруй тамирчид амжилттай оролцож Тэргүүн байр: Баруун-Урт сум Дэд байр: Эрдэнэцагаан сум Гутгаар байр: Халзан сум Тусгай байр: Уулбаян сум тус тус шалгарсан. Аймгийн Засаг дарга аймгийн боксын холбоотой хамтран ОУХМ Б.Ганхуягийн нэрэмжит боксын Зүүн бүсийн нээлттэй олон хотын тэмцээнийг зохион байгуулсан. | 100 |
| 56 | 2.3.1. Хүүхэд бүрийн цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлж, чанартай боловсрол олгоно. | 1. Наран суманд 100, Дарьганга 150, Баруун-Урт хот, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Онгон, Уулбаян суманд 200 хүүхдийн шинэ цэцэрлэг барьж, Баруун-Урт сумын 7-р цэцэрлэгийн барилгын асуудлыг шийдвэрлэх | 2021 - 2024 | Улсын төсвийн хөрөнгөөр Дарьганга 1600,0 сая, Наран 160,0 сая, Баруун-Урт сум 200 хүүхдийн цэцэрлэг 2100,0 сая нийт 3860,0 сая төгрөг зарцуулсан. | 2 | Улсын төсвийн хөрөнгөөр Дарганга суманд шинээр 150 хүүхдийн 1,977.3 төгрөгийн өртөгтэй цэцэрлэгийн барилгын ажил 60 , Наран 1,898.9 төгрөгийн өртөгтэй барилгын ажил 7,5 гүйцэтгэлээр 2022 онд хийж гүйцэтгэх ажил 100 хувь хийгдсэн . Баруун-Урт сумын 200 хүүхдийн цэцэрлэг 2020 онд ашиглалтанд орж , Эрдэнэцагаан, Баяндэлгэр сумын 200 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгчтэй байгуулах гэрээ цуцлагдаж шинээр хийгдэхээр төлөвлөлтөд орж, 2024 онд улсын төсөвт хөрөнгийг суулгахаар дүгнэлт гаргах ажлын хэсэг ажиллаж байна. | 70 |
| 57 | | 2. Эрдэнэцагаан сумын 2-р , Баруун-Урт хотын 4, 9-р цэцэрлэгт их засвар хийж, | 2021 - 2024 | Олон улсын төсөл 628,9 сая | 1 | Баруун-Урт сумын 4-р цэцэрлэгийн барилгын их засварын ажлын ЯУЭСЯ Өвсний Үндэс хөтөлбөрийн санхүүжилтээр 2021 онд 628,9 сая төгрөгөөр хийж ашиглалтанд оруулсан. Баруун-Урт сумын 9-р , Эрдэнэцагаан сумын 2-р цэцэрлэгт засварын ажлын зураг төсвийн ажил хийгдэж байна. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Баруун-Урт хотын 5-р цэцэрлэгийг өргөтгөх | | | | | |
| 58 | | 3. Цэцэрлэгийн хүүхдүүдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангалт хийх | 2021 - 2024 | 240,0 сая - орон нутаг | 24 | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 24 цэцэрлэгийн 48 ангийг 240,0 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн тоглоом наадгайгаар хангасан. Мөн АИХ, АЗД-ын нөөцөөс 70,0 сая төгрөгийн гадаад талбайн тоглоом болон гэрэлтүүлэг, ОНХСангийн 161,3 сая төгрөгийн дэмжлэгээр Баруун-Урт сумын 1,6,8,9,10, Дарьганга, Мөнххаан, Онгон, Түвшинширээ, Эрдэнэцагаан сумдын цэцэрлэг гадна пасад, дээврийн засвар, тоног төхөөрөмж, тоглоом наадгай, тавилга, зөөлөн эдлэл зэрэгт шинэчлэл хийсэн. Эцэг эх, иргэд, байгууллагын хандив тусламжаар 31,2 сая төгрөгийн тоглоом наадгайг авч сургалтын орчныг бүрдүүлсэн | 100 |
| 59 | 2.3.2. "Чадварлаг багш арга хэмжээний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлнэ. | 1. "Залуу багш" хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 5 | 100 | Багш мэргэжлээр төгсөөд 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарт зориулан “ЗАЛУУ БАГШ” хөтөлбөрийг Боловсролын хамтын ажиллагаатай хамтран хэрэгжүүлж, 2021 онд 105 багш, 2022 онд 100 багшийг хамруулж, мэргэжлийн болон арга зүйн дэмжлэгийг үзүүлж байна. Энэ хичээлийн жилд ЕБС, СӨБ-ын багш нарын 50 хувь нь 1-5 дахь жилдээ ажиллаж байна. Сургалтаар залуу багш нар багшлах ур чадвараа дээшлүүлэхийн зэрэгцээ шилдэг арга туршлагаа үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх боломж бүрдэж байгаа юм. | 100 |
| 60 | | 2. “ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХ СҮХБААТАРЧУУД ТӨСӨЛ, “10:10” арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2022 | 5.4 | 100 | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 45 -р тогтоолоор “Дэлхийд өрсөлдөх Сүхбаатарчууд” хөтөлбөрийг батлуулан dагш, суралцагчид, хүүхэд залуучууд, иргэдийн англи хэлний боловсролыг сайжруулан улсын хэмжээнд өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх зорилгоор АНУ-ын ETS (Educational Testting Service) байгууллага, CELPA (Commissionon English Language Program Accreditation)- “Англи хэлний хөтөлбөрийг магадлан итгэмжлэх холбоо” –той хамтран 10 багш 100 сурагчдад зуны вакум сургалт, англи хэлний багш нарыг цахим болон танхимаар ETC байгууллагын хөтөлбөрөөр олон улсын шалгуурт нийцсэн сургалтад хамруулсанаар АНУ-ын ЭСЯ-ны хөтөлбөрт гадаад хэлний БШУГ TOEFL ITP шалгалтыг орон нутагт зохион байгуулах эрхтэй болсон нь бидний үр дүн юм. Гадаад хэлний 10 багш "Сурагчдыг олон улсын шалгалтад яаж бэлдэх" талаарх сургалтад бүрэн хамрагдаж, Баруун-Урт, Түмэнцогт, Түвшинширээ, Мөнххаан сумдын 10 багш 6-12-р ангийн 100 сурагчдыг хамруулж, 36 цагийн нэмэлт агуулгыг 2 сарын турш гүнзгийрүүлэн судалсан бөгөөд 1 багш 10 сурагчтай ажиллаж IELTS, TOEFL-ийн шалгалтанд тэнцүүлэх, ЭЕШ, улс бүс, олон улсын олимпиад уралдаан тэмцээнд өрсөлдөхүйц хэмжээний англи хэлний мэдлэгийг олгох юм. тус зорилтын хүрээнд 2021-2022 онд 100 хүүхдийн сургалт амжилттай зохион байгуулагдан суралцагчид 1-р шатны шалгалтаа амжилттай өгч, 2-р шатны шалгалт хөрөнгөөс шалтгаалан түр хугацаагаар хойшлогдож хүлээлттэй байна. Англи хэлний сургалтын үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга 5,390,0 сая төгрөгийн дэмжлэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үзүүлсэн. Багш нарын мэргэжлийн ур чадварыг дэмжих зорилгоор TOEFL ITP шалгалтыг орон нутгийн түвшинд зохион байгуулж 25 багш хамрагдаж Европын хүрээний түвшинг харьцуулж оноог бодож танилцуулсан. -CELPA олон улсын байгууллагатай хамтарсан төслийн нээлтийг зохион байгуулж, 9 сургагч багш бэлтгэх сургалт болон 88 сурагч TOEFL junior шалгалт өгсөн. Сургагч багш нар 45 хоногийн сургалт зохион байгуулсан , сурагчдын ирц 80 хувьтай хамрагдсан. | |
| 61 | | 3. Шаардлагатай мэргэжлээр зөвлөх, зочин, ментор багш ажиллуулж, багш солилцоо хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахмад багш нарын зөвлөгөөн зохион байгуулах | 2021 - 2024 | 0 | багшийн тоо 10<br>багш солилцоонд 30<br>ахмад багш нарын зөвлөгөөн 1 | "Сүхбаатар аймгийн хэлний бодлогын зөвлөлд МУГБ Ш.Чулуунбор, Ахмад багш Ш.Борчулуун, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт Наран сумын Монгол хэлний ахмад багш Х.Сарантуяа хичээлийн хоцрогдлыг арилгаж, агуулга нөхөх чиглэлээр багш сурагчдад зөвлөн туслах төсөл бичин дэмжигдэж хичээлийн шинэ жилээс хэрэгжиж эхлэх бэлтгэлээ хангаж байна. Онгон, Асгат сумдаас Математик, Газарзүй, Монгол хэл хичээлүүдээр 4 ахмад багштай хамтран зөвлө х үйлчилгээг үзүүлсэн. Сүхбаатар аймгийн төгсөгчдийн холбоо “Сүхбаатар - Нэг мөрөөдөл” ТББ –аас ахмад багш М.Эрдэнийг цалинжуулж ЭЕШ өгөх төгсөх ангийн сурагчдад үнэ төлбөргүй давтлага өгсөн нийт 3 багш зөвлөх үйлчилгээгээр ажиллаж, 5 багш ажиллах бэлтгэлээ хангасан.Технологийн багш Эрдэнэтуяа нь Халзан сумын ЕБС-д цахим хэлбэрээр сурагчдад хичээл зааж хамтран ажиллаж байна. Мөн Мэдээллийн технологийн багш дутагдалтай газруудад туршлагатай багш цахим хэлбэрээр хичээл заах ажлыг амжилттай хэрэгжүүлсэн. | 90 |
| 62 | | 4. Сурагчдын сэтгэн бодох өөрийгөө илэрхийлэх, зөв цэгцтэй ярих чадварыг хөгжүүлэх, илтгэх урлаг, мэтгэлцээний аймгийн сургагч багш нарыг бэлтгэх, энэ чиглэлээр клуб, дугуйлан хичээллүүлж , тэмцээн зохион байгуулах | 2021 - 2024 | 0 | 32 багш<br>320 сураг | 2022 - 2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 16 сургуульд 5421, 24 цэцэрлэгт 5529 нийт 10950 суралцагч хичээллэж буй хараа, орон зай, Хэл, өгүүлэхүйн, Хөдөлгөөн, тэнцвэр, Хэмнэл, сонсгол, Логик, харилцааны мэдрэмжид суурилсан авьяас сэтгэхүйг хөгжүүлэх 5 чиглэлийн 352 төрлийн секц дугуйлан клубыг нийт 26 иргэн, 389 багш удирдан чиглүүлж ажилласан. Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагын 88 клубд 1693 хүүхэд хамрагдаж авьяас чадвараа хөгжүүлж байна. Аймгийн хэмжээнд сургуулиас гадуур иргэдийн хичээллүүлж буй Уран зураг, Оюун ухааны академи, спортын бүжиг, спорт өрөлт, монгол бичиг, англи хэл, төгөлдөр хуур, морин хуур, шатар, гитар, дуу бүжгийн 16 төрлийн дугуйлан, секц, сургалтын төвд нийт 574 хүүхэд хамрагдан суралцаж байна. | 90 |
| 63 | | 5. Орон нутгийн түүх соёлын дурсгалыг судалж хамгаалахад багш нарын оролцоог хангаж, археологийн, болон түүх соёлын дурсгалыг таних, | 2021 - 2024 | 0 | зохион байгуулсан арга хэмжээний тоо 4 | 2022-2023 оны хичээлийн жилд 3 сургууль, 7 цэцэрлэг, МСҮТ эко сургууль болох төсөлд хамрагдан орон нутгийн түүх соелын дурсгал , дурсгалт газрыг судалж эх түүх, байгаль орчин, ан амьтанаа хайрлах, хамгаалах чиглэлээр Музейн аялал, хээрийн аялал экскурс , Янзаган хүрээг хайрлаарай уриан дор цагаан зээрийг хамгаалах үйл ажиллагааг сумдын байгаль орчины мэргэжилтэнүүдтэй хамтран зохион байгуулсан. Хилийн цэргийн ангиудтай хамтран ахлах ангийн | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | илрүүлэх сургалт, экскурс аялал зохион байгуулах | | | | сурагчдыг хил хамгаалах ангитай танилцуулсан. нийт 3928 сурагч дээрх үйл ажиллагаанд хамрагдаж оролцсон. Ж.Эрдэнэцогт ахлагчтай СГЗ Г.Аким, .ГБадамсамбуу , С.Амартайван, тэргүүтэй эрдэмтэн судлаачид “Хатгины уг сурвалж, үр сад” анхдугаар аялалтыг эхлүүлэн Сүхбаатар, Эрдэнэцагаан, аймгийн төвийн 4 сургуулийн сурагчид, түүх нийгмийн ухааны багш нарыг оролцуулан түүх, ёс заншлын талаар сургалт зохион байгуулж мэдээлэл хүргэсэн. | |
| 64 | | 6. Байгалийн ухааны хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, багш нарыг чадваржуулах зорилгоор Шинэ-Монгол сургуультай хамтран ажиллах | 2021 - 2024 | 0 | хамрагдсан багшийн тоо 44 | “ТӨРИЙН ӨМЧИЙН СУРГУУЛИУДЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ” төсөлд Баруун-Урт сумын 2-р сургууль хамрагдаж , 2022 онд удирдах 5, багш 57, нийт 63 хүн 12 төслийн тайлан танилцуулж , 28 хүн 4 чиглэлээр туршлага судлах үйл ажиллагаанд оролцсон. 2022 онд Байгалийн ухааны хичээлүүдийн үйл ажиллагаа, багийн ажил, зохион байгуулалт, ЭЕШ-ын бэлтгэл, хөтөлбөр төлөвлөлт гэсэн агуулгуудаар 3 удаагийн сургалтыг Шинэ Монгол Эрдмийн хүрээлэнгээс зохион байгуулсан. Байгалийн ухааны багш нарыг чадвахжуулах ажлын хүрээнд Шинэ Монгол сургуультай хамтран ажиллаж багш нарт 4 хичээлээр 2 өдрийн танхимын сургалт, сурагч сурагчиддаа 5 хичээлээр 7 хоног бүр 12-р ангийн суралцагчдыг оролцуулан сургалт үйл ажиллагааг цахимаар зохион байгуулсан. | 70 |
| 65 | | 7. Гадаад улс оронд мэргэжил дээшлүүлэх сургалт, зөвлөгөөн, туршлага судлахад багш, боловсролын ажилтнуудад дэмжлэг үзүүлнэ | 2021 - 2024 | 0 | 4 | АНУ-ын ЭСЯ-ны хөтөлбөрт хамрагдаж TESOL Methodoldogy цахим сургалт/МООС/-д гадаад хэлний 25 багш танхим болон цахимаар хамрагдаж сертификат авсан. * БШУГ-ын түүх нийгмийн ухааны боловсрол хариуцсан мэргэжилтэн А.Алтаншагай тэтгэлгээр Солонгос улсад, 2 дугаар сургуулийн англи хэлний багш Э.Болор АНУ-ын засгийн газрын тэтгэлэгт TEA хөтөлбөрт хамрагдаж 45 хоног мэргэжил дээшлүүлэх сургалтад суралцаад ирсэн. * Наран сумын Сургалтын менежер Н.Хонгорзул APCEIU - аас зохион байгуулдаг олон улсын багш солилцооны хөтөлбөрийн 10 жилийн ойн хуралд төлөөлөгчөөр уригдан , багш солилцооны хөтөлбөрийн сайн туршлага илтгэлээр оролцохоор болсон.Филипин улсад англи хэлний эрчимжүүлсэн 1 сарын сургалт, Эрдэнэцагаан сумын Физизийн багш Э.Ойдов Япон улсад мэргэжлээрээ Магистрт тус тус суралцсан. мөн Наран , 3-р сургуулийн багш нар Өмнөд солонгос улсын сургуулийн сурагчдад цахимаар хичээл зааж олон улсад туршлагаа хуваалцсан. | 100 |
| 66 | | 8. Сумдын сургуулиуд болон Насан туршийн боловсрол төвийг мэргэжлийн багшаар хангах | 2021 - 2024 | 0 | мэргэжлийн багшийн хангалтын тоо 12 | НТБТ нь 23 багш ажилтан ажиллаж байгаа бөгөөд 2022-2023 оны хичээлийн жилд Мөнххаан суманд 1 багш шинээр томилогдон ажиллаж байна. НТБТ-ийн багш нараас заах аргач зэрэгтэй 3, тэргүүлэх зэрэгтэй 2, ахлах зэрэгтэй 1 багш нэмэгдүүлэн багшийг мэргэшүүлж байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 67 | | 9. Мэдээлэл зүйн багш нарын чадавхыг дээшлүүлж, боловсролын салбарын нэгдсэн системийг бий болгон, багшид шаардлагатай мэдээлэл, харилцааны технологийн тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 0 | сургалтын тоо 1 | Ерөнхий боловсролын 12 сургуулийн 14 мэдээллийн технологийн багш нарт мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор С++ програмчлалын хэлний массив , хэрэглэгчийн функц сэдвээр цахим сургалтыг зохион байгуулсан. Бага боловсролын багш, мэдээллийн технологийн багш нарт интерактив хичээл бэлтгэх adobe cartivite 2019 программ болон хэрэглээний программууд болох M5 Excel MsPowerPnt, "Цахим сайт ашиглан үр дүнтэй цахим хичээл бэлтгэх" сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Нийт 3 удаагийн сургалтад 128 багш хамруулсан | 100 |
| 68 | 2.3.3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын хангамжийг нэмэгдүүлнэ. | 1. Баруун-Урт хотод шинээр баригдаж байгаа 960 хүүхдийн сургуулийг ашиглалтад оруулж, 3-р сургуулийн барилгын асуудлыг шийдвэрлэх | 2022 - 2024 | 9,993. 3 сая төгрөг улсын төсвийн хөрөнгө | 1 | Баруун-Урт суманд улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд 960 хүүхдийн сургууль шинээр баригдаж 2023 онд ашиглалтанд оруулахаар барилгын ажил хийгдэж байна. Баруун-Урт сумын 3-р сургуулийн барилгыг шинээр баригдаж байгаа 960 хүүхдийн сургуулийн барилгад шилжүүлэхээр аймгийн Засаг даргын орлогчийн 2020.12.07 2б/1163 тоот албан бичгээр мэдэгдэн бэлтгэл ажил хийгдэж байна. | 70 |
| 69 | | 2. Баруун-Урт хотын 1, 3, 4-р, Эрдэнэцагаан сумын 1-р, Халзан, Уулбаян сумын ЕБС-ийн "Б" байрны барилгад урсгал засвар хийх | 2021 - 2024 | 0 | 2 | Баруун-Урт сумын 1-р сургуулийн барилгын их засварын ажлын зураг төсвийг орон нутгийн 91,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Мөн Уулбаян сумын сургуулийн их засварын ажлыг ЯУЭС яам өвсний үндэс хөтөлбөрийн санхүүжилтээр хийхээр санхүүжилтйг гэрээнд гарын үсэг зурсан. Баруун--Урт сумын 3-р сургуулийг 960 хүүхдийн шинэ сургуулийн барилга ашиглалтад ороход шилжүүлэхээр шийдвэр гаргасан. | 70 |
| 70 | | 3. Баруун-Урт хотын 2-р сургуулийн урлагийн заалны өргөтгөл, Баяндэлгэр сумын 320, Мөнххаан, Түвшинширээ сумын 240 хүүхдийн сургуулийн барилгыг өргөтгөх | 2021 - 2024 | | ТШ өргөтгөл 1 | Баруун-Урт сумын 2-р сургуулийн урлаг заалын барилга улсын төсвийн 746,4 сая төгрөгийн хөрөнгөөр баригдаж ашиглалтад оруулсан. | 100 |
| 71 | | 4. Халзан, Баяндэлгэр сумдад шинэ дотуур байр барьж, Дарьганга, Мөнххаан, Түвшинширээ сумдын сургуулийн дотуур байранд их засвар хийх | 2022 - 2024 | | Дарьганга 1 | Халзан суманд 50 хүүхдийн дотуур байр барих зураг төсвийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд улсын төсвийн хөрөнгөөр 2022-2023 онд 2,9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр Түвшинширээ сумын ЕБС-ийн 100 ортой дотуур байрын барилгын ажил хийгдэж эхэлсэн. Мөнххаан суманд ЕБС-ийн дотуур байрны дээврийн их засварын ажлын тендерийг зарлаж тендерт “Хүрэл соёмбо ХХК” шалгарч дотуур байрны дээврийн их засварын ажлыг хийж гүйцэтгэн 2022 оны 10 сард хүлээлгэн өгсөн. Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалт 60000,0 төгрөгийн санхүүжилтээр дээврийн засварын ажлыг гүйцэтгэсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Түвшинширээ суманд УТХО-аар шинээр дотуур байр баригдаж эхэлсэн учир их засварын ажлыг цуцласан. | |
| 72 | | 5. Хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг байгуулах санал, санаачилгыг дэмжих | 2021 - 2024 | | | Одоогоор хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг байгуулах санал ирээгүй байна. | ҮБ-гүй |
| 73 | 2.3.4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно. | 1. Баяндэлгэр, Мөнххаан, Дарьганга сумын сургууль, Түвшинширээ сумын хичээлийн 2-р байр, Халзан, Наран сумын ЕБС-уудыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох | 2021 - 2024 | 1000,0 | 2 | Халзан , Наран сумын ЕБС-иуд орчин үеийн ариун цэврийн байгууламжийг ашиглалтад оруулсан. Эрдэнэт ТӨҮГ-ийн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлж байгаа ЕБС, цэцэрлэгийг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох төслийн 1, 2-р ээлжийн төслүүд ашиглалтанд орж, 3-р ээлжийн төсөлд 4 ЕБС /Баяндэлгэр, Мөнххаан, Түвшинширээ, Уулбаян/ , 4-р ээлжийн төсөлд 4 сургууль /Дарьганга, Сүхбаатар, түмэнцогт, Эрдэнэцагаан / орчин үеийн АЦБ болгохоор ажиллаж байна. 3,4-р ээлжинд хийгдэх төслийн зураг төслийн ажлыг хийх худалдан авах ажиллагаа зарлагдаж гүйцэтгэгч ХХК иуд тодроогүй байна. Дотуур байрын хувьд Эрдэнэцагаан, Наран, Халзан сумын дотуур байр орчин үеийн АЦБ -тай болсон. 3-р ээлжинд 5, 4-р ээлжинд 2 дотуур байранд төсөл хэрэгжинэ. | 100 |
| 74 | | 2. Наран, Уулбаян, Дарьганга, Онгон болон Эрдэнэцагааны 1,2-р цэцэрлэгийг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох | 2022 - 2024 | | 0 | аймгийн хэмжээнд 9 цэцэрлэг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болох төсөлд хамрагдаж байгаа бөгөөд 3,4-р ээлжинд хамрагдахаар зураг төслийн ажлын худалдан авах ажиллагаа зарлагдан гүйцэтгэгч тодроогүй байна. | 70 |
| 75 | | 4. Уулбаян, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Наран, Түвшинширээ сумдын сургуулийн дотуур байранд камержуулалт хийх | 2021 - 2024 | | 80 | Уулбаян , Наран, Эрдэнэцагаан , Баяндэлгэр сумын сургуулийн дотуур байр 2021 онд орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалтаар 29 камер шинээр тавьж бүрэн камержуулсан. Түвшинширээ суманд дотуур байр шинээр барихтай холбоотойгоор камержуулалтыг хийгээгүй. | 100 |
| 76 | 2.3.5. "Үдийн цай" арга хэмжээг "Үдийн хоол" болгож, сургууль, дотуур байр, цэцэрлэгийг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана. | 1. 13 сургууль, 12 дотуур байр, 24 цэцэрлэгийг ус цэвэршүүлэгчтэй болгох | 2021 - 2024 | сумын ОНХС | 15 | Аймгийн Засаг даргын сумын Засаг даргатай байгуулсан 2022 оны гэрээнд тусгаж сумын Засаг дарга нар үүрэг хүлээн хэрэгжүүлэхээр тусгагдан хэрэгжүүлсэн. Тус ажлын хүрээнд 2022 онд Түмэнцогт сумын Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангаас 2,4 сая төгрөгийн санхүүжилтээр хүүхдийн цэцэрлэгтээ 3ш ус цэвэргүүлэгч, Халзан сумын цэцэрлэг гал тогооны эх үүсвэр дээр ус шүүгч байрлуулж , нийт гал тогооны усны эх үүсвэр дээр ус шүүгч байрлуулсан 7 цэцэрлэг байна. Үүнд: Мөнххаан, Халзан, 1,4,6,7, 11-р / Сүхбаатар сумын ЕБС гал тогооны эх үүсвэр дээрээ ус шүүгчтэй /. Мөн Баруун-Урт сумын тамгын газраас төвийн 11 цэцэрлэгийг ус шүүх цэвэршүүлэгчээр хангасан. одоогоор Нийт 6 сургууль, 2 дотуур байр, 13 цэцэрлэг гал тогооны цорго болон ундны усны эх үүсвэр дээр ус | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цэвэршүүлэгч байршуулан цэвэршүүлсэн усаар суралцагсдад үйлчилж байна. Сургууль, цэцэрлэгүүд өөрсдийн хөрөнгөөр болон эцэг эхийн дэмжлэгээр ус уух нөхцлийг бүрдүүлж анги бүрт баллонтой цэвэр усыг хэрэглэж байна. Мобикомоос Баруун-Урт сумын Нэгдсэн дотуур байранд 3ш ус шүүгчийн дэмжлэг үзүүлсэн. 2022-2023 оны хичээлийн жилд 1-5 ангийн 231 бүлгийн 7155 сурагчдыг “Үдийн хоол ” хөтөлбөрт 100 хамруулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг “Үдийн хоол” болгох ажлын хүрээнд БШУЯ-наас сургууль, цэцэрлэг, дотуур байрын хоол үйлдэвэрлэл үйчилгээний ажилчдад зохион байгуулсан цахим сургалтад эмч – 17, нярав – 41, тогооч – 141, БСУГ –ын мэргэжилтэн -2, нийт 201 ажилтан албан хаагчид хамрагдаж, хоолны технололгийн карт боловсруулах, хоолны илчлэг тооцох, хоол үйлдвэрлэлийн цахим систем ашиглах зэрэг аргад суралцлаа. | |
| 77 | 2.3.6. Сургууль, цэцэрлэгийг сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмжөөр хангаж, боловсролын чанарт ахиц гаргана. | 1. Баруун-Урт хотын 2, 4-р сургууль, мөн хотын 6, 9, 11-р, Онгон сумын цэцэрлэгүүдэд стандартын шаардлага хангасан биеийн тамирын талбай байгуулах | 2021 - 2024 | хувийн хөрөнгө оруулалт | 2 | Аймгийн Засаг даргын сумын Засаг даргатай байгуулсан гэрээнд шинэ биеийн тамирын талбай барих зураг төсвийг хийх ажлыг тусгасан. Хүлээгдэж байна. 4-р сургуульд төгсөгчдийн Хаан банкны санхүүжилт санаачлагаар 4х4 сагсны талбайг хийж хүлээлгэн өгсөн. Үр дүн: Дулааны улиралд Баруун-Урт сумын өсвөр үе залуучууд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх, сагсан бөмбөгийн спортоор хичээллэх, бие бялдраа хөгжүүлэх орчин нөхцөл бүрдлээ. * БУЗДТГ-аас Баруун-Урт хотын 2 сургууль, 6, 9, 11-р цэцэрлэгт биеийн тамирын талбай байгуулах зураг төсвийг хийсэн, 2022 оны ажил 100 , Онгон сумын цэцэрлэгийн талбай хугацаа болоогүй | 70 |
| 78 | | 3. ЕБС-д лаборатори байгуулж, виртуал орчин бүрдүүлэн, дижитал технологи ашиглах боломжийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 320,0 сая | 16 | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 16 ерөнхий боловсролын сургуульд сургалтын лаборатори байгуулах ажлыг 320,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Үүнд англи хэлний лаборатори 1ш, мэдээлэл зүйн кабинет 8ш, дизайн технологийн кабинет 1ш, биологи, химийн кабинетуудын тоног төхөөрөмж тус бүр 3,3 сургууль дээр байгуулагдсан. Аймгийн Засаг даргын захирамжаар Баруун-Урт сумын 1-р сургуульд сурагчийн ширээ сандал 12,0 сая, 10-р цэцэрлэгт 6,2 сая төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжөөр хангасан. Дизирит олон улсын байгууллагын 10,0 сая төгрөгөөр Эрдэнэцагаан сумын ЕБС-ийн 1 ангийн тохижилт ширээ сандалыг шинэчилсэн. Мөн БШУЯ-ны санхүүжилтаар БШУГ, лаборатори 1-р сургуульд 38 сая төгрөгийн "Цахим контент боловсруулах лаборатори" байгуулсан. | 100 |
| 79 | 2.3.7. Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | 1. Төрийн албан хаагчдад монгол бичгийн сургалт явуулж, “Хүмүүн бичиг-Хүн бүрийн бичиг” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | 4600,000 төгрөг | ТАХ too 40<br>фонд - 14 | Үндэсний бичиг соёлын өдрийг тохиолдуулан 5 дахь жилдээ зохион байгуулж буй “ХҮМҮҮН БИЧИГ-ХҮН БҮРИЙН БИЧИГ” -2022 тэмцээнд 8 багийн 40 албан хаагч өрсөлдсөнөөс Баруун-Урт сумын 1-р сургууль 1-р байр, Нийгмийн даатгал 2-р байр, Ус цаг уур орчны шинжилгээний газар 3-р байр, “Сайхан бичигтэн” төрөлд Баруун-Урт сумын 1-р сургуулийн “Тэнгэрийн зурлага” багийн гишүүн хөгжмийн багш Э.Янжиндулам шалгарлаа. “Жаахан шаргын нутаг” уралдаанд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 56 байгууллага, 645 албан хаагч, иргэн багш, суралцагч нар оролцлоо. Үндэсний бичиг соёлын өдрийг тохиолдуулан аймгийн хэлний бодлогын зөвлөлөөс бүх суманд “Титэм арт” академийн санаачилгаар Нутгийн зохиолчдын уран бүтээлийг сурталчилан таниулах, монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор “Жаахан шаргын нутаг” уралдааныг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдсан. Энэ жилийн онцлог нь төр нийгмийн зүтгэлтэн О.Дашбалбарын бүтээлийг сурталчилан таниулж 24 байгууллагын 248 албан хаагч, 308 сурагч, 36 мэргэжлийн багш, 23 иргэн нийт 600 оролцогч хамрагдаж , орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр иргэдэд сурталчилсан. | |
| 80 | | 2. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн албан хэрэг хөтлөлтийг Монгол хэл, бичгээр хөтлөх бэлтгэл ажлыг хангуулах | 2022 - 2024 | | фонд 14 | Аймгийн архивын тасаг Архивын ерөнхий газрын зөвшөөрлын дагуу аймгийн Засаг даргын тамгын газар хэвлэмэл хуудасаа хэвлэж албан хэргээ монгол бичгээр хөтлөх туршилтыг ажлыг 2022 оны 11 дүгээр сард эхлүүлсэн. | 70 |
| | | | | | | Аймгийн хэмжээнд нийт 16 агентлаг, байгууллага монгол бичгийн фонд суулгаж хэвлэмэл хуудастай болж албан хэргээ хос бичгээр бичих туршилтын ажлаа туршиж байна. | |
| | | | | | | 16 сургууль, 24 цэцэрлэгт CMs Ulaanbaatar, CMs Urga, huree зэрэг программыг компьютерт суулган монгол бичгээр хослуулсан бичих бэлтгэлийг хангасан | |
| 81 | | 3. Албан байгууллага, аж ахуйн нэгж болон нийтийн эзэмшлийн талбай, гудамжны хаягийг монгол бичгээр бичиж байрлуулах | 2021 - 2024 | 170,0 сая | хаяг шинэчилсэн байгууллагын эзлэх хувь 45 | Аймгийн Засаг дарга 14 байгууллагад 170,0 сая төгрөгийн гадна гэрэлтүүлэг , гэрлэн хаягийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч 30 байгууллагаас 19 , 13 сумын төсөвт 78 байгууллагаас 53 байгууллага гадна хаягаа монгол бичгээр бичиж байрлуулсан. Нийт байгууллагын хаягжилтын хувь 65,5 | 100 |
| | | | | | | 2022 онд шинээр 79 аж ахуйн нэгж монгол бичгэн гэрлэн хаягийг шинээр хийж хэрэгжүүлсэн. Баруун-Урт суманд 4 гудамжны нэрийг Үндэсний бичиг крилл, англи хэлээр хослуулан бичиж байрлуулсан | |
| 82 | | 4. Монгол хэл, бичгийг гадаад, дотоодод түгээн дэлгэрүүлж байгаа байгууллага, багш, сурагчдыг урамшуулах | 2021 - 2024 | 5,6 сая | | Аймгийн Засаг даргын 2021 оны А/381 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралтаар “Монгол хэл, бичгийг дээдлэгч сум, байгууллага, иргэн, мэргэжлийн багш урамшуулах журам” -ыг батлуулан хэрэгжүүлж эхний жилийн шалгаруулалтаа хийсэн. Шалгуур үзүүлэлтийн дагуу Монгол хэл, бичгийг дээдлэгч сумаар Баяндэлгэр сум 80 хувийн гүйцэтгэлээр шалгарч 2,0 сая төгрөгийн урамшуулал олголоо. Монгол хэл бичгийг дээдлэгч иргэнээр Түмэнцогт сумын иргэн Ц.Одон, монгол хэл бичгийг дээдлэгч багшаар Баруун-Урт сумын 1-р сургуулийн багш Э.Уранцэцэг нарыг урамшууллаа. Шалгаруулалтыг аймгийн хэлний бодлогын зөвлөл шалгаруулсан. - Үндэсний бичиг соёлын баярын өдрүүдэд Монгол улсын соёлын элч Титэм арт академийн тэргүүн, урлаг судлалын ухааны доктор, уран бичээч Э.Ариунболд “ Монголын эзэнт гүрний Их Хаадын захидлууд” үзэсгэлэнгээ анх удаагаа төрсөн нутгийн түмэн олноо толилуулж ард иргэдэд сурталчиллаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 83 | | 5. Монгол хэлний хичээлээр анги нийтийн сургалтын чанарыг сайжруулан, массын олимпиадыг Засаг даргын ивээл дор зохион байгуулах | 2022 - 2024 | | Монгол хэлний сургалтын чанарын үзүүлэлт 40 | Монгол хэлний хичээлээр анги нийтийн сургалтын чанарыг сайжруулах зорилгоор Монгол хэл, монгол бичгийн хичээлийн нэгдмэл агуулгаар 7 төрлийн блюпринт, даалгавар боловсруулж 6-12-р ангийн 235 бүлгийн 6629 сурагчдад Гараааны үнэлгээ хийж , хоцрогдолтой агуулгыг тодорхойлон, багш, сурагчдыг хөгжүүлж, чадваржуулах ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилт, ахиц үр дүнг тооцсон. 12-р сард ахицын үнэлгээ хийгдэж , ахиц гаргасан анги бүлэг , багш нарыг урамшуулна.<br>Монгол хэлний сургалтын чанарын үзүүлэлт бага боловсрол 51 дунд анги - 58,2 , нийт дундаж үнэлгээ 54,6 | 90 |
| 84 | 2.3.8. Насан туршийн боловсрол төвөөр дамжуулан олгох сургалтын чанар, хүртээмжийг сайжруулна. | 1. Цахим сургалтын хөтөлбөр, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлж, цахим танхим байгуулах | 2021 - 2024 | 0 | 0 | БШУ яамны захиалгаар Азийн хөгжлийн банкны 18,9 сая төгрөгийн санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэдээллийн төв байгуулагдсан. | 100 |
| 85 | | 2. Зорилтот бүлгийн иргэдэд суурь боловсрол олгож, шаталсан сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | | суралцагчийн тоо 200 | Иргэн бүрийн ялгаатай хэрэгцээнд тохирсон боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх, технологийн дэвшилд суурилан тасралтгүй хөгжлийг дэмжих сургалт, олон талт арга хэмжээг Насан туршийн боловсролын үндсэн чиглэлийн агуулгын хүрээнд зохион байгуулан ажиллаж байна. 2022 онд нийт 211 сургалтад 7135 иргэн, 143 нөлөөлийн үйл ажиллагаанд 5478 иргэн хамрагдсан . 2022-2023 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрөөр 130 суралцагч суралцаж байгаа бөгөөд эрдэнэмандал хийдийн дэргэдэх баян эрхт шашны сургуулийн 20 лам хүүхэд хамрагдаж байна. Бага боловсролд-27 Суурь боловсролд-103 Энэ хичээлийн жил суурь боловсролыг 32 суралцагч төгссөн. | 100 |
| 86 | 2.4.1. Гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг дээшлүүлж, сургалт нөлөөллийн ажлын хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтот гэр бүлд чиглэсэн үйлчилгээг өргөжүүлэх. | 2021 - 2024 | | зорилтот өрхийн амьдралын чанар дээшилсэн хувь 30 | Гэр бүлийг дэмжих туршилтын хөтөлбөр Сүхбаатар аймагт хоёр дахь жилдээ хэрэгжиж байгаа билээ. Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар тус хөтөлбөрт сонгогдсон 270 өрхөд нөхцөл байдлын үнэлгээ хийж, хүүхэд бүрт эрсдлийн нөхцөл байдлын үнэлгээ хийж ажилласан | 90 |
| 87 | | 2. Байгууллагын эцэг эхийн зөвлөл шалгаруулах болзолт уралдаан зарлаж дүгнэх | 2021 - 2024 | | 1 | Аймгийн Засаг даргын 2021.05.11-ний өдрийн А/271 дүгээр захирамжийн гуравдугаар хавсралтаар “Хүүхдэд ээлтэй эцэг эхийн зөвлөл” шалгаруулах журмыг шинээр баталсан. аймгийн хэмжээнд 120 байгууллага эцэг эхийн зөвлөлөө байгуулан ажиллаж байгаа бөгөөд шалгаруулалт 12-р сард хийгдэнэ. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 88 | | 3. "Гэр бүл , хүүхдэд ээлтэй сум" , байгууллага шалгаруулах болзолт уралдаан зохион байгуулах | 2021 - 2024 | | 1 | Аймгийн Засаг даргын 2021.05.11-ний өдрийн А/271 дүгээр захирамжын гуравдугаар хавсралтаар “Хүүхдэд ээлтэй сум” шалгаруулах журмыг шинээр батлан хэрэгжүүлж 8 сум тайлангаа ирүүлсэнээс наран сум шалгарч аймгийн Засаг даргын 2022 оны А/80 дугаар захирамжаар 2,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 100 |
| 89 | | 4. Хувь хүний ур чадварыг дээшлүүлэх сургалт зөвлөгөөн зохион байгуулах | 2021 - 2024 | | 2 | Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Онгон, Мөнххаан сумдад 2 дахь жилдээ хэрэгжиж байгаа Японы хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж байгаа "Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох төслийн амжилттай хэрэгжүүлж 367 15-25 насны залуучуудад хувь хүний зөөлөн ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, Дорнод аймгийн багш Цоглхагвын “Төрийн албан хаагчийн Харилцаа хандлага” сэдэвт сургалтыг ХХҮГ, БШУГ, ЭМГ, Соёлын байгууллагууд, аймаг сумын ЗДТГ-ын нийт 150 төрийн албан хаагчдыг хамруулан , “Гэр бүлийн харилцаа-хандлага”, “ Хүүхдийн хөгжил, хүмүүжилд орчны нөлөөлөл” сургалтуудад 56 албан хаагч, Дэлхийн улс орнуудад суралцагч оюутан, залуучуудын холбооны ерөнхийлөгч Н.Лхагвадорж "Ирээдүй таны гарт" уулзалтыг аймгийн төвийн сургуулийн 9-12-р ангийн 300 гаруй сурагч, Итгэл ирээдүй ТББ-ын илтгэгч Д.Хүрэлбаатарын "Хамтын хүч амжилт" сургалтанд 130 төрийн удирдах, гүйцэтгэх албан хаагч, нийт 1003 иргэд, төрийн албан хаагч, сурагчдыг томоохон хэмжээний сургалтанд хамруулсан. Байгууллагуудын ёс зүйн зөвлөлөөр дамжуулан 88 төрлийн нөлөөллийн арга хэмжээ, ажлуудыг зохион байгуулж давхардсан тоогоор 2990 багш, ажилтан хамруулсан. Олон нийтийг хамарсан 12 төрлийн сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 90 | | 5. Эмэгтэйчүүдийн уулзалт, сургалт, зөвлөгөөн, нийгэмд тустай төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | | 1 | Аймгийн Засаг даргын дэмжлэгээр эмэгтэйчүүдийн холбоог өдөр тутам ажиллах ажлын байраар хангаж 3 өрөө байрыг төр засгаас олгосон. “Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжье” аймгийн эмэгтэйчүүдийн чуулганыг “Өөрчлөлтийг өөрөөсөө” өглөөний иога дасгалаар эхэлж, нэгдсэн хуралдаан, “Би ба миний дөрвөн эмэгтэй” лекц, “Эмэгтэйчүүд эмэгтэйчүүдээ дэмжье” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулан 12 сумын 400 гаруй эмэгтэйчүүд оролцож, нэгэн өдрийн турш эмэгтэйчүүд, нийгмийн өмнө тулгамдсан олон асуудлыг хөндөн ярилцаж, гарц гаргалгаа, зөв шийдлийг эрэлхийлэн саналаа солилцож, цаашдаа аз жаргалтай, сайн сайхан ирээдүйг бүтээн байгуулахад ,бидний оролцоо, нөлөөлөл ямар байх талаар хэлэлцэн ярилцсаж Хамтдаа “Ойлгоё, хүндэлье, дэмжье" уриалга гаргалаа. Аймгийн олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр "Эмэгтэйчүүдийн үдэш " арга хэмжээ,Гэртээ хүүхдээ хардаг, ажлаасаа түр чөлөө авсан, хараахан өөрт тохирох ажлыг олж чадаагүй байгаа нийгэм, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох сонирхолтой 20-35 насны бүсгүйчүүдийн хувьд хүний ур чадвар, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх замаар тэдний оролцоог нэмэгдүүлэх эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих " Бүсгүйн гараа" бичил төсөлд 20 эмэгтэйг хамруулсан. Эмэгтэйчүүдийн эдийн засаг дах оролцоог нэмэгдүүлэх нь Үндэсний чуулганд бизнес эрхлэгч 10 эмэгтэй, 'Хавдаргүй Монгол эмэгтэй " арга хэмжээнд 6 эмэгтэй оролцсон. Удвал агсаны амьдралаас сэдэвлэн бүтээсэн "Улаанцэцэг" киног эмэгтэйчүүдэд зориулан захиалан авчирч орон нутагтаа эмэгтэйчүүд иргэдэд үзэж сонирхуулав. Тус бүтээлийг 1000 гаруй хүн үзэж сонирхсон . ЭХ Улаан загалмайтай хамтран Охид бүхэн үзэсгэлэнтэй илтгэл уралдааныг зохион байгуулсан. | |
| 91 | | 6. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэхэд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангаж, Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулж, Баруун-Урт хотын баг бүрд хамтарсан баг байгуулах. | 2021 - 2024 | 2,8 сая төгрөг ОНТ | 2 | 22 хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 3 удаагийн томоохон сургалтыг 8 өдөр Үжин ТББ-тай хамтран гэрээлж зохион байгуулсан . 160 хамтарсан багийн гишүүд 3 удаагийн давтан сургалтад хамрагдаж кейсийн үйлчилгээнд хэрхэн бичиг баримт бүрдүүлж хохирогчид үйлчилгээ үзүүлэх талаарх мэдлэгээ нэмэгдүүлсэн. Сургалтын зардалд шаардагдах 2880,000 сая төгрөгийг аймгийн засаг дарга санхүүжүүлсэн. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг илрүүлэх, хохирогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн үйлчилгээг үзүүлэх анхан шатны нэгж болох Баруун-Урт сумын 9 багийн "ХАМТАРСАН БАГ"-т кейсийн хариу үйлчилгээ үзүүлэх бичиг хэргийн багцын дэмжлэг үзүүллээ. Мөн Наран сумын хамтарсан баг үйл ажиллагаагаа явуулах тусгайлсан өрөө гаргаж тохижуулсан. | 100 |
| 92 | 2.4.2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчин, нөхцөлийг бүрдүүлнэ. | 1. Асгат, Уулбаян, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Онгон сумдад ахмадын өргөө, хөгжлийн төв байгуулах | 2021 - 2024 | | 10 | Аймгийн Засаг даргын 2021 оны 154 дүгээр захирамжаар 2021-2024 онд ахмадын талаар хэрэгжүүлэх 90 бүтээлч ажлын чиглэл, төлөвлөгөөг батлан, сум, холбогдох байгууллагуудад хүргүүлэн, холбогдох арга хэмжээг зохион байгуулж, байна. Аймгийн Засаг даргаас сумдын Засаг даргатай байгуулсан 2022 оны гэрээнд ахмадын хөгжлийн төв, танхимыг бий болгох, тохижуулах чиглэлээр холбогдох заалтыг тусгалаа. Тайлант хугацаанд Түвшинширээ сум Ахмадын хөгжлийн төвийг шинээр байгуулсан байна. Аймгийн хэмжээнд 13 суманд ахмадын хороо идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй бөгөөд Түмэнцогт, Эрдэнэцагаан, Сүхбаатар сумд үйл ажиллагаагаараа улсдаа тэргүүлэх үзүүлэлтийг үзүүлсэн байна. | 90 |
| 93 | | 2. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлаг, спортын наадмыг зохион байгуулах | 2021 - 2024 | 5.0 сая | Тийм | Аймгийн Засаг даргын нэрэмжит "АХМАД-2022" спортын 7 төрөлт наадам IX/23-25-ны өдрүүдэд Баруун-Урт суманд зохион байгуулж, , давхардсан тоогоор 629 ахмад тамирчид, үүнээс 54,2 хувь буюу 341 нь эмэгтэй тамирчид оролцсон байна. Ахмад-2022 спортын наадамд Ахмадын хавчаахай харваа болон Шугаман бүжгийн төрөл шинээр нэмэгдсэн ба сумдын дүнгээр Тэргүүн байр Баруун-Урт, Дэд байр Эрдэнэцагаан, 3-р байр Халзан, Тусгай байр Мөнххаан, Уулбаян сум эзэллээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын арга хэмжээнд оролцох боломж нөхцлийг бүрдүүлэн 2022 оны 05-р сард зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагсан "Зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээн", 2022 оны 06-р сард зохион байгуулагдсан "Монгол абилимп-2022" уралдаан, бүх ард түмний наадамд оролцох зардлыг шийдвэрлэж, дэмжлэг үзүүллээ. | |
| 94 | | 3. ХХҮГазрын дэргэдэх Ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааг өргөтгөх | 2022 - 2024 | | Өргөтгө сөн эсэх | Ахмадын амралт, сувиллын үйл ажиллагааг өргөжүүлэн, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, бие даасан байдлыг хангах зорилгоор Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор дугаар тогтоолоор "Амгалант дэнж" улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгууллаа. Амгалант дэнж УТҮГазрын үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор орон нутгийн тусгай зөвшөөрлөөр сувиллын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг авсан ба байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2023 оны орон нутгийн төсөвт 60.0 сая төгрөгийг тусгаад байна. | 90 |
| 95 | | 5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх оролцоог хангах дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | 10 | 30 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх оролцоог дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг орон нутагт төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран гүйцэтгэж байна. Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг 12 сумдад ажиллан, уулзалт зохион байгуулж, сургалт, нөлөөллийн арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. Монголын Тусгай Олимпын хороо, Улаанбаатар Ротари Клуб, Мобиком Корпораци ХХК хамтран зохион байгуулж буй "Боломжийг Бүгдэд" төслийн хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 18-20-ний өдрүүдэд Дорнод аймагт зохион байгуулсан сургалт, уулзалт зөвлөгөөнд тус аймгийн төрийн аймгийн ТББ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эхийн төлөөлөл 60 гаруй хүн амжилттай оролцлоо. Дээрх сургалтад оролцсон төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран "Цацарсан хайр - Цалгисан итгэл" өдөрлөг арга хэмжээг Баруун-Урт суманд зохион байгуулж, 50 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эхийг хамруулав. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хөгжил оролцоог дэмжих дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх , төрийн бус байгууллагын санал, оролцоог дэмжих зорилгоор аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чуулганыг 2022 оны 12 дугаар сарын 02-нд Баруун-Урт суманд зохион байгуулахаар бэлтгэж ажлыг хангаж байна. 2022 жилийн эцсийн байдлаар дэд хөтөлбөрийн хэрэгжилт 40 хувьтай байна. | 100 |
| 96 | | 6. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, ХББЭМНХСК-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | 4 | 5 | 2022 оны 05 дугаар сард аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, холбогдох асуудлыг хэлэлцэв. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн хөгжлийн бэрхшээл, хоцрогдлыг эрт илрүүлэх, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2022 оны А221 дүгээр захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссыг бүх сумдад ажиллуулахаар шийдвэрлэн, салбар комисс бүх сумдад ажиллаа. гжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол нийгмийн хамгааллын асуудлаар орон нутгийн удирдлага, сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн төвийн эрхлэгч, ХХҮГазрын хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Насан туршийн боловсролын багш, нийгмийн бодлогын мэргэжилтнүүдтэй хамтарсан уулзалт зохион байгуулж мэдээлэл зөвлөгөө өгч, шаардлагатай хүүхдийн асуудлыг газар дээр нь шийдвэрлэлээ. Дээрх үйл ажиллагаанд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас 3750.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | |
| 97 | 2.4.3. Залуучуудын хөгжлийг дэмжинэ. | 1. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх залуучуудын хөгжлийн төвийг 1 цэгийн үйлчилгээ үзүүлэх төв болгон, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, тохижуулах | 2022 - 2024 | | 1 | НҮБ-ын Хүн амын сангийн санхүүжилтээр зөөврийн компьютер, зургийн аппарат зэрэг тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Үйл ажиллагаа сайжруулах 77 сая төгийн тон. Төх дэмжлэг хүссэн. /1 цэгийн үйлчилгээний төв болгоно гэж арга хэмжээг ойлгомжгүй томьёолсон/ | 70 |
| 98 | | 2. "Нутгийн Залуучууд" хөтөлбөр хэрэгжүүлж, залуучуудын чуулган зохион байгуулах | 2021 - 2024 | 70,0 сая 10,0 сая | 0 | Аймгийн ИТХ-ын 2021 оны 41 дүгээр тогтоолоор "Нутгийн Залуучууд" хөтөлбөрийг батлуулан төрийн ажлыг ТББ -аар гүйцэтгүүлэх ажлын хүрээнд Залуучуудын холбоогооро гэрээлэн гүйцэтгүүлж байна. Залуучуудын холбоог 3 өрөө ажлын байраар хангаж , 300 залуучуудын чуулган зохион байгуулж 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн ЗДТГ, эрүүл мэндийн газартай хамтран “ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА” сарын аян зарлаж , "ЭРТЭЧ ЭРЧҮҮД" өглөөний уулзалт арга хэмжээг зохион байгуулан 35 эрчүүдийг хамруулж Эрчүүдийн эрүүл мэнд, эрэгтэй эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү эрчүүдийн богино наслалт зэрэг асуудлыг хэлэлцлээ. Сүхбаатар аймгийн Залуучуудын холбоо нь “Гэртээ гэрэл асаая-II” төсөл, 3 сарын бүрийн 25-нд “ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ӨДӨР" хэмээн АИТХ-аар батлуулан үйл ажиллагааг зорилтот бүлэг бүрт зохион байгуулсан. ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨӨРӨӨСӨӨ” өдөрлөгийг 12 суманд сар бүрийн 25нд зохион байгуулан ажиллаж , 6 сумын 700 гаруй залуучуудыг оролцуулан зохион байгуулсан. | 100 |
| 99 | 2.4.4. Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээний | 2. Хүүхдийн оролцоо үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангах хүрээнд "Хүүхдийн | 2021 - 2024 | | 13 | аймгийн Хүүхдийн 7р чуулганы "Нэгдүгээрт хүүхэд" уриан дор 100 хүүхдийн оролцоотойгоор, хүүхдийн өмнө үүрэг хүлээгч сумдын Засаг дарга нарыг оролцуулан зохион байгуулсан. Тус чуулганд сум бүрийн хүүхдийн төлөө зөвлөл Сумдын Засаг дарга нарт тулгамдаж байгаа 40 гаруй асуудлыг хөндөн тавьж, 10 асуудлыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүртээмжийг нэмэгдүүлнэ. | чуулган" зохион байгуулж, гарсан шийдвэр, санал санаачилгын хэрэгжилтийг хангах | | | | шийдвэрлүүлэхээр амлалт авлаа. тус чуулганы үеэр аймгийн хүүхдийн зөвлөлийн тэргүүн, дэд тэргүүн гишүүдийн сонгууль бболж 106 хүүхэд оролцож тэргүүн болон дэд тэргүүн , тэргүүлэгч гишүүдээ сонгох сонгуулийг хүүхдүүд амжилттай шударга нээлттэй зохион байгууллаа. | |
| 100 | | 3. "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-г салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах | 2021 - 2024 | | кейс илрүүлгийн хувь 25<br>кейс шийдвэрлэлтийн хувь 40 | Хүүхдэд ээлтэй орон нутаг санаачлага, Хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх "СҮҮДЭР БҮҮ ТУСГА" аяны хүрээнд гэр бүл, нийгмийн орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийнн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, сургууль, цэцэрлэгийн "Хүүхэд хамгааллын баг" "Хамтарсан баг"-ийн гишүүдэд зөвлөн туслах ажлын хэсэг 13 суманд ажиллаж ЕБС-ийн сурагчдад "Хорт зуршил", "Мэргэжил сонголт", "Цахим орчны зохистой хэрэглээ" сэдвүүдээр сургалт хийн ... хүүхдийг хамруулллаа. явуулын үйлчилгээний хүрээнд ГБХТТ Хууль, Хүүхдийн эрхийн болон хамгааллын тухай хууль, #Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилт, Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, Хамтарсан багийн үйл ажиллагаа, кейс шийдвэрлэлт, Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдэд үйлчилгээ үзүүлж буй урьдчилан сэргийлэх үйлчилгээ , Залуучуудын салбар зөвлөлийн үйл ажиллагаа , ЕБС-ийн сурагчдад сургалт мэдээлэл хүргэх, Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх зэрэг үйлчилгээ үзүүлсэн. | 90 |
| 101 | | 4. Хэрэг зөрчилд холбогдсон, хохирсон хүүхдүүдэд “Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо”-оор дамжуулан үйлчилгээ үзүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | | шийдвэрийн тоо 3 | МУЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Олон улсын Эрх зүйн хөгжлийн IDLO байгууллага хамтран хэрэгжүүлж буй хэлэлцүүлгийг "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо", "Хамтарсан баг"-ийн хүрээнд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт аймгийн Засаг даргын орлогч Г.Мөнхзаяагаар ахлуулсан "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо"-ны гишүүд, Баруун-Урт сумын "Хамтарсан баг"-ийн гишүүдийн төлөөллийг оролцуулан: ХЭХЗХ-ны шинэ бүрэлдэхүүн, чиг үүрэг, шинэчлэгдсэн журам ХЭХЗХ-ны үйл ажиллагаа, нөхцөл байдал, 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга зам, Цагдаагийн байгууллагад хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын шатанд байгаа хүүхэд оролцсон гэмт хэргийн талаарх мэдээлэл ХЭХЗХ, Хамтарсан багийн үйл ажиллагаа, үйлчилгээний статистик, кейс шийдвэрлэлтийн талаар орон нутгийн түвшинд уялдуулах, "Хамтарсан баг"-тай хамтран ажиллах талбарын талаар хэлэлцлээ. Мөн ХЭХЗХ, "Хамтарсан баг"-ийн ажил үйлчилгээг орон нутгийн түвшинд уялдуулах, мэдээлэл солилцох, холбон зуучлах чиглэлээр гарч буй амжилт, сургамж, хүндрэл бэрхшээлийн талаарх нээлттэй хэлэлцүүлэг хийж санал хүсэлтийг сонсож, ажлын уялдааг сайжруулах тал дээр дор бүрнээ анхаарч, хариу үйлчилгээг шуурхай хүргэж ажилласан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 102 | | 6. Хүүхэд, залуучуудын хөдөлмөр зуслан, эко зуслан байгуулах | 2022 - 2024 | 2000,0 | 1 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дарьганга зусланг орчин үеийн стандартад нийцсэн амралт, аялал жуулчлалын цогцолбор болгон шинэчлэх ажлын хүрээнд 2,0 тэрбум төгрөгийн барилгын ажил хийгдэж, 2019-2023 онд 2,179,9 тэрбум төгрөгөөр барихаар улсын төсөвт 2023 онд 335,8 сая төгрөгийн хөрөнгө тусгасан. | 70 |
| 103 | 2.5.1. Хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинэ ажлын байр бий болгоно. | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | | 1768<br>300 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан 2022-2023 онуудад хэрэгжих 7 хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна. Тайлант хугацаанд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөрт 1436 иргэн хамрагдаж 1,082.3 сая төгрөг зарцуулсан ба төсөл, хөтөлбөрийн хүрээнд 255 ажлын байр шинээр бий болсон байна. 2022 оны 11-р сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 481 иргэн ажлын байранд зуучлагдаж 513 ажлын байр шинээр бий болсон байна. | 90 |
| 104 | | 2. “Малчны залуу халаа” хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 25<br>125 | ХЭДСангаас хэрэгжүүлж буй Малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 2022 онд 13 сумын 70 малчин өрхийг хамруулж, 350,0 сая төгрөгийн 3303 толгой малаар малжуулсан. байна. Арга хэмжээнд хамрагдсан 55 малчныг мал аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулсан. Мөн 1 иргэнийг туслах малчнаар ажиллуулахаар гэрээ байгуулж 4,0 сая төгрөгөөр малжуулах зорилгоор санхүүгийн дэмжлэг олгов. Орон нутгийн онцлогт түшиглэн "Малчны залуу халаа" хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлэхээр 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, 100.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж байна. | 70 |
| 105 | | 3. Гарааны бизнес буюу старт-аппыг дэмжиж, хөгжүүлэн ажлын байрыг бий болгох | 2021 - 2024 | 10 | 1 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрийн "СТАРТ-АП" залуучуудад гарааны бизнесийн дэмжлэг үзүүлэх сургалтыг “ВЕСТ МЕТОД” ХХК-ийн дэргэдэх сургалтын байгууллагатай хамтран 6 дугаар сард зохион байгуулж 20 залуу 10 баг болж бизнес шинэ санааг өрсөлдүүлснээр 5 баг шалгарч 5 долоо хоногийн хурдасгуур арга хэмжээнд хамрагдсан. Эцсийн шалгаруулалтад 10-0-0 MINI CINEMA-CHILL OUT CENTER баг шалгарч 10 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэг олгож 2 ажлын байр шинээр бий болсон байна. Шилдэг старп –ап орон нутагт хэрэгжсэнээр аймагтаа анх удаа орчин үеийн шийдэлтэй мини кино театрыг байгуулж хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж байна. | 100 |
| 106 | | 4. Орон нутгийн хэрэгцээнд тулгуурласан мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | | 55 | 2021-2022 онд зохион байгуулагдсан Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэн орон нутагт мэргэжлийн сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. ХХҮЕГазраас эрх авсан Улаанбаатар хотын “ДАРЬ ОВООНЫ ЭЗЭД“ ТББ дэргэдэх “Юу Ти Си” сургалтын байгууллага, Аймгийн МСҮТөв, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалт мэдээллийн төвтэй хамтран 2022 онд оёдол эсгүүр 33, авто засвар 21, гар урлал, уран зангилаа 9 нийт 63 иргэнийг мэргэжил олгох сургалтад чадамжийн гэрчилгээ олгов. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 107 | | 4. Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | | 6 | Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлэх, иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж, нөхцлийг нэмэгдүүлэх зорилгоор сумдын Засаг даргын тамгын газар, холбогдох байгууллагуудтай хамтран нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. 2022 онд дээрх арга хэмжээний хүрээнд нээлттэй хаалганы өдөрлөг, Ажил олгогчдын уулзалт, Эмэгтэйчүүдийн уулзалт зэрэг 7 удаагийн арга хэмжээг зохион байгуулан, давхардсан тоогоор 450 иргэнийг хамруулж 54 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан байна. | 100 |
| 108 | | 5. Ажлын байрыг бий болгох, хадгалахад чиглэсэн хөнгөлөлттэй зээлийг иргэд , аж ахуйн нэгжид олгох | 2021 - 2024 | | 15 | Хөдөлмөр эрхлэлтийн 5 хөтөлбөрийн 6 арга хэмжээний санхүүгийн дэмжлэгт 151 иргэн хамрагдаж 890.0 сая төгрөгийн олгосноор 255 ажлын байр бий болсон байна. Нийт сумдын хэмжээнд ХЭДС болон хоршоо хөгжүүлэх сангаас 947 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосноор 97 шинэ ажлын байр бий болсон. | 100 |
| 109 | 2.5.2. Орон нутгийн хөгжлийн зорилттой уялдуулан мэргэжлийн боловсрол, сургалтыг төрөлжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлнэ. | 2. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш нарыг мэргэшүүлэх, туршлага судлуулах арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | | 5 | 1. Барилгын засал чимэглэлчийн мэргэжлийн багш А.Энхжаргал ,Бетонарматурчин мэргэжлийн багш Ц.Оюунцэцэг, Барилгын өрөг угсрагч мэргэжлийн багш Г.Болор-Эрдэнэ нар үйлдвэрлэлийн дадлага болон үйлдвэр сургалтын дадлагын хичээлийг Талын баян-Эрхэт ХХК, "Хабу Хасу" ХХК, "Шарга" ХХК, "Хайлааст гарам" ХХК, "Энгэр бүрд" ХХК, "Оргих" ХХК, "Молцог элс" ХХК, "Их Модун" ХХК, "Aadar craft" ХХК, "Ханан салхит" ХХК-ууд дээр зохион байгуулснаар сүүлийн үеийн тоног төхөөрөмжийг ажиллуулах болон орчин үеийн барилга барих аргачлал, шинээр гарч ирж буй барилгын материалуудыг таньж мэдэн ашиглах гэх мэт сургалтаа цаг үедээ тохируулан зохион байгуулж байна.<br>2. АНУ-аас хоол хүнс үйлдвэрлэл, бизнес аж ахуйн чиглэлээр ажил үйлчилгээ эрхэлдэг иргэн MILLER STANLEY DAVID-г гэр бүлийн хамт урилгаар авчран Хоолны мэргэжлийн багш Д.Батцэцэгт харилцан туршлага судлуулж Европ хоол хийх арга барилд мэргэшүүлж байна.<br>3. Төмөр замын замчин мэргэжлийн багш А.Гансэлэм, Ойжуулагч мэргэжлийн баш М.Өлзийжаргал, Барилгын мэргэжлийн багш Э.Түвшинтөгс, Газар зүйн багш Х.Оюунболор, Англи хэлний багш Г.Ичинхорол, Монгол хэлний багш Х.Цэрэнцэцэг багш нарыг Хэнтий аймгийн ПК-д туршлага судлуулсан. 4. Х.Гэрэлмаа, Х.Оюунболор, М.Өлзийжаргал нар Дорнод дээд сургууль дээр туршлага судалсан. нийт 11 багш туршлага судлах үйл ажиллагаанд оролцсон. | 100 |
| 110 | | 3. “Ажилтай төгсөгч” хөтөлбөрийг хэрэгжүүлж, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 73 | Аймгийн Мэргэжлийн боловсролын сургалтын үйлдвэрлэлийн төвийн төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдааныг 2022 оны 10 дугаар зохион байгуулж, зөвлөлийн бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн зохион байгуулсан. -2021 онд зохион байгуулагдсан Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаанд үндэслэн цаашид элсэлт авах мэргэжлийн чиглэлийг оновчтой тогтоох -Төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, төгсөгчдийн ажил хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого арга хэмжээг нэн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэргүүнд шат дараатай хэрэгжүүлэх -Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн шинэ барилгын зураг төсвийн ажлыг хийлгэж, дараагийн хөрөнгө оруулалтыг татах ажлыг яаравчлах зэрэг үүрэг чиглэлийг өгсөн байна. Аймгийн мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2022-2023 оны хичээлийн жилд шинээр ойжуулалтын ангийг нээж, элсэлт авч байгаа бол хөдөлмөрийн зах зээлийн төлөвтэй уялдуулан төмөр замын элсэлтийг жил бүр авч байна. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа 2022 оны 01-р сарын 01-ээс эхлэн Боловсролын яаманд шилжсэнтэй холбогдуулан мэргэжлийн боловсрол, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 онд хэрэгжүүлсэн санхүүгийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр болон шилэн дансны хуулийн хэрэгжилт зэрэгт хяналт, шинжилгээ, үнэлгээ өгөх ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулан, үйл ажилагааг эхлүүлээд байна.Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 1 жилийн 6 мэргэжилд хийхэд мэргэжлээрээ ажиллаж байгаа 25,6 , мэргэжлийн бус ажил эрхэлж байгаа 23,1 , малчинаар ажиллаж байгаа 31,4 , цаашид суралцаж байгаа 4,1 , 15,7 хувь нь цэрэгт явсан, ажлын байр байхгүй, жирэмсэн болон эрүүл мэндийн шалтгаанаар ажил эрхлэхгүй байна гэсэн судалгааг хийсэн. 2,5 жилийн ангийг төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа хийхэд 4 мэргэжилд мэргэжлээрээ ажиллаж байгаа 31,2 , өөр ажил эрхэлж байгаа 34 | |
| 111 | | 4. Хөдөлмөрийн зах зээлийн төлөвтэй уялдуулан мэргэжлийн ангийн чиглэлийг оновчтой болгох | 2021 - 2024 | | 1 | Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа 2022 оны 01-р сарын 01-ээс эхлэн Боловсролын яаманд шилжсэнтэй холбогдуулан мэргэжлийн боловсрол, сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 онд хэрэгжүүлсэн санхүүгийн үйл ажиллагаа, төсөл хөтөлбөр болон шилэн дансны хуулийн хэрэгжилт зэрэгт хяналт, шинжилгээ, үнэлгээ өгөх ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар байгуулан, хяналт шалгалтын арга хэмжээг зохион байгууллаа. Аймгийн хөдөлмөрийн зах зээлийн төлөв, төр засгийн бодлого шийдвэртэй холбогдуулан Мэргэжил, сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2022-2023 оны хичээлийн жилд шинээр ойжуулалтын ангийг нээж, элсэлт авсан ба төмөр замын элсэлтийг жил бүр авч байна. | 90 |
| 112 | 2.5.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин, нөхцөлийг сайжруулна. | 1. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт хэлэлцээрийг 2 жил тутам зохион байгуулж, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | | 1 | Аймгийн Засаг дарга, Үйлдвэрчний эвлэлийн холбоо болон ажил олгогч эздийн холбооны дарга, тэдгээрийн бүрэн эрх төлөөлөгчид хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2022-2023 оны хэлэлцээрийг байгуулж, аймгийн ХХҮГазарт 2022 оны 02-р сард бүртгүүллээ. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг орон нутагт хангах, Засгийн газрын “Нийгмийн түншлэлийг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 370 дугаар тогтоол, аймгийн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2022-2023 оны гурван талт хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны 07, 08 тоот албан даалгаврыг сум, агентлагт хүргүүлэв. | |
| 113 | | 2. ХАБЭА-н орчин бүрдүүлсэн ААН-ийг урамшуулах | 2021 - 2024 | | 3 | Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2022 оны 4- сард ХАБЭА-н сарын аян, 10 дугаар сард эрүүл мэндийн салбар дахь ХАБЭА-н хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг тус тус амжилттай зохион байгууллаа. Аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлөөс "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг эрхэмлэгч байгууллага" шалгаруулах удирдамжийг боловсруулан сум, байгууллагуудад хүргүүлсэн ба 2022 ажлын төлөвлөгөөний дагуу 2022 оны 12-р сард Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуйг эрхэмжлэгч байгууллага, сумыг шалгаруулна. | 90 |
| 114 | | 3. Цалин хөлс, ХАБЭА-н талаарх Засаг даргын нэрэмжит сарын аян, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | | 1 | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг аймгийн төвийн 7 аж ахуйн нэгжүүдэд үзлэг хийж зөвлөмж өгч ажиллав. 2022 оны 04-р сард ХАБЭА-н сарын аяныг зохион байгуулж, “Хөдөлмөрийн тухай хуулийн шинээр орсон зохицуулалт”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”, “Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх” сэдвээр танхимаар болон цахим сургалтыг МҮЭХ-ны дэргэдэх сургалтын байгууллага, холбогдох бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулж давхардсан тоогоор 300 гаруй байгууллагын 1242 ажилтан , албан хаагчийг хамруулсан. байна. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг Баруун-Урт сумын 11 цэцэрлэгт зохион байгуулж ХАБЭА-н анхан шатны баримт бичгийг бүрдүүлэх, ХАБЭА-н ажилтан хэрхэн ажиллах талаар 240 цагийн зөвлөгөө өгч ажиллав. | 100 |
| 115 | 2.5.4. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй олгоно. | 1. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах | 2021 - 2024 | | 9 | 2022 онд шинээр ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж зэрэг 3 үйлчилгээ Ehalamj.mn цахим системд шилжсэнээр халамжийн үйлчилгээ 100 цахимд шилжээд байна. | 100 |
| 116 | 2.5.5. Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, аймгийн хэмжээнд татварт бүртгэлтэй | 1. Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад холбогдох хууль тэдгээрийг дагалдан гарах журам, дүрмийг иргэдэд сурталчлах, сургалт | 2021 - 2024 | | 15 | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулахаар орон нутагт зохион байгуулсан 59 удаагийн арга хэмжээнд 4848 хүн хамрагдсан байна. Нээлттэй хаалганы өдөрлөг: 7 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 1159 иргэд даатгуулагчдад мэдээ мэдээлэл өгсөн. Явуулын үйлчилгээ: 4 удаагийн явуулын үйлчилгээгээр нийт 235 хүнд мэдээ мэдээлэл өгж ажиллаа. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад: Нийт 26 удаагийн сургалтаар 3038 иргэнд мэдээлэл өгч ажилласан байна. Олон нийтийн сүлжээ буюу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажил олгогчийн 98, эдийн | сурталчилгааг сайжруулах | | | | фэйсбүүк хуудсаар 8026 хүнд мэдээлэл хүргэж, BBS телевизийн “Тодруулга” мэдээнд 22 удаагийн мэдээ өгч ажилласан. | |
| 117 | засгийн идэвхтэй хүн амын 50 хувийг нийгмийн даатгалд, нийт хүн амын 98 хувийг эрүүл мэндийн даатгалд хамруулна. | 2. Цахим үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 85 | ИРГЭД ДААТГУУЛАГЧДАД 1.Даатгуулагчид зориулсан https://daatguulagch.ndaatgal.mn веб программын тусламжтайгаар дараах үйлчилгээг хүргэж байна.Үүнд: Тэтгэвэр тогтоолгосон талаар мэдээлэл Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт илгээх Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж авах хүсэлт илгээх Жирэмсэн, амаржсаны тэтгэмж авах хүсэлт илгээх Нийгмийн даатгалын шимтгэлээ төлөх Сайн дурын даатгалын гэрээ байгуулах Нөхөн даатгалын талаар мэдээлэл авах Тэтгэврээ өөрчлөн тогтоолгох 2. Даатгуулагчид зориулсан “Нийгмийн даатгал” аппликэйшнийг 2018 оноос эхлэн нэвтрүүлсэн бөгөөд даатгуулагч нь энэхүү аппликэйшнийг ашиглан өөрийн: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллээ харах, тодорхойлолт авах; Нийгмийн даатгалын сангаас авсан тэтгэвэр, тэтгэмжийн мэдээлэл авах; Нэрийн дансны орлогын мэдээлэл харах; Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, гэрээгээ сунгах, шимтгэлээ төлөх; Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар мэдээлэл авах боломжтой. 3.Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт цахимаар гаргах боломж 4.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны тэтгэмж авах хүсэлт цахимаар гаргах боломж 5. Нийгмийн даатгалын дэвтэрийг халж цахим дэвтэр буюу апп-р дамжуулж НД шимтгэл болон бусад мэдээллийг хянадаг боллоoo. 6. Цахим архивын программийг нэвтрүүлэх шатанд 6.Фэйсбүүк болон фэйжээр дамжуулж тус тус мэдээлэл хүргэн ажиллаж байна. АЖ АХУЙН НЭГЖИД Шимтгэлийн цахим систем НД-ын шимтгэлийн төлөлтийн талаарх тодорхойлолт | 100 |
| 118 | | 3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын нөхөн шимтгэл төлөлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | 2020-2021 онуудад үргэлжлэн хэрэгжээд дууссан. Нийт 1300 малчин, ХХЭ хамрагдсанаас 2022 онд 174 малчин иргэн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон авч байна. | 100 |
| 119 | 2.5.6. Өрхийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх арга хэмжээг хөдөлмөр эрхлэлтийн | 1. Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах дэд хөтөлбөрийн хүрээнд өрхийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | | 250 | 2022 онд 13 сумын амьжиргааг дэмжих зөвлөлийг хуралдуулж, иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор 400 өрхийн амьжиргааг дээшлүүлэхээс 222 өрхийн хөгжүүлэх, 178 өрхөд дэмжлэг үзүүлэхээр сонгон ажиллаж байна. Тайлант хугацаанд Төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр 198 өрхөд 25,685.0 мянган төгрөгийн гэр, хашаа, хүнс, түлээ түлш, бэлэг зэрэг бараа материалын дэмжлэг үзүүлсэн. | 90 |
| 120 | бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ. | 2. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн | 2021 - 2024 | | 140 | Халамжаас хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхийн хөдөлмөрийн насны иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2022 онд ийгмийн халамжийн дэмжлэг, | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд хамруулах | | | | туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн 956 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулсан ба 178 иргэн байнгын ажлын байранд зуучлагдсан байна. Мөн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөлд 126 иргэн, мэргэжил олгох болон бусад сургалтуудад 328 иргэнийг тус тус хамруулсан байна. Зорилтот өрхийн иргэдийг хөдөлмөр эрхлэлт болон ОНОТХҮйлчилгээний төсөлд хамруулах замаар ХЭБ үйлчилгээнээс түдгэлзүүлж НАРАН, ТҮВШИНШИРЭЭ СУМД ХҮНСНИЙ ЭРХИЙН БИЧГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГҮЙ СУМ БОЛСОН. | |
| 121 | 2.5.7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлж, нөлөөллийн ажлын нэр төрлийг нэмэгдүүлнэ. | 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2023 | | 150 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газрын санаачлагаар 2022 оны 02, 03-р сард аймгийн хэмжээнд “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн төлөө” аяныг зохион байгууллаа. Аяны хүрээнд аймаг, сумдын ЗДТГ, Эрүүл мэндийн газар, АНЭ, Өрх сумын эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран эрэгтэйчүүдийг урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулж, эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт сурталчилгааг хийж, сумд байгууллага хамт олноороо эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Аймгийн Цагдаагийн газрын дэргэд хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байр байгуулагдаж, 2022 оны 5 сард ашиглалтад орж "Үжин төв" ТББ гэрээлэн үйл ажиллагаа явуулж байна. Төрийн албан хаагчдыг сургах зорилтын хүрээнд Мерит төсөлтэй хамтран 600 гаруй албан хаагчдыг "Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт цахим сургалтад хамруулсаны зэрэгцээ 2 дахь шатны сургалтад 32 албан хаагчийг хамрууллаа. Дээрх сургалтад хамрагдсан албан хаагчид орон нутагт жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг нэвтрүүлэх чиглэлээр 12 дэд төслийг амжилттай хэрэгжүүлж байна. 2022 оны 10-р сард Жендэрийн үндэсний хороо, Хүний эрхийн үндэсний комиссын ажлын хэсэг орон нутагт ажиллаж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн, орон нутагт хийгдэж буй бодлого арга хэмжээтэй танилцлаа. | 90 |
| 122 | | 2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах | 2021 - 2024 | | 3 | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Аймгийн Цагдаагийн газрын дэргэд хохирогчийн аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байр байгуулагдаж, 2022 оны 5 сард ашиглалтад орж "Үжин төв" ТББ гэрээлэн үйл ажиллагаа явуулж байна. Төрийн албан хаагчдыг сургах зорилтын хүрээнд Мерит төсөлтэй хамтран 600 гаруй албан хаагчдыг "Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт цахим сургалтад хамруулсаны зэрэгцээ 2 дахь шатны сургалтад 32 албан хаагчийг хамрууллаа. | 100 |
| 123 | 2.6.1. Үндэсний үнэт зүйлсийг хадгалж, | 1. Үл хөдлөх дурсгалуудыг хамгаалах, хүн | 2021 - 2024 | ОНХС 10,0 сая | | Засаг даргын захирамжаар байгуулагдсан Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллогын ажлын хэсэг 13 суманд ажиллаж, нийт 281 үл хөдлөх дурсгалыг тоолж, бүртгэн баримтжуулж, RICH | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамгаалан хойч үедээ өвлүүлэн уламжилна. | чулууны хадгалалт, хамгаалалтыг сайжруулах | | | | mongoluv программд бүртгэж оруулсан. Тус арга хэмжээг зохион байгуулсан зохион байгуулсан ажлын үр дүнгээр улсад 3-р байранд орсон. Түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг хамгаалах чиглэлээр орон нутгийн иргэд малчидтай гэрээ байгуулан сайн дурын гэрээт хамгаалагчаар ажиллуулж, урамшуулалд бензин түлшний дэмжлэг, соёл урлагийн үйлчилгээгээр гэр бүлээрээ үнэ төлбөргүй үйлчлүүлэх эрх, Засаг даргын болон соёлын төвийн зүгээс шагнал урамшуулал олгох зэргээр дэмжиж урамшуулсан. Хүн чулуун хөргүүдийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр Наран сум албан байгууллагуудынхаа дунд уралдаан зарлаж, ЭМТ, СӨБ-ийн хамт олон Мандалын 1, 2-р хүн чулуу, Онгон сум Хөрөгт, Шартад хадны 5 хүн чулуун хөргийг шинээр хашаажуулж, ойр орчинд шувууны суултуурыг давхар хийж байрлуулсан.<br>Үл хөдлөх хөшөө дурсгалуудыг хамгаалах, өнгө үзэмжийг сайжруулах зорилтын хүрээнд Дарьганга , Халзан, Мөнххаан сумд нийт 12 хөшөө дурсгалын өнгө үзэмжийг сайжруулж, хашаажуулж сэргээн засварласан. | |
| 124 | | 2. Соёлын биет бус өв тээгчдийн судалгааг бодитой болгон, өвлөн уламжлуулах арга хэмжээг зохион байгуулж, алдаршуулах | 2021 - 2024 | ЗДМХ хэрэгжүүлэх зардалаас "Сүхбаатар 80" урлагийн наадам 22,5 сая "Талын Монгол" тоглолт 15,0 сая "Нүүдэлчин Монгол" фестивал 15,0 | | Аймгийн соёлын биет бус өв тээгчдийн улсын үзлэг, судалгаа хийж, цахим бүртгэлд 302 өвлөн уламжлагчийг бүртгэж, 10 сумын 79 өвлөн уламжлагчийн үйл ажиллагааг баримтжуулсан. Ардын авьяастнууд, өв тээгчдийг олон нийтэд таниулан сурталчлах, алдаршуулах, үйл ажиллагааг нь түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Сүхбаатар 80" ардын урлагийн наадмыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан ба 13 сумын 430 ардын авъяастан 9 төрлөөр оролцсон. Мөн УБ хотод ардын авьяастнууд, аймгийн театрын уран бүтээлчид, УБ хот дахь нутгийн гаралтай уран бүтээлчид, өв тээгчид оролцсон "Талын Монгол" тоглолтыг зохион байгуулж, дээрх 2 арга хэмжээний хүрээнд наадамд оролцсон Дарьганга, Эрдэнэцагаан, Сүхбаатар сумдын 3 төрөлт өвлөн уламжлагчийг шагнаж урамшуулсан. Тус 2 арга хэмжээний зардалд ЗДМХ хэрэгжүүлэх зардлаас 37,5 сая төгрөг зарцуулсан.Угсаатны түүх соёл, өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий улсын хэмжээнд зохион байгуулагдсан "Нүүдэлчин-22" арга хэмжээнд оролцсон ба ЗДМХ хэрэгжүүлэх зардлаас 15,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Эрдэнэцагаан, Халзан, Мөнххаан, Дарьганга сумдын 6 биет бус өвлөн уламжлагчдын баримтат мэдээ, мэдээллийг бэлтгэн сошиал орчинд сурталчилсан. Орон нутгийн ТВ-тэй хамтран 5 өв тээгчийн цуврал баримтат, контентийг хийж, олон нийтэд хүргэн, баримтжуулж хадгалсан. Өв тээгч Монгол Улсын ардын жүжигчин Шарын Чимэдцэеэгийн “Дуунд залбирсан тавилан" тоглолтын арга хэмжээнд хүндэтгэл үзүүлж, 1,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Өв тээгч Ш. Чимэдцэеэд урамшуулал 1,0 сая Нийт 53,5 сая | | | |
| 125 | 2.6.2. Хүүхэд залуусыг үндэсний өв соёл, ёс заншлаа дээдлэгч, өвлүүлэгч, хамгаалагч иргэн болгож хөгжүүлнэ. | 2. Орон нутгийн угсаатны зүйн музейн үзмэрийг хүүхэд бүрд үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | | | “Ганган байгаль” уран зургийн үзэсгэлэн, Үндэсний бичиг соёлын өдрийг тохиолдуулан “Титэм арт” академийн тэргүүнтэй хамтран "Их хаадын захидал" үзэсгэлэн, Номын баярын тохиолдуулан “Баримтат өв” үзэсгэлэн, ОУ-ын хүүхдийн эрхийн хамгаалах өдрөөр “Монгол наадгай” үзэсгэлэн, аймгийн 80 жилийн ойд зориулан “Түүх мартахгүй” үзэсгэлэн, Ардын зураач Амгалангийн зургуудын фото үзэсгэлэн, Соёлын бүтээлч сарын хүрээнд “Монгол бахархал-Монгол хэл,бичиг”, “Амгалан тал” үзэсгэлэн , “Гоё өдрүүд” музейн тайлбарт аялал арга хэмжээнүүдийг зохион байгуулж, нийт 4360 хүүхэд музей үзсэн. ЕБС-ийн сурагчдад “Монгол гэр”, “Эх хэл үндэсний дархлаа”, “Угсаатан” боловсролын ажил, СӨБ-ийн хүүхдүүдэд “Байгаль эх-Миний гэр” сургалт, боловсролын ажилуудыг зохиож, 1095 хүүхэд хамрагдсан. Мөн "Дарьганга өв аялаж байна" үйл ажиллагаанд “Дарьганга” зочид буудалд байрлаж буй 30 гэр бүл, Олон улсын гэр бүлийн өдрөөр 11 цэцэрлэгийн “Аав-Ээж-Би” тэмцээнд 8 гэр бүл, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Монгол наадгай” арга хэмжээнд 140 гэр бүл, музейн ажилчдын гэр бүл дунд зохион байгуулсан “Гэр бүл- Амьдралын бэлэг” арга хэмжээнд 17 гэр бүл тус тус хамрагдсан. тайлант хугацаанд ЕБС-ийн 5368 хүүхэд буюу 33.6 хувьд, СӨБ-ийн 1540 хүүхэд буюу 24,4 хувьд музейн үйлчилгээг хүргэсэн. | 100 |
| 126 | 2.6.3. Угсаатны өв соёл, ёс заншлыг түгээн дэлгэрүүлнэ. | 1. "Өв соёл" -ын эвент арга хэмжээнүүд зохион байгуулах | 2021 - 2024 | | | Дарьганга угсаатны өв, соёлыг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэн уламжлуулах зорилгоор Дарьганга сумын ЗДТГ, Соёлын төв хунгийн чуулганы үеэр "Хунгийн баяр" арга хэмжээг Дарьганга хошууны 6 сумтай хамтран зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд өв соёлын үзэсгэлэн, Дарьганга нүүдэл, бэр гуйх ёслол, идээ ундааны соёл, хувцас эд хэрэглэгдэхүүний үзэсгэлэн зэрэг олон талт арга хэмжээ зохион байгуулагдаж, арга хэмжээнд 580 гаруй иргэд, зочид төлөөлөгчид оролцсон. Монгол хурдан морь болон адууны өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий "Агтан хүрээт" наадам уламжлал болгон зохион байгуулагдаж 3 мянга гаруй хүн оролцсон. Тус арга хэмжээнд сумд адуучид, иргэдээ зохион байгуулан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцуулснаас гадна аймгийн соёл урлагийн байгууллагууд хамтран оролцож, үзэмчин болон Дарьганга соёлын өвийн үзэсгэлэн , Дарьганга ястны шавар зуух барих үзүүлбэр, эмээлийн ганзага мялаах ёслол, таван хошуу мал сэтэрлэх, гал тахих ёс, азарга тавих ёс зэргийг үйлдэж, жуулчид, наадамд оролцогчдод үзүүлж, өв соёлоо түгээн дэлгэрүүлж, сурталчилсан. Улсын хэмужээнд зохион байгуулагдсан соёлын биет бус өв тээгчдийн "Нүүдэлчин Монгол 22" наадамд СББӨ-ийн 6 ай савын төрөлд 61 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. Наадамд хүндэтгэлийн өргөө 1, Гар урлалын үзэсгэлэнгийн гэр 1, Өв соёлын өргөө 2, нийт 5 гэрийг угсаатны ахуй соёлыг шингээснэ байдлаар тохижуулж, дарьганга, үзэмчин угсаатны тоглолт зохион байгуулсан ба Мөнххаан сумын өвлөн уламжлагч Цээсүрэн нь хамгийн олон шавь сургасан өвлөн уламжлагчаар шалгарсан амжилт үзүүлсэн. Наадмын үйл ажиллагааны зардалд ЗДМХ хэрэгжүүлэх зардлаас 15,0 сая төгрөг зарцуулсан. | |
| 127 | | 2. . "Дарьганга соёлын өв", "Сүхбаатар аймаг" брэнд брэндбүүк бүтээн, соёл урлагийн болон сурталчилгааны контент шинээр бий болгож, олон нийтэд сурталчлах, сувгийн хөгжүүлэлт хийх | 2021 - 2024 | Сумдын урлагийн наадам 22,05 сая, "Талын Монгол" концерт 15,0 сая /ЗДМХ ХЗ/ Нандин өв 5,0 сая /ЗДМХ З/ "Сониуч хүүгийн адал явдал" | | Нутгийн болон угсаатны онцлог бүхий брэнд, брэндбүүк үүсгэх зорилтын хүрээнд аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн лого, эмблем, бэлэгдлийг бүтээж, сурталчилгаа хэвлэмэл хуудас, бэлэг дурсгал, урилга, хөтөлбөр зэрэгт ашиглахын хамт 80 жилийн ойн арга хэмжээг "Сүхбаатар аймаг"-ийн онцлог шинжийг илэрхийлсэн байдлаар зохион байгуулсан. Дарьганга угсаатны онцлог бүхий эвент бүтээх арга хэмжээний хүрээнд Дарьганга сум "Хунгийн баяр" арга хэмжээг Дарьганга хошууны 6 сумтай хамтран зохион байгуулсан ба 580 гаруй иргэд, зочид төлөөлөгчид оролцсон. "Агтан хүрээт" наадам 4 дэх жилдээ зохион байгуулагдаж, 3000 гаруй зочид төлөөлөгчид оролцсон. Тус арга хэмжээнүүдэд соёлын байгууллагууд угсаатны ахуй, идээ ундааны соёл, хувцас эд хэрэглэгдэхүүний үзмэр үзэсгэлэн, ёс заншлыг ёс заншлыг харуулсан үзүүлбэрүүдийг дэглэн толилуулсан. Угсаатны урлаг соёлыг агуулсан "Талын Монгол" концертыг УБ хотод 2 удаа тоглосон. УЗМ нь Дарьганга мөнгөн урлалын үзмэрийг музейн гол бренд болгон УБ хотноо "Нандин өв" үзэсгэлэн, орон нутагт "Дарьганга өв аялаж байна" арга хэмжээг зохион байгуулсан. Угсаатны өв соёлыг хүүхэд багачууддаа өвлүүлэх, олон нийтэд сурталчлах зорилгоор ННС-ийн хамт олон Соёл, урлагийг дэмжих сангаас зарласан төслийн уралдаанд гавъяат багш Ш. Чулуунборын “Сониуч хүүгийн адал явдал” цуврал өгүүллэгээр дүрст видео ном, аудио сонсдог ном, дабль CD, хуурцаг / бүтээх төслөөр оролцож шалгарсан. Дарьгангачуудын үр хүүхдээ хүмүүжүүлж ирсэн ёс заншил, өв соёл, гоо зүйн талаар мэдлэг олгох бүрэн хэмжээний дүрст болон аудио хос хуурцаг бүтээж зах зээл дээр гаргах зорилготой. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүрс ном 50,0 сая /Соёл урлагийг дэмжих сан/ | | | |
| 128 | 2.6.4. Аймгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээнэ. | 1. Угийн бичиг хөтлөх арга хэмжээг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх | 2021 - 2024 | 5,1 сая ОНХС | | Угийн бичиг хөтлөлтийг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх, баяжилт хийх, шинээр хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлэх, салбар дундын оролцоонд тулгуурлан хэрэгжилтийг хангуулах зорилгоор аймгийн Засаг даргын А/517 дугаар захирамжаар “Угийн бичгээ хөтөлж, удмын сангаа хамгаалъя” сарын аян зарласан. Аны удирдамж чиглэл болон "Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд соёл, урлагийн салбар байгууллагууд нь идэвхтэй оролцож нэгдсэн дүнгээр аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан 81 сургалтанд 2467 иргэн хамрагдаж, давхардсан тоогоор 34 багш ажиллаж, сургалтаас бусад төрлийн 58 арга хэмжээ зохион байгуулж, 4065 иргэн хамрагдсан. Нийт 5,1 сая төгрөг зарцуулсан. | 90 |
| 129 | 2.6.5. Соёл, урлагийн байгууллагын чадавхыг сайжруулна. | 1. Баяндэлгэр, Түмэнцогт, Онгон сумдад стандартын шаардлага хангасан Соёлын төв барих | 2021 - 2024 | | | Баяндэлгэр сумын 300 хүний суудалтай соёлын төвийн барилгын суурь, нэгдүгээр давхрын хучилтын ажил хийгдэж, ажлын гүйцэтгэл 35 хувьтай байна. Төсвийн хэмнэлтийн хуулийн хүрээнд Онгон сумын Соёлын төвийн барилгын ажил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлаас хасагдсан. 2023 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд Онгон, Түмэнцогт сумын саналыг хүргүүлсэн. | 50 |
| 130 | | 2. Соёлын төвүүдийг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, алслагдсан хөдөөгийн иргэдэд соёлын явуулын үйлчилгээг хүргэх | 2021 - 2024 | | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Зүүн бүсийн шилдэг Соёлын төвөөр шалгарсан Сүхбаатар сум, мөнТүвшинширээ сумын соёлын төвд 52.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Сум, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 10 Соёлын төв 126.4 сая төгрөгийн нийт 165 ширхэг техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумын номын санд 15.1 сая төгрөгийн 434 нэр төрлийн 880 ширхэг хүүхдийн номоор номын сангийн сан хөмрөгийн баяжилт хийсэн байна. Сум, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 4 суманд 5,0 сая төгрөгийн номын баяжилт хийгдсэн ба аймгийн нийтийн номын санд АЗДМХ хэрэгжүүлэх зардлаас 5,0 сая төгрөгийн шинэ номын баяжилт хийсэн. Алслагдсан хөдөөгийн иргэдэд урлаг, соёлын тоглолт, номын үзэсгэлэн, угийн бичгийн сургалт зэрэг 229 удаагийн бүх төрлийн соёлын явуулын үйлчилгээг хүргэж давхардсан тоогоор 47521 иргэд хамрагдсан. | 100 |
| 131 | | 4. Виртуал технологид суурилсан соёлын өвийн танилцуулга, | 2022 - 2024 | | 100 | Хугацаа болоогүй. 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж батлуулсан. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | цахим музейтэй болоход шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх | | | | | |
| 132 | 2.6.6. Номын сангийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 2. Сумдын номын сангуудыг номын сангийн LIB4U нэгдсэн программд холбох | 2021 - 2024 | Шинэ програм нэвтрүүлэх 10,0 сая /ЗДМХ/ | | Электон номын сан болон электрон каталоги байгуулан уншигчдад ашиглуулах, ном, тогтмол хэвлэл, эрдмийн ажил, аудио, видео гэх мэт материалуудыг бүртгэх, зураасан кодын тусламжтайгаар номын сангийн үйлчилгээ, тооллого хийх ажлыг автоматжуулах, тайлан, статистик мэдээллээр хангах LIV4U нэгдсэн програмд аймгийн 12 сумыг холбосон. Програм холбосонтой холбоотойгоор сумдын номын санчдад чадавхжуулах сургалт зохион байгуулж хэрэглээнд нэвтрүүлэх бэлтгэл хангасан. Аймгийн хэмжээнд 22387 нэр төрлийн 55473 ширхэг номын програмд оруулсан байна. | 100 |
| 3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ | | | | | | | |
| 133 | 3.1.1. Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд сайн засаглалыг хөгжүүлэх замаар өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 1. Удирдлагын багийг чадавхжуулах замаар үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн үр ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх | 2021 - 2024 | | | 2021 онд аймгийн Засаг дарга орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн захиралтай байгуулсан контрактыг дүгнэх ажлын хэсэг нь аймгийн Засаг даргын А/78 дугаар захирамжаар байгуулагдсан. ИТХ-ын Тэргүүлэгчдийн 49 дүгээр тогтоолоор батлагдсан орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай Контракт байгуулах дүгнэх журмын дагуу 9 хуулийн этгээдийг үнэлж аймгийн Засаг даргад 2022 оны 122 тоот албан тоот бичгээр гэрээний үнэлгээг хүргүүлсэн. Нийт байгууллагын дундаж нь 55 хувьтай үнэлэгдсэн байна. 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж байгаа Хөдөлмөрийн тухай хуулиар ОНӨААТҮГ-тай гэрээ байгуулах зүйл заалт өөрчлөгдсөн тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 49 тогтоолыг хүчингүй болгож ОНӨААТҮГ-тай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журмыг аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/419 дүгээр захирамжаар батлуулан ажиллаж байна. ОНӨААТҮГ-уудын удирдлагын багийг чадавхижуулах чиглэлээр сургалт мэдээллийг тухай бүр хэрэгжүүлж ажиллахаас гадна олонхийг хамруулсан сургалтыг 1 удаа зохион байгуулсан. Тухайн байгууллагуудын үйл ажиллагааны явцаас үзэхэд өмнөх жилүүдээс удирдлага зохион байгуулалт сайжирч байна. /Жилийн эцсийн мониторинг хийгдэж байна/ . | 90 |
| 134 | | 2. Санхүүгийн сахилга, хөрөнгийн ашиглалтыг сайжруулснаар алдагдлыг бууруулах | 2021 - 2024 | | | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн 18 газар дулаан түгээх дулаан үйлдвэрлэх, амралт, ногоон байгууламж, хог зөөвөр, цэвэрлэгээ, эмийн жижиглэн худалдаа явуулж байна. Жилийн эцсийн байдлаар нийт байгууллагын гэрээг дүгнэсэн бөгөөд 7 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газар нь ашигтай ажилласан бөгөөд бусад байгууллагууд нь алдагдалтай ажилласан байна. Тхйлант онд санхүүгийн сахилга, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор зохион байгуулагдсан улсын үзлэг тооллогоор Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд дээр 10 төрлийн 95,958,800 төгрөгийн маргаантай, 10 төрлийн 50,856,551.44 төгрөгийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дутагдсан, 14 төрлийн 2,708,928,240 төгрөгийн бүртгэлгүй хөрөнгийн зөрчлүүд илэрч аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр ИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн. Тус тооллогын хугацаанд газар болон үл хөдлөх хөрөнгийн зарим нэг зөрчлийг арилгасан, цаашид ашиглах боломжгүй хөрөнгийн жагсаалтыг гаргасан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 77 дугаар тогтоолын дагуу 1 ОНӨААТҮГ-ийн 3 хөрөнгийг худалдах шийдвэр гарсаны дагуу 3 удаагийн дуудлагын худалдааг зохион байгуулж, 24,100,000 төгрөгийн 3 үндсэн хөрөнгийг худалдан борлуулсан. | |
| 135 | 3.1.2. Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, сахилга хариуцлагыг сайжруулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ. | 1. Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгох | 2021 - 2024 | | | Татварын хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд 2021 оноос эхлэн татвар хураалтыг цахимжуулж бэлэн мөнгөний тасалбараар хураадаг байсныг бүрэн зогсоосон. Мөн хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэний орлогын албан татварын болон үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тайланг цаасаар гаргаж ногдлыг гараар компьютерт оруулдаг байсныг өөрчлөн цахимаар тайлагнадаг болсон ба дараа оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тухайн жилийн татварын ногдол нь автоматаар үүсдэг болсон. Иймд татвар төлөгч татварын ногдол цахим болж, тайлангаа цахимаар хийдэг болсоноор татвар төлөгчдөд хүндрэлгүй болсон гэж үзэж болно. | 100 |
| 136 | | 2. Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгон төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх | 2021 - 2024 | | | 1.Төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын программыг УСНББОУ-ын стандартад нийцсэн, хууль тогтоомжийг шинэчлэлийг тусгасан, нягтлан бодогчид болон төрийн сангийн үйл ажиллагааг хөнгөвчилсөн CTS программаар шинэчлэн 58 төсвийн байгууллага, 30 төсөл сангийн үйл ажиллагаанд нэвтрүүлээд байна. Энэ программ хангамж нь онлайн горимоор ажиллах боломжтой, нярвын тайлан нь нягтлан бодогчийн тайлантай уялдсан, байгууллагын гүйлгээ төрийн сангийн төлбөр тооцооны fools, санхүүгийн тайлан нь э-тайлан системд хөрвөх боломжтой зэргээр нягтлан бодогчийн ажлын ачааллыг багасгаж үр дүнг нэмэгдүүлсэн давуу талуудтай болно. Мөн программ ашиглалтын талаарх сургалтыг хөгжүүлэгч байгууллагатай хамтран 5 болон 11 сард нийт 176 ажилтанг хамруулан зохион байгуулсан бөгөөд хэрэгжилт хангалтай гэж үзэж байна. 2. "Эрхийн бүртгэлийн сан" системийн хөгжүүлэлтийг Сангийн яам хийж, түүний дата мэдээлэл болох аймгийн 124 төсвийн байгууллагын төлбөрийн баримтад 1,2 дугаар гарын үсэг зурах этгээдийн мэдээллийг цахим системд бүрэн оруулж дууссан. Төрийн сан, төсвийн байгууллагын систем хооронд мэдээлэл солилцох, цахимаар төлбөр тооцоо хийх, хяналт тавих боломжийг бүрдүүлэх зорилгоор “Портал систем”-ийг хөгжүүлэх ажлыг үе шаттай нэвтрүүлж байна. 12 сард 3 Портал системийн туршилт, сургалтыг 3 төсөвт байгууллага мөн орон нутгийн 1 дансанд хийхээр төлөвлөн ажиллаж байна. 3. Төсвийн төлөвлөлтийн “Fiscal” программыг 13-н сумын төрийн санд суулгаж, санхүү албаны дарга , мэргэжилтнүүдэд программын сургалтыг зохион байгууллаа. Төсвийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөлтийн “Fiscal” программыг бүх сумд ашиглаж эхэлснээр төсвийн төлөвлөлт, төсвийн хуваарь, төсвийн зохицуулалтын үйл ажиллагаа хялбар болж цаг хугацаа хэмнэх, төсвийн тооцооллын арифметик алдаа гаргахгүй байх, төсвийн байгууллагуудын санал хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх зэрэг олон давуу талуудыг бий болгож байна.<br>4. Хөрөнгө оруулалтын программ хангамж | |
| 137 | | 3. Газар, үл хөдлөх эд хөрөнгө, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн бүртгэлийг сайжруулж, татварын хувь хэмжээг бууруулах замаар татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | | 2021 онд АТБӨЯХАТ- хамрагдалт 55,1 , газар 91, Үл хөдлөх эд хөрөнгө 95,3 байсан бол 2022 онд 59,7 , үл хөдлөх 96,1 , газар 100 хувийн хамрагдалтай байна. Үл хөдлөх эд хөрөнгө болон автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор хувь хэмжээг бууруулах талаар саналаа аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн боловч, аймгийн ИТХ-аас хувь хэмжээг тогтоосон хурлын тогтоол шийдвэр өнөөдөрийн байдлаар батлаагүй байна. | 90 |
| 138 | | 4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | | Сүхбаатар аймгийн 2022 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөг 2021 оны 12-р сарын 20-нд аймгийн Засаг даргын А/721 дугаар захирамжаар 59 нэр, төрлийн бараа, ажил, үйлчилгээ 8836,4 сая төгрөгийн төсөвтэй батлагдсан. 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/524 дугаар захирамжаар 58 нэр төрлийн 10430,2 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг шинэчлэн баталсан байна. Улсын болон орон нутгийн төсөв, мөн эрх шилжиж ирсэн болон явсан нийт 77 нэр төрлийн 44231.7 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээний тендер зохион байгуулахаас өнөөдрийн байдлаар 62 гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 33948,4 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. Зохион байгуулагдсан тендер шалгаруулалт бүрийн тендерийн баримт бичигт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу тендерт оролцогчдод давуу эрх олгох тухай тусгаж давуу эрх тооцуулах боломжоор хангаж ажилласан. Энэ онд давуу эрх тооцуулах хүсэлт, шаардлагыг хангаж давуу эрх тооцуулсан оролцогчдоос 2553.6 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан. Худалдан авсан бүтээгдэхүүнийг гэрээний дагуу цаг хугацаанд нь нийлүүлэлтийг хийж хамтран ажиллаж байна. | 100 |
| 139 | 3.1.3. Банкнаас бусад олон талт санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. Иргэн, хуулийн этгээдийн хөрөнгийн болон бусад үүсмэл санхүүгийн зах зээлийн талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх | 2021 - 2024 | | | Санхүүгийн зах зээл өргөжин тэлж,бүтээгдэхүүн үйлчилгээ боловсронгуй болохын хэрээр түүнийг дагаад санхүүгийн залилан, луйврын схем, олон шатлалт санхүүгийн пирамид зэрэг механизм хувьсан өөрчлөгдөж ялган таних, тогтоон илрүүлэхэд хүндрэлтэй болж байна. Орон нутгийн иргэдийн мэдээ мэдээллээс алслагдсан байдал, санхүүгийн мэдлэгийн түвшин хангалтгүй зэргийг ашиглаж тэднийг татан оролцуулах, улмаар залилах тохиолдол нэмэгдсээр байна. Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт Герман, Швейцарийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтарсан PLC Ultima гэх хөрөнгө оруулалт хэлбэрээр мөнгө татан төвлөрүүлэх, иргэдийг тус койнд өндөр ашиг амлаж, элсүүлэх зорилгоор нээгдсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос албан ёсны тусгай зөвшөөрөл аваагүй тул үйл ажиллагаагаа явуулахыг нь зогсоох арга хэмжээг авч ажиллалаа.Тус койны талаар анхааруулга, сэрэмжлүүлгийг иргэдэд хүргэх ажиллагааг шат дараатайгаар төлөвлөн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд иргэдийн санхүүгийн боловсрол, мэдлэг мэдээллийг дээшлүүлэх ажлын хүрээнд Монгол банк бусад арилжааны банкууд, НТБТөв, ЕБ-ын 1,2,3,4-р сургууль, ГБХЗХГ газар гэх зэрэг нийт 44 байгууллагатай хамтран “Иргэдэд хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох нь”, “Дэлхийн мөнгөний 7 хоног”, "Ирээдүйнхээ төлөө хуримтлуулцгаая", аян, сургалт хэлэлцүүлгийн үйл ажиллагааг 2 сарын хугацаанд аймгийн бүх сумдад 30 удаагийн давтавжтайгаар 943 сурагч, 55 иргэн, 58 төрийн албан хаагчдад зохион байгууллаа. Тус аяны хүрээнд иргэд болон сурагчдад мөнгө, үнэт цаас, үүсмэл болон хөрөнгийн зах зээлийн талаар зах зээлийн санхүүгийн мэдлэг мэдээллийг хүргэн, хэрхэн хөрөнгийн зах зээлд зөв, үр ашигтайгаар оролцох, тэдгээрийн давуу болон сул талууд, үүсмэл зах зээлийн хор уршиг зэрэг ойлголтуудыг олгосон давуу талтай сургалтууд болж өнгөрлөө. Тус сургалтын үр дүнд санхүүгийн сахилга батад суралцсан, хуримтлал үүсгэсэн, хадгалах зуршлыг нэмэгдүүлсэн, хуримтлал бий болгосон, банк болон компаниудын хувьцааг судлан үр өгөөж өндөртэй арилжаанд оролцон хувьцаа худалдан авсан гэх зэргээр эерэг үр дүнгүүд гарсаар байна. | |
| 140 | | 2. "Даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх" | 2021 - 2024 | | | Аймгийн хэмжээнд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 119 иргэн байдаг бөгөөд аймгийн төвд болон 12 суманд гэнэтийн осол, эмчилгээний даатгал, хөрөнгийн даатгал, автотээврийн хэрэгслийн даатгал, мал амьтдын даатгал, автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал, урт хугацааны даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус онд гэнэтийн ослын даатгалд 159 иргэнийг 14,6 сая төгрөгөөр, хөрөнгийн даатгалд 3 иргэнийг 4,0 сая төгрөгөөр, автотээврийн хэрэгслийн даатгалд 53 иргэнийг 34,1 сая төгрөгөөр, жолоочийн хариуцлагын даатгалд 1449 иргэнийг 110,7 сая төгрөгөөр, мал амьтдын даатгалд 13623 бог, 3675 бод малыг 22,4 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалд 239 иргэнийг 5,8 сая төгрөгөөр, зээлийн эрсдлийн даатгалд 540 иргэнийг 26,0 сая төгрөгөөр тус тус даатгалд хамруулсан бөгөөд зуучлалын үйл ажиллагааны чиглэлээр 21,4 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан байна. Даатгалын нөхөн төлбөрт гэнэтийн ослын даатгалаар 7 иргэнд 13,7 сая, хөрөнгийн даатгалаар 2 иргэнд 1,9 сая, автотээврийн хэрэгслийн даатгалаар 7 иргэнд 3,8 сая, жолоочийн хариуцлагын даатгалаар 27 иргэнд 17,2 сая, эрүүл мэндийн даатгалаар 41 иргэнд 2,0 сая, зээлийн эрсдлийн даатгалаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1 иргэнд 0,7 сая төгрөгийг тус тус нөхөн олговроор буцаан олгожээ. 2022 онд даатгалын үйлчилгээний хүртэмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлснээр даатгалд хамрагдалт болон орлого бүрдүүлэлт 20-30 хувиар өслөө. Даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Үндэсний давхар даатгал, албан журам, Монголын даатгалын холбооноос хамтран даатгалын төлөөлөгчдийн сургалт, шалгалтыг тус оны II улиралд зохион байгууллаа. Сургалтад нийт 35 иргэн оролцсон бөгөөд эрх олгох шалгалтад 10 иргэн тэнцэн "Монгол даатгал" ХК-д төлөөлөгчөөр ажиллах тусгай зөвшөөрлөө авлаа. Даатгалын хохирол үнэлэгчийн 2 салбар, Даатгал зуучлагчийн 7 салбар үйл ажиллагаа явуулж байна. | |
| 141 | 3.1.4. Статистик мэдээллийн хамрах хүрээ, тооллого, судалгааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 1. Улсын хэмжээний тооллого, судалгааг зохион байгуулах | 2021 - 2024 | | | Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны А237 тоот захирамжийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс 06 дугаар сарын 19-ний хооронд Хөдөө аж ахуйн ээлжит тооллогыг зохион байгуулсан. Хөдөө аж ахуйн тооллогын бэлтгэл ажлын хүрээнд тооллогонд ажиллах тоологч, шалгагчийн сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. Энэхүү сургалтад Аймгийн тооллогын комиссын дарга Д.Шижирбаатар, Хэлтсийн дарга Т.Эрдэнэбат, Үндэсний Статистикийн хорооноос ХААТ-н гэрээт ажилтан Б.Маралсувд , мэдээлэл технологийн газрын референт н.Энэбиш, хэлтсийн мэргэжилтэн Ө.Хулан, нягтлан бодогч Ц.Азжаргал нар оролцож тооллогын танилцуулга, тооллогын зохион байгуулалт, анхаарах асуудал, ХААТ-1,2,3,6 маягтуудыг нөхөх, таблетыг хэрхэн ашиглаж мэдээлэлээ цуглуулах талаарх сургалтуудыг хийлээ. Сургалтанд 13 сумын 50 тоологч, 14 шалгагч нийт 64 хүн хамрагдсан.. Уг тооллогод аймгийн хэмжээнд газар тариалан эрхлэгч өрх 222, ААНБ 39, ойн аж ахуй эрхлэгч ААНБ 11, түүврээр мал аж ахуй эрхлэгч өрх 3394, ААНБ 61 нийт 3727 нэг тооллогонд хамрагдсан. Хөдөө аж ахуйн тооллогын хяналтаар хэлтсийн дарга Т.Эрдэнэбат Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр, Халзан, Түмэнцогт, Мөнххаан, Түвшинширээ, Уулбаян, Баруун Урт сумдад, нягтлан бодогч Ц.Азжаргал Асгат, Сүхбаатар сумдад ажилласан. Хөдөө аж ахуйн тооллогын мэдээлэл цуглуулан сүлжээтэй газар бүрт төвд дамжуулан ажиллаж эцсийн дамжуулалтыг 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдөр тоологч нар хийж тооллогын мэдээлэл бүрэн дамжуулалт хийсэн. 2022 оны 11-р сарын байдлаар өрхөд суурилсан 8 төрлийн судалгааг 2781 өрхөөс цуглуулан ажилласан. Өрх, хүн ам болон мал, тэжээвэр амьтдын 2022 тооллогын бэлтгэл ажлыг хангаж, багийн Засаг дарга нарын сургалтыг 2022 оны 11-р сарын 16-ны өдөр зохион байгуулан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 142 | | 2. Статистикийн анхан шатны мэдээ, тайлангийн чанарт анхаарч сумд, ААНБ-д улсын байцаагч нарын хяналт, шалгалтыг хийх | 2021 - 2024 | | | Статистикийн хэлтсийн дарга бөгөөд улсын байцаагчаасны мэргэжилтнүүдийн цуглуулсан салбарын анхан шатны мэдээнүүдэд 1 удаа хяналт хийж, гарсан алдаа зөрчлийг дор бүр нь арилгуулж, анхаарч ажиллах санамжийг өгсөн байна. Аймгийн ЗДТГ, Статистикийн хэлтэс, Татварын хэлтсийн холбогдох албан хаагчид хамтран жилийн эцсийн санхүүгийн балансыг буруу гаргасан 15 аж ахуйн нэгжийн тайланд хяналт хийж, илэрсэн алдааг засуулан ажиллалаа. Мөн улсын хэмжээний мэдээ тайланг хугацаа хожимдуулж, алдаатай гаргасан Эрдэнэцагаан, Асгат, Наран, Түмэнцогт сумдын холбогдох албан хаагчдад хариуцлага тооцож ажилласан байна. | 100 |
| 143 | 3.2.1. Ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна. | 1. Байгаль, орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил арга хэмжээг, чанартай гүйцэтгүүлж, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж байгаа аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжин ажиллах | 2021 - 2024 | Аж ахуй нэгжүүдийн хөрөнгөөр | | БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар баталсан журмын дагуу тухайн жилийн байгаль орчны менежментийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын 2020 оны А/446 дугаар захирамжаар байгуулагдсан аймгийн БОАЖГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг 11-р сарын 01-ний дотор тайланг хүлээн авч, газар дээр нь ажиллаж дүгнэлт гарган БОАЖЯ-нд хүргүүлж ажилладаг. Энэ оны тайлангаа үнэлүүлэхээр "Цайрт минерал", "Хунт өгөөж", "Олгойбулаг","Монголжүюаньли", "Цэгээн үүдэн" ХХК-иуд хүсэлтээ ирүүлээд байна. Ажлын хэсэг 12 сард ажиллана. Аймгийн хэмжээнд "Цайрт минерал", "Эм эл цахиурт овоо", "Монголжүюаньли" ХХК-иуд баяжуулах үйлдвэрт усыг дахин ашиглах технологи нэвтрүүлсэн. Энэ онд "Эм эл цахиурт овоо" ХХК Бичигт боомтын нээгдээгүйн улмаас үйл ажиллагаа явуулаагүй байна. | 70 |
| 144 | | 2. Уул уурхайн ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах, байгаль орчин, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор бүтээгдэхүүн тээвэрлэлтийн экспортын хүнд даацын авто зам барих ажлыг үе шаттай хэрэгжүүлэх | 2021 - 2024 | Төсөл хөтөлбөр болон аж ахуй нэгж байгууллагын хөрөнгөөр | | Бичигтийн боомтын үйл ажиллагаа 9 сараас туршилтын журмаар тээвэрлэлт явуулж эхэлсэн. Аймгийн Засаг даргын 2022 оны А/520, А/521, А/575 дугаар захирамжаар Хунт өгөөж, Каскейд майнинг, Олгойбулаг ХХК-иуд тээвэрлэлт гүйцэтгэх түр чиглэл батлуулж, хэсэгчилсэн авто зам засварын ажлыг гүйцэтгэсэн. Мөн Эрдэнэцагаан сумын нутагт үйл ажиллагаа явуулах Эрээнтолгой ХХК Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/05 дугаар тушаалаар "Эрээн толгой" хүрэн нүүрсний уурхайгаас Бичигт боомтын чиглэлд 110.3 км тусгай зориулалтын авто замын чиглэл батлуулж, авто барих төслийг эхлүүлэхээр ажиллаж байна. | 70 |
| 145 | | 3. Орон нутгийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд шаардагдах ТТАМ-ын хайгуул, ашиглалтын | 2021 - 2024 | аж ахуй нэгж байгууллагуу | | Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа авто замын ажлуудад шаардагдах ТТАМ-ын карьерын солбилцолыг баталж авто замын гүйцэтгэгч компаниар нөхөн сэргээлтийг гүйцэтгүүлж, төлбөрийг сум, орон нутагт төвлөрүүлэхээр мэргэжлийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тусгай зөвшөөрөл олгох, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд орон нутгаас санал санаачилга гарган ажиллах | | дын хөрөнг өөр | | байгууллагууд хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ онд 1 аж ахуй нэгжид ТТАМ-ын хайгуулын тусгай зөвшөөрөл олгож, хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 8 өргөдлийг анхан шатны шүүлт хийн цахимаар бүртгэн АМГТГ-аас дүгнэлт авахаар хүргүүлээд байна. АМГТГ-аас Асгат сумын нутаг Бор нуруу-1 нэртэй, Асгат сумын нутаг Цахилдаг нэртэй талбайд ТТАМ-ын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой дүгнэлт ирсэнийг хуулийн дагуу сумын ИТХ-аас санал авахаар хүргүүлсэн. ТТАМ-ын өргөдөл шийдвэрлэлтийн явцын мэдээллийг аймгийн Засаг даргад танилцуулсан. 2019-2021 оны хугацаанд Эрдэнэцагаан сумын ИТХ-аас санал ирээгүй удааширсан ТТАМ-ын 7 өргөдлийн шийдвэрлэлтийн талаар аймгийн Засаг даргаас сумын ИТХ, Засаг дарга нарт хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлийг хүргүүлсэн. ТТАМ-ын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Ноёдын ноён хөндий" ХХК Хүрмэн, Шанаган, Элстэй нэртэй 3 талбайд хайгуулын зөвшөөрлийг сунгуулах хүсэлтийг хуулийн дагуу 2 жилийн хугацаагаар сунгаж байна. Мөн "Бага өлгий", "Сэвүүн уудам тал" ХХК-иуд хайгуулын ажлын үр дүнгээр нөөц тогтоолгон ТТАМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаар холбогдох материалаа ирүүлсэн. | |
| 146 | 3.2.2. Уул уурхай, газрын тосны салбарын үйл ажиллагаанаас орон нутгийн хөгжил, иргэдэд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 1. Уурхайг ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай нутгийн захиргааны байгууллага хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах | 2021 - 2024 | Төсөлөөс | | 2022 онд Нийгмийн хариуцлагын хүрээнд Орон нутгийн хөгжлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг өргөжүүлэх зорилгоор Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын дагуу Аймгийн Засаг дарга, холбогдох сумын Засаг дарга ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГУРВАЛСАН ГЭРЭЭ байгуулах уулзалт зохион байгуулж 18 аж ахуй нэгжтэй гэрээний хэлцэл зохион байгуулж 13 аж ахуй нэгжтэй аймаг, сум, компани гурвалсан гэрээ байгуулж баталгаажуулсан байна. Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд аймгийн хөгжлийн санд 2,335.0 сая төгрөгийн дэмжлэг төвлөрүүлэхээс 1,900.0 сая төгрөг төвлөрүүлээд байна. | 90 |
| 147 | | 2. Уул уурхайн салбарын хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, тусгай зөвшөөрөл, үйл ажиллагааны талаарх мэдээллийг орон | 2021 - 2024 | Төсөлөөс | | Уул уурхайн амьдралын мөчлөг сэдэвт сургалтыг Канадын засгийн газраас хэрэгжүүлж байгаа Мэрит төслийн дэмжлэгтэйгээр Дорнод их сургуулийн багш нараар Баяндэлгэр, Түвшинширээ, Мөнххаан сумдад зохион байгуулаад байна. Уг сургалтуудад давхардсан тоогоор 80 хүн хамрагдаад байна. Уг сургалтад Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ахлах мэргэжилтэн оролцож Монгол улсын Засгийн газраас санаачилсан шинэ сэргэлтийн бодлого, Уул уурхайн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нутгийн иргэдэд мэдээлэх | | | | салбарын хууль тогтоомж, тухайн сум орон нутагт олгогдоод байгаа тусгай зөвшөөрлүүдийн талаар бодит мэдээлэл өгч ажилласан. | |
| | | | | | | Мөн уул уурхайн бүсийн зөвөлгөөнийг Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ашигт малтмал газрын тосны газар, олборлох үйлдвэрийн ил тод байдлын ажлын дэд зөвлөл, Зам тээврийн яамтай иргэний нийгмийн байгууллагууд болон аж ахуй нэгжүүдтэй хамтран 3 сард болон 10 сард тус бүр хийгээд байна. | |
| | | | | | | Эрдэнэцагаан сумын нутгийн зөвлөлтэй хамтран Эрдэнэцагаан сумын уул уурхайн зөвлөгөөнийг иргэний нийгмийн байгууллагууд, тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллагууд, иргэдийг оролцуулан хийгээд байна. | |
| 148 | | 3. Төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, уул уурхайн компаниуд болон орон нутгийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор салбарын зөвлөгөөн, уулзалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | Төсլөөс | | Монгол улсын Засгийн газраас санаачилсан шинэ сэргэлтийн бодлого, Уул уурхайн салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд УУХҮЯ, Сүхбаатар аймгийн ЗДТГ, Мерит төсөл, АМГТГ хамтран “ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА, БОЛОМЖ, ШИЙДЭЛ” Зүүн бүсийн хэлэлцүүлэг, уулзалтыг 3-р сарын 28,29-ний өдрүүдэд Баруун-Урт хотод зохион байгууллаа. Бүсийн хэлэлцүүлэгт УУХҮЯ, ЗТХЯ, БОАЖЯ, ЭХЯ, АМГТГ, МХЕГ, Үндэсний геологийн алба, Геологийн төв лаборатор, Усны газар, Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Төв, Дундговь аймгийн Засаг дарга, ЗДТГ, аймгуудын МХГ, БОАЖГ-ын дарга мэргэжилтнүүд, холбогдох сумдын Засаг дарга нар, уул уурхайн аж ахуй нэгжүүдийн төлөөлөл, Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл нийт 180 орчим зочид төлөөлөгчид оролцсон. Ил тод хариуцлагатай уурхайг төлөвшүүлэхэд орон нутагт тулгарч байгаа асуудлыг хамтран шийдвэрлэх талаар санал солилцож талуудын оролцооны санаачлагаар "УРИАЛГА"-ын төсөл боловсруулж нийт оролцогчдод танилцуулсан. Мөн энэ оны 10 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын алба санаачилан Аймгийн ЗДТГ, Иргэний нийгмийн байгууллагууд хамтран Төрөөс эрдэс баялгийн салбарт баримталж байгаа бодлого, хууль, эрх зүйн орчны өөрчлөлт, хэрэгжилт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах салбарын өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх арга замын талаар санал солилцох, шийдвэрлэх арга зам сэдэвт “ЗҮҮН БҮСИЙН АЙМГУУДЫН ОЛБОРЛОХ САЛБАРЫН ИЛ ТОД БАЙДЛЫН НЭГДСЭН ЧУУЛГАН ЗӨВЛӨГӨӨН”-ийг Баруун-Урт суманд зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Гаалийн ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газрын удирдлага, мэргэжилтнүүд, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн ЗДТГ, сумдын удирдлага, ТАН эвсэл ТББ-иудын төлөөлөл, иргэд нийт 100 гаруй | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөөлөл оролцсон.Зөвлөгөөнөөс нэгдсэн уриалга, зөвлөмж гарч Засгийн газар, холбогдох яамд, орон нутагт хүргэгдэхээр болсон. | |
| 149 | | 4. Аймгийн хэмжээнд уул уурхайн салбарын хайгуул, ашиглалтын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хяналт шалгалт явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | 2021 - 2024 | Холбогдох байгууллагуудын зардлаас | | Бичигтийн боомтын үйл ажиллагаа хязгаарлагдмал байгаа тул уул уурхайн ашиглалт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа зогсонги хэвээр байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс өргөдөл гомдол ирээгүй байна. Аймгийн МХГ, БОАЖГ-уудаас хуулийн хэрэгжилтийн хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтууд хийгдэж байна.<br>Ашигт малтмалын хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлгүй хууль бусаар ашигт малтмал хайсан долоон үйлдлийг иргэдээс ирсэн мэдээллийн дагуу аймгийн Цагдаагийн газар экологийн цагдаатай хяналт шалгалт хийж таслан зогсоож эрүүгийн хэрэг үүсгээд байна.<br>Уг хэргүүдэд байгаль орчин, аялал жуулчлалын газрын зүгээс байгаль орчинд учруулсан хохиролыг холбогдох хууль тогтоомжийн дагуу тооцож шинжээчийн дүгнэлт гарган ажиллаж байна. | 90 |
| 150 | 3.2.3. Уул уурхайн орд газрыг түшиглэн экспортод чиглэсэн хүнд үйлдвэр байгуулах санал санаачилгыг дэмжинэ. | 1. Хөөт, Ерөөлт, Цахиурт овоогийн уурхайн ордыг түшиглэн хүнд үйлдвэр байгуулах төслүүдийн үйл ажиллагааг орон нутгаас бодлогоор дэмжин хамтран ажиллах | 2022 - 2024 | | 1 | Цахиурт овоогийн уурхайн баяжуулах гангийн үйлдвэр ашиглалтад ороод байгаа болович хил гааль хаалттай байгаа шалтгаанаар үйл ажиллагаа нь зогсонги байна.<br>Ерөөлтийн ордод ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг Дорнын чулуулаг ХХК нь ажилчдын кемпийг Цагаан залаатын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байгуулаад байгаа.<br>Хэрэгжих хугацаа болоогүй, Бичигтийн боомтын үйл ажиллагаа хязгаарлагдмал, хөрөнгө оруулалтын хүндрэлтэй нөхцлийн улмаас хувийн хэвшлийн аж ахуй нэгжээс хүнд үйлдвэр барих санал санаачлага гараагүй байна. 30 | 70 |
| 151 | 3.3.1. Атрын IV аяныг хэрэгжүүлж, атаршсан газрын талбайн ашиглалтыг сайжруулан, тариалалтыг нэмэгдүүлнэ. | 1. Үр тарианы аж ахуй нэгжүүдийн талбайн ашиглалтыг сайжруулах | 2021 - 2024 | - | 13 | Түмэнцогт сумын “Үргэлж бадрал”ХХК, “Хэрлэн Алтай”ХХК, “Түмэнцогт ургац”ХХК, “Газрын чимэг”ХХК, Сүхбаатар сумын “Дорнод шим агро”ХХК, Эрдэнэцагаан сумын “Номин богд” ХХК-иуд нийт 7548 га талбайд тариалалт хийж 6967.46 тонн ургацыг хураан авсан. Санхүүгийн хүндрэлээс шалтгаалан 2022 онд тариалах талбайн хэмжээ 4960 га-аар буурсан. | 90 |
| 152 | | 2. Төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээний 40-өөс доошгүй хувийг хангах | 2021 - 2024 | - | 160 га-д тариалах | Аймгийн хэмжээнд төмс 81.2 га, хүнсний ногоо 49,2 га нийт 130.4 га талбайд тариалалт хийснээс төмс 800 тн, хүнсний 500 тн нийт 1300 тн-ыг хураан авсан нь өнгөрсөн жилийнхээс төмс 64.9 тн, хүнсний ногоо 64 тн-оор нэмэгдсэн. Энэ нь хүн амын хэрэгцээт төмсний хангамжийн 34.8 хувь, хүнсний ногооны хангамжийн 8.6 хувьд хүрсэн. | 100 |
| 153 | | 3. Тариалангийн талбайг мал, тэжээвэр амьтны хөлөөс хамгаалах ажлыг эрчимжүүлэх | 2021 - 2024 | - | 500 га | Аймгийн Засаг даргын "Тариалангийн талбайг малын хөлөөс хамгаалах, чөлөөлөх тухай" А/405 дугаар захирамжийн дагуу Түмэнцогт суманд үйл ажиллагаа явуулдаг “Хэрлэн алтай” ХХК 300 га, “Газрын чимэг” ХХК 500 га, нийт 800 га, Сүхбаатар сумын Дорнод шим агро ХХК зөөврийн 2000 га, Эрдэнэцагаан сумын Номин богд ХХК зөөврийн 1900 га талбайн хашаажуулалт хийгээд байгаа нь тариалангийн талбайн 23.6 хувь байна. Түмэнцогт сумын 4, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сүхбаатар сумын 5, Эрдэнэцагаан сумын 35, нийт 44 малчинтай уулзалт хийж ургамал ургалтын хугацаанд тариалангийн талбайг малын хөлөөс чөлөөлөх тухай хуулийг танилцуулав. | |
| 154 | 3.3.2. Малын эрдэс, тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 1. Малын тэжээлийн тариалалтыг нэмэгдүүлэх /га/ | 2021 - 2024 | - | 1000 | Түмэнцогт сумын "Хэрлэн Алтай" ХХК 100 га талбайд ногоон тэжээл, 300 га талбайд овъёос, "Түмэнцогт ургац"ХХК 260 га талбайд ногоон тэжээл, 210 га талбайд овъёос, “Газрын чимэг” ХХК 130 га талбайд ногоон тэжээл, Баруун-Урт сумын ЗДТГ 6 га талбайд ногоон тэжээл, "Нараншарга агро"ХХК 10 га талбайд ногоон тэжээл, Сүхбаатар суманд "Дорнод шим агро" ХХК 200 га талбайд овъёос тус тус нийт 780 га-д овъёос, 872 га-д ногоон тэжээл тариалалт хийж, овъёос 718 тн, ногоон тэжээл 2125 тн тус тус хураан авсан. | 70<br>100 |
| 155 | | 2. Орон нутагт эрдэс тэжээлийн цех байгуулах санал санаачилгыг дэмжих | 2021 - 2024 | 130,0 сая | 1 | Сүхбаатар сумын 5 дугаар багийн иргэн Г.Боргил "Холимог хүчит тэжээлийн үйлдвэрлэл" байгуулахаар бэлтгэл ажлаа хангаж байна.Эрдэс тэжээлийн чиглэлээр аймгийн хэмжээнд хувийн хэвшлийг дэмжих ХХС-аас хөнгөлөлттэй зээл олгоход бэлэн байна. | 100 |
| 156 | 3.3.3. Өвөл зуны хүлэмжийн болон зоорины аж ахуйг хөгжүүлж, хүнсний ногооны ургацыг нэмэгдүүлнэ. | 1. Өвлийн хүлэмжийн аж ахуйг шинээр байгуулах | 2021 - 2024 | 35,0сая | 0,03 | Баруун-Урт сумын 8-р багийн иргэн Р.Даваа нь өөрийн хөрөнгөөр аймгийн ХХАА-н газрын зөвлөмжийн дагуу 72 м.кв бүхий 4 улирлын өвлийн хүлэмжийг барьж эхлээд байна. | 70 |
| 157 | | 2. 3.3.3.2. Нийлэг хальсан хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 25,0 сая | 3,2 | Орон нутгийн хөгжлийн сангаас Дарьганга, Баяндэлгэр, Баруун-Урт сумдад нийт 69.0 сая төгрөгний өртөг бүхий 32 м2 талбайтай 50 ширхэг хүлэмжийг 45 тариаланч иргэдэд олгосон. Үүнээс Баяндэлгэр сум 50 хувийн хөнгөлөлттэй нөхцлөөр 16 иргэнд, Дарьганга суманд 8 ширхэг, Мөнххаан суманд 2 ширхэг, Түмэнцогт суманд 2 ширхэг, Сүхбаатар суманд 1 ширхэг, Баруун-Урт суманд 21 ширхэг хүлэмж тус тус олгосон. Энэ онд аймгийн хэмжээнд 1600 м2 нийлэг хальсан хүлэмж нэмэгдэж нийт 39071м2 нийлэг хальсан хүлэмжийн 3.9 га талбайг эзэлж байна. | 100 |
| 158 | | 3. "Жимс, жимсгэнэ"-ний суулгац үржүүлгийг, эрчимжүүлэх, хамгаалалтыг сайжруулах | 2021 - 2024 | 5,0 | | ОНХС-аас жимс, жимсгэнэ үржүүлгийн төвийн цахилгааны асуудлыг шийдвэрлэснээр усалгааны асуудлыг бүрэн шийдвэрлээд байна. Туркийн хамтын ажиллагаа байгууллага/TIKA/ төслөөс 43.0 сая төгрөгний өртөг бүхий 120 м2 талбай бүхий 5 ширхэг нийлэг хальсан хүлэмжийг шинээр байгуулсан. Мөн үржүүлгийн газарт 200 ширхэг чацаргана, 130 ширхэг бөөрөлзгөний эх ургамлыг нэмж суулгасан. 1 га талбайд модны дуслын усалгааны систем, 120 м.кв бүхий 2 ширхэг мананцаржуулах услалтын системийг шинээр суурилуулсан.<br>БОАЖГ-аас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх, Намрын мод тарих өдрийг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж ажиллаа. Төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд<br>• Аймгийн хүрээнд айл өрхийг жимс жимсгэнийн мод / алим / тарьж ургуулахад дэмжлэг үзүүлж, Ховд аймгийн Булган сумаас энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах туршлагатай хүн урьж, Алимын мод тарьж ургуулах, түүний экологи, эдийн засгийн ач холбогдлын талаар газар дээр онол, дадлага хослуулсан сургалтыг зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан. Алим ургуулах сонирхолтой 70 гаруй иргэд 220 ширхэг модыг худалдан авч хашаандаа тарьсан. | |
| | | | | | | ХХААГ жимсний мод тарих ажлыг гүйцэтгэж байна. 700 гаруй жимсний эх ургамал үржүүлж байна. 5 хүлэмжийг 100.0 үхрийн нүд үржүүлэх ажлыг эхэлж, дуслын систем намираа усалгааны системийг ашиглаж байна. Алим, интоор, чавга,бөөрөлзгөнө,чацаргана, үхрийн нүд зэрэг модыг тарьж ургуулах ажлыг хийж байна. | |
| | | | | Алимны суулгац 1 ширхэг нь 35000 төгрөгийн үнэтэй. 70 иргэн 220 ш суулгац 7.7 сая төгрөгөөр худалдан авсан. | | | |
| 159 | | 4. Зоорины аж ахуйн ашиглалтыг сайжруулж, иргэдэд чанартай хүнсний ногоо нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх | 2021 - 2024 | - | - | Баруун-Урт, Сүхбаатар, Түмэнцогт сумдад төмс, хүнсний ногоо хадгалах нийт 590 тонныг 9 зоорийг ашиглаж байна. Энэ нь аймгийн хэмжээнд хураан авсан төмс, хүнсний ногооны 45 хувийг хадгалах нөхцөл бүрдсэн. Баруун-Урт сумын “Алтан цацал” хоршоо нь өөрийн хөрөнгө оруулалтаар 150 тн төмс, хүнсний ногоо хадгалах зоорийг шинээр барьж байгуулсан. | 100 |
| 160 | 3.3.4. Аймгийн хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг орон нутгийн үйлдвэрлэлээр | 1. Хүн амын стратегийн болон гамшгийн үеийн хүнсний нөөц бүрдүүлэх ажлыг аймаг, орон нутгийн хэмжээнд зохион байгуулах | 2021 - 2024 | | | Аймгийн стратегийн болон гамшгийн үеийн улирлын нөөц бүрдүүлэхээр 12 сумын 28 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байна, Аймгийн төвийн "ӨСӨХ ДЭЛГЭР УНДРАХ" ХХК, " НОМИН АГУУЛАХ ХУДАЛДАА"-ны төвийн агуулахад байршуулах Стратегийн хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл , хэмжээг хавсралтаар баталсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 6 1 | бүрэн хангах, хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна. | 2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх /мах, сүү, гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо гэх мэт/ | 2021 - 2024 | | | Одоогийн байдлаар 48 идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, цех, 200 гаруй иргэн хувиараа хүнс үйлдвэрлэж байгаа ба аймгийн хэмжээнд 10 сарын байдлаар мах 100 , /үүнээс үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах 51.8 хувь нь үйлдвэрийн аргаар / сүүний 30 , гурилан бүтээгдэхүүн 18 , төмс 34,6 , хүнсний ногоо 8,6 , өндөг 6.9 , цэвэр ус 2.8 хувиар тус тус дотоодын үйлдвэрлэлээр хангаж байгаа нь жил бүр тодорхой хувиар өсөн нэмэгдэж байна. Дээрх тооцооллоос үзэхэд хүнсний ногоо 1,6 хувь, гурилан бүтээгдэхүүн 1.0 хувиар нэмэгдэж, шинээр 2800 өндөглөгчтэй тахианы аж ахуй байгуулагдсанаар өндөгний хангамж нэмэгдсэн байна. | 100 |
| 1 6 2 | | 3. Хүнсний үйлдвэр, нийтийн хоолны аюулгүй байдалд хяналт тавьж эрсдэлийг бууруулах | 2021 - 2024 | | | Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 01/91 тоот удирдамжаар тус аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4 сургууль, 11 цэцэрлэг, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, 200 хүүхдийн Нэгдсэн дотуур байр, Эрдэнэцагаан сумын 1, 2-р цэцэрлэг, Дарьганга, Түвшинширээ, Халзан сумдын цэцэрлэг, Түвшинширээ, Улбаян, Мөнххаан сумдын сургуулиудын хоол үйлдвэрлэлийн газрууд болон сургуулийн орчинд худалдаа үйлчилгээ явуулж буй хүнсний дэлгүүрүүд хамрагдсан бөгөөд МХЕГ-ын даргын 01/91 тоот удирдамжид заасан чиглэлүүдээр урьдчилан сэргийлэх шалгалт хийж, боловсролын байгууллагуудын 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажил, сургууль, цэцэрлэгийн гадаад, дотоод орчны аюулгүй байдалд үнэлгээ дүгнэлт хийж, коронавирүст халдвар “КОВИД-19”-аас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй газар дээр нь танилцаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | 90 |
| | | | | | | Мөн 6 сумын ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолноос нэг хүүхдэд ноогдох хоолны илчлэг норм норматив хангуулахаар МХГ-н нэгдсэн лабораторид шинжлүүлэхэд 210-820 ккал илчлэгтэй гарч тус байгууллагад дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Шалгалтад хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн 71.4 хувь нь хоол зүйчтэй болсон байгаа нь хоолны жор, технологийн картад орц, илчлэг, шим тэжээллэг чанар, боловсруулах технологи бүрэн тусгаж, эрх бүхий албан тушаалтнаар батлуулан, мөрдөж ажиллаж байна.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн стандартын шаардлага хангасан зориулалтын байр 75 хувь, гал тогоо 75 хувь, зориулалтын тоног төхөөрөмжтэй 80 хувьтай тус тус хангагдсан байна. | |
| 1 6 3 | 3.3.5. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн | 1. Бэлчээрт ашиглаж байгаа худаг, уст цэгийн тооллогыг явуулж байршил, ашиглалт, эзэмшигчийг тодорхойлж бүртгэл, | 2021 - 2024 | - | - | “Умард говийн гүвээт”, “Халхын дундат тал”, “Галба-Өөш Долоодойн говь”, “Буйр нуур- Мэнэнгийн тал”, “Хэрлэн гол” зэрэг сав газрын захиргаанууд болон Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтран зөвшөөрөлгүй гаргасан гүний худгуудын судалгаа гарган энэ онд шинээр гаргасан худгуудын зөвшөөрлийг олгох тал дээр хамтран ажиллаж байна. Байгаль орчин, аялал жуулчлалын газрын худаг, уст | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээнэ. | мэдээллийн нэгдсэн сантай болох | | | | цэгийн мэдээллийн сангийн бүртгэлийг дахин хянан бэлчээрт 3071 худаг тоологдсоноос гүн өрмийн 773 ширхэг, богино яндант 171 ширхэг, бетонон хашлагат 556, энгийн уурхайн 1795 худаг байна. Үүнээс төв суурин газар 93, хөдөөд 2689 худаг ашиглагдаж байгаагийн 70 орчим хувийг энгийн уурхайн худаг эзэлж байна. | |
| 164 | | 2. Бэлчээрт шинээр гүний худаг гаргах | 2021 - 2024 | УТ,ОНТ,Төсөл хөтөлбөр - 920,0 сая | УТ-30 шрхэг<br>ОН,Төсөл-40 ширхэг | Улсын төсвийн хөрөнгөөр Эрдэнэцагаан, Мөнххаан, Халзан сумдад 4 ширхэг инженерийн хийцтэй худаг гаргах тендерт Дорнод аймгийн “Сатабу”ХХК гүйцэтгэгчээр шалгарч Мөнххаан суманд 1 худгийг гаргаад байна. Мөн Өрмийн машины түрээсээр “Төв дрилленг” ХХК 2 ширхэг уст цэгийг шинээр гаргасан. Орон нутаг, малчид иргэдийн хөрөнгөөр 15 инженерийн хийцтэй худаг, 26 ширхэг энгийн уурхайн худаг шинээр гаргаж бэлчээрийг усжуулаад байна | 100 |
| 165 | | 3. Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг зохион байгуулах | 2021 - 2024 | 128,0 сая | 80,000 | Орон нутгийн 110.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн мэрэгч амьтан үлийн цагаан оготнотой тэмцэх хаврын устгалыг Мөнххаан сум микробиологийн аргаар 3.0 мянган га талбайд 6 тн бактерийн бэлдмэлээр, Онгон сум энгийн механик биологийн аргаар 3.0 га талбайд огтоно устгалын ажлыг хийж гүйцэтгэсэн. Намрын устгалыг Баяндэлгэр, Онгон, Түмэнцогт, Түвшинширээ, Асгат сумд микробиологийн аргаар буюу бактерийн хордуулсан будаа захиалан 26.1 мянган га талбайд нийт 32.1 мянган га талбайд тэмцэх арга хэмжээг тус тус зохион байгуулсан.<br>Мөн Онгон сум шувууны 60 ширхэг суултуур, шувууны үүр 40 ширхэг тус тус байршуулсан. Түмэнцогт сум шувууны суултуур, үүр байрлуулах 100 ширхэг шон бэлдсэн. Халзан сум шувууны суултуур 29 ширхэг, шувууны үүр 15 ширхэг, алсыг харагч 10 ширхэгийг тус тус зассан. | 90 |
| 166 | | 4. Сум дундын болон сумын отрын бүс нутгийг тогтоох, хил заагийг тодорхойлж баталгаажуулах | 2021 - 2024 | 5,0 сая | 4 | Аймгийн Засаг даргын 2020 оны А/411-р захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг сум дундын болон сумын отрын нөөц нутаг тогтоох ажлыг газар дээр нь очиж тодруулан ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн болон ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхардуулахгүйгээр зураглаж тухайн сумын ИТХ-шийдвэр гарч Сүхбаатар, Наран, Дарьганга, Мөнххаан, Түмэнцогт сумдад 30 байршилд 397779.2 га газрыг сумын отрын нөөц нутгаар тогтоон зураглал мэдээллийн сан үүсгээд байгаа нь нийт бэлчээрийн 5.7 хувь байна.<br>Аймаг дундын отрын нөөц нутгийн захиргаа, Сүхбаатар сумын ЗДТГ-тай хамтран сум дундын отрын нөөц нутаг байгуулахаар судалгаа тооцоог гарган ажиллаж байна. | 100 |
| 167 | | 5. Малчдын бүлгийн оролцоонд тулгуурлан бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон | 2021 - 2024 | - | 10 | Монгол улсын Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2022-2023 оны өвөл-хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн багийн нутгаар тооцоолж гаргав. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэлчээрийг сэргээх арга хэмжээ хэрэгжүүлэх | | | | Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс хархад: Аймгийн нийт нутгийн 25.4 хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байх боломжтой тодорхой тооны мал гаднаас отроор оруулах бэлчээрийн нөөцтэй, 31.6 хувьд гаднаас отрын мал оруулах бололцоогүй тухайн багийн мал өөрийн нутагт өвөлжиж, хаваржихад бэлчээр хүрэлцээтэй, 30.2 хувьд даац 1-3 дахин хэтэрсэн, 1.5 хувьд даац 3-5 дахин хэтэрсэн, 11.3 хувьд олон дахин хэтэрсэн. Өөрөөр хэлбэл нийт нутгийн 57 хувьд өвөл-хаврын бэлчээрийн даац хүрэлцээтэй байхаар, харин 43 хувьд бэлчээрийн даац багтаамж хэтэрсэн дүн мэдээ гарсан.Сумдын ЗДТГазартай хамтран 11 суманд МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨН зохион байгуулж, цаг үеийн мэдээлэл, хууль тогтоомж, цаашид хэрэгжүүлэх ажил, бэлчээр ашиглалтыг сайжруулах, доройтсон бэлчээрийг сэргээх, сэлгэх талаар 1590 малчдад мэдээлэл хүргэн ажилласан. | |
| 168 | | 6. Сумдад өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг хадгалах агуулах, саравч шинээр барих ажлыг үргэлжлүүлэх | 2021 - 2024 | - | - | Асгат суманд малын тоо толгойн албан татвар болон Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хөрөнгөөр тэжээлийн агуулах, өвсний саравч, хашааны хамт шинээр барих ажлыг Улаанбаатар хотын “Хайлааст гарам” ХХК-аар хийж гүйцэтгүүлэн хүлээн аваад байна. Мөн Баруун-Урт сумын онцгой үед ашиглах өвс, тэжээлийн агуулах барих ажлыг “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төслийн 100 хувийн санхүүжилтээр ирэх онд барьж ашиглалтанд оруулахаар “Молцог элс” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| 169 | | 7. Сумын аюулгүйн нөөцийг бие даан бэлтгэх хүрээнд зарим сумдад хадлан бэлтгэлийн техник, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | - | - | Засгийн газрын 2021 оны 221 дүгээр тогтоолын дагуу бэлтгэсэн 1173 тн өвс аймаг, сумдын өвс тэжээлийн агуулахад хадгалагдаж байна. Шинэ хөдөө төслийн санхүүжилтээр 9 ширхэг өвс хаман боогч авч Баруун-Урт, Мөнххаан, Түмэнцогт, Наран сумдад түрээс хэлбэрээр ашиглуулахаар гэрээ байгуулсан. Мөн Сүхбаатар сум Орон нутгийн хөгжлийн сангаасаа 120.0 сая төгрөгийн үнэ бүхий том жижиг трактор тус бүр 1 ширхэг, хаман боогч, хадуур, тармуур зэрэг хадлангийн иж бүрэн тоног төхөөрөмж худалдан авсан. | 100 |
| 170 | 3.3.6. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулах, хээлтүүлэгч болон цөм сүргийг мэргэжлийн байгууллагын | 1. Жил бүр үржлийн малын 1-ээс доошгүй хувьд үзлэг ангилалт тогтмол хийж, ээмэгжүүлэн, бүртгэл мэдээллийн санд оруулах | 2021 - 2024 | 45,0 сая | 18000 | Малын үзлэг ангилалтын ажлыг сум, орон нутаг болон малчдын өөрсдийн зардлаар хийсэн. Нийт 13 сумын 139 малчин өрхийн 25752 толгой хонь, 11737 толгой ямаа, 775 толгой үхэрт нийт 38264 толгой малд үзлэг ангилалт хийсэнээс одоогийн байдлаар 9263 толгой малыг бүртгэн, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулаад байна. | 100 |
| 171 | | 2. Хавар, намар малд хийх үзлэг ангилалтад хяналт тавьж, үр дүнг тооцох | 2021 - 2024 | - | 13 | Онгон, Баруун-Урт сумдын 5 суурийн 2350 толгой малд үзлэг ангилалт, бүртгэлжүүлэлтийн ажилд хяналт тавьж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 172 | хяналтад авах, генетик нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, нэгжийн ашиг шимийг дээшлүүлнэ. | 3. Сумдад мал бордох цогцолбор байгуулах | 2021 - 2024 | 450,0 сая | 3 | 2022 онд нийт сумдад төр хувийн хэвшлээс хийгдсэн ажил байхгүй 2021 онд Зах зээл бэлчээрийн удирдлага төслөөс махны чиглэлийн үхрийн бордооны аж ахуй эрхлэх "Арга түшиг" ХХК-д 75.0 сая төгрөгийн зээлийг олгосон. Сүхбаатар сумын "Манхат баян уул" ХХК, Баруун-Урт сумын "Арга түшиг" ХХК-иуд 100 эр бяруу бордож эхлээд байна. | 50 |
| 173 | | 4. Бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтад бүрэн хамруулж анги чанарыг тодорхойлох ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | 33,1 сая | 22100 | Аймгийн хэмжээнд 13 сумын 4355 толгой хуц, 2703 толгой ухна нийт 7058 толгой бог малын хээлтүүлэгчийг үзлэг ангилалтанд хамруулж 2540 толгой бог малын хээлтүүлэгчийг мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж, мэргэжилтний хяналтад авсан. Үүнд: Мөнххаан суманд 170, Наран суманд 248, Сүхбаатар суманд 286, Түмэнцогт суманд 131, Эрдэнэцагаан суманд 428, Баруун-Урт суманд 1110, Дарьганга суманд 61, Онгон суманд 60, Эрдэнэцагаан суманд 46 толгой богийн хээлтүүлэгчийг малчид иргэдэд түрээсээр ашиглуулж байна. | 100 |
| 174 | | 5. Бог малын хээлтүүлэгчийг бүрэн ээмэгжүүлж, мэдээллийг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулах | 2021 - 2024 | 2,8 сая | 2500 | Аймгийн хэмжээнд 13 сумын 4355 толгой хуц, 2703 толгой ухна буюу нийт 7058 толгой богийн хээлтүүлэгчийг ангилан, ээмэгжүүлэн бүртгэлжүүлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулсан. | 100 |
| 175 | | 6. Мал үржүүлэг технологийн нэгж болон шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нь нэг удаагийн дэмжлэг үзүүлэх /Дэмжлэг: хуцан хурга, ухна ишиг/ | 2021 - 2024 | 50,0 сая | 5 | Энэ онд Наран, Баяндэлгэр сумдад МҮТАҮНэгж шинээр байгуулагдсан. Түмэнцогт сумын "Баян сүрэг"ХХК, Мөнххаан сумын “Баясгалант сүрэг”ХХК, Баруун-Урт сумын “Билүүт өсөх” хоршоо болон Мөнххаан сумын ХАА-н тасагт мал ангилалтын багаж, тоног төхөөрөмж болох бог малын хашаа, пүү, палкметр, лентметр, ээмэгний бахь, Сүхбаатар, Мөнххаан, Түмэнцогт сумдын МҮТАҮНэгжид тус бүр 65 толгой үзэмчин үүлдрийн хурган хуц, 50 толгой Баяндэлгэрийн улаан ишгэн ухныг ДМХХТЛБОЯБХТөслөөс олгосон. Мөн ХХААХҮ-ийн яамнаас 13 сумын Хөдөө аж ахуйн тасагт бог малын палкметр, лентметр, өргөдөг килограмм олгосон. /Дорнод монголын хуурай хээрийн ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөл/ | 100 |
| 176 | | 7. Сумдын ХАА-н тасгийн малын бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтнийг бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх боломж бүхий компьютер, тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | - | 13 | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын STREAM төсөлтэй хамтран 2022 оны 05 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд Чингис хотод “Зүүн бүсийн аймгуудын малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, түүний дэд сангуудын нэвтрүүлэлт” сэдэвт сургалт зохион байгуулагдсан. Тус сургалтад ХХААГазраас МҮАлбаны дарга, 2 мэргэжилтэн, 13 сумын ХАА-н тасгийн Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэнүүд, Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний 6 нэгжийн дарга нар нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 177 | 3.3.7. Өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үүлдрийн үхэр, гахай, шувууны эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, ашиг шимийг нь нэмэгдүүлнэ. | 1. Цэвэр үүлдрийн болон эрлийз, цус сайжирсан малын тоог нэмэгдүүлэн гадаадын өндөр ашиг шимт эцэг малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх/тариф-50.0 ₮/ | 2021 - 2024 | 12,5 сая | 250 | МУСҮТ-өөс зохион байгуулсан Бод малын зохиомол хээлтүүлэгийн сургалтанд Баруун-Урт сумын 2 мэргэжилтэнг хамруулсан. Баруун урт сумын малчид иргэдийн захиалгын дагуу 95 үнээнд Хар тарлан, Алатоу, Семминталь, Герефорд, Хар ангус үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр, Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөлтэй хамтран Сүхбаатар, Түмэнцогт сумдад 51 үнээнд Алатау, Симменталь, Герефорд үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлгийн ажил хийгдээд байна. Мөн Мөнххаан сумaнд Суффолк үүлдрийн хуцны халуун үрээр 60 толгой эм хонинд хээлтүүлэгийн ажлыг тус тус зохион байгуулсан. | 100 |
| 178 | | 2. Гойд ашиг шимт малын үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах | 2021 - 2024 | 15,0 сая | - | Намрын ногоон өдрүүд- Сүхбаатарт үйлдвэрлэв 2022 ШИЛМЭЛ МАЛ үзэсгэлэн худалдааг Баруун-Урт хотноо амжилттай зохион байгуулсан. “Бог мал”-ын төрлөөр нийт 8 сумын 15 иргэн, 5 ААН-ийн 128 толгой мал оролцсон. Үзэмчин үүлдэр, Баяндэлгэрийн улаан үүлдэр, Импорт болон зохиомол хээлтүүлгээр гаргаж авсан мал гэсэн 3 төрөлд бүдүүн хуц, төлгөн хуц, эм хонь гэсэн ангилалаар 30 номинацыг шалгаруулж байр эзлүүлсэн. | 100 |
| 179 | | 3. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийг дэмжих | 2021 - 2024 | | | ЖДҮ хөгжүүлэх сангаас Баруун-Урт сум эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 1 нөхөрлөлд 72.4сая/төг, Хоршоо хөгжүүлэх сангаас Сүхбаатар сум Тахианы аж ахуй байгуулах чиглэлээр 1 хоршоонд 85 сая/төг, Онгон сум малын хашаа, мах сүүний үхэр үржүүлэх чиглэлээр 1 ААН-д 10 сая/төг, Асгат сум эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 1 ААН-д 60сая/төг, ДМХХТЛБОЯБХТөслөөс Сүхбаатар сумын “Манхат баян уул”ХХК-д эрчимжсэн аж ахуйн чиглэлээр /үйл ажиллагаа өргөтгөх/ 75 сая/төг, нийт аймгийн хэмжээнд 4 сумын 5 аж ахуй нэгж эрчимжсэн аж ахуйг дэмжих чиглэлээр 302.5 сая төгрөгийн зээлд хамрагдсан. | 100 |
| 180 | | 4. Үйлдвэр технологийн паркийн үйл ажиллагааг өргөтгөж, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн боловсруулах төв байгуулах | 2021 - 2024 | 400,0 сая.төг | | Сүхбаатар хөгжил ҮТП" ОНӨААТҮГазрын үйл ажиллагааг тогтвортой явуулж, үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор аймгийн ИТХурлын 2021 оны 07 дугаар тогтоолоор тус газрын 2021 оны үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэн ажилласан. Мөн 2021-2024 онуудад бүтээн байгуулах жижиг дунд үйлдвэрийн тэргүүлэх салбарыг тодорхойлж, аймгийн Засаг даргын 2021 оны өдрийн А/308 дугаар захирамжаар баталгаажуулан үйлдвэрийн бүсүүдэд хөгжүүлэх талаарх чиглэлийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан. Улсын төсвийн хөрөнгөөр 600,000,000 сая төгрөгний 1-р бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажил хийгдсэн. /Жич 400,000,000 сая.төгрөгний санхүүжилт нь хийгдсэн/ | 70 |
| 181 | 3.3.8. Малын гоц халдварт, халдварт, зооноз, халдваргүй | 1. Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөр тайван байдлыг баталгаажуулах /хувиар/ | 2022 - 2024 | 3,0 сая | Судалгаа, санамсаргүй сонголт | Мал эмнэлгийн ерөнхий газраас үхрийн цээж, ямааны годрон өвчингүй тайван байдлыг Монгол улсын хэмжээнд баталгаажуулах ажлын хүсэлтийг ДМАЭМБ-д хүргүүлснээр 2018 оноос аймгуудаас дээж цуглуулж Сүхбаатар аймгаас 120 дээжинд тандалт шинжилгээг Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран хийж 2022 оны 05 дугаар сарын | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өвчнөөс урьдчилан сэргийлж, малын өвчнөөр тайван бүсийг тогтооно. | | | | оор тандалт шинжилгээ хийх | 25-нд "Үхрийн цээж өвчнөөр эрүүл, тайван" байдлыг баталгаажуулсан гэрчилгээ авсан. Мөн ямааны годрон өвчний 120 дээжинд шинжилгээ хийлгэхээр ДМАЭМБ-д хүргүүлээд байна. 2023 онд баталгаажуулах гэрчилгээ авахаар бэлтгэл ажлаа хангаад байна. | |
| 182 | | 2. Халдварт зоонози өвчний гаралтыг багасган уг өвчнөөр тайван, халдваргүй бүсээр баталгаажуулах | 2021 - 2024 | 2,0 сая | Бүс нутагт сүүлийн 10 жилийн судалгааг гарган баталгаажуулах | Халдварт зоонози бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 4813 өрхийн тугал-68403, хурга-570112, ишиг-324620 нийт 963135 төлд Штам-19-72.0 мт, Рев-1 901300 мт вакцинийг зарцуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваад байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны А/166 тушаал, аймгийн Засаг даргын А/309 тоот захирамжаар бруцеллёз өвчний тандалт шинжилгээнд 19,1 мянган хээлтүүлэгчийг хамруулж өвчлөл илэрсэн 10 тооны хээлтүүлэгчийг үржилд ашиглахгүй, засах, хөнгөлөх арга хэмжээ авахыг тухайн сумдын МЭТ-т хариуг албан тоотын хамт хүргүүлсэн ба өвчлөл өмнөх оноос 25,6 хувиар буурсан, дархлаажуулалтыг 2021 онд сайн хийж хэрэгжүүлсэнтэй холбоотой юм. 2022 онд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины үйлчилгээний хөлсний 68,0 буюу 1736,0 сая төгрөгийн урьдчилгааг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгон, вакцин хийсэн баримт материалыг МЭЕГ-т хүргүүлээд байна. | 100 |
| 183 | | 3. Эрсдэлт бүс нутгийн өвчлөмтгий мал сүргийг гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд бүрэн хамруулах | 2021 - 2024 | Дархлаажуулалтын арга хэмжээнд нийт 84.2 сая төгрөг зарцуулагдсан | - | "Шүлхий өвчин"-өөс урьдчилан сэргийлэх хавар, намрын дархлаажуулалтад 64 ажлын хэсэг 11315 малчин өрхийн үхэр 632431, гахай 291 нийт 632722 толгой мал, амьтан хамрагдаж 98.2 -н гүйцэтгэлтэй хийгдсэн. “Үхрийн арьс товруутах өвчи"-нөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 57 ажлын хэсэгт 226 хүн хүч ажиллаж 5481 өрхийн үхэр 277640, тугал 43915 нийт 321.555 толгой үхэр хамрагдсан. “Хонины цэцэг өвчин"-өөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 4 сумын өвчлөмтгий мал болох нийт 1029 өрхийн хонь 705668, хурга 21200 нийт 726868 богийг бүрэн хамруулсан. “Бог малын мялзан өвчин"-өөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Түвшинширээ сумын 9 өрхийн 4074 хонь, 3231 ямаа нийт 7307 мал хамрагдсан. | 100 |
| 184 | | 4. Шимэгчтэх өвчний халдварлалтыг бууруулах | 2021 - 2024 | ААН, малчин, мал, амьтан өмчлөгч иргэн 724,2 сая төгрөгийг эм, | 20 | Аймгийн хэмжээнд 13 суманд 52 мал угаалгын ванн бүрэн ашиглагдаж байна. Мал эрүүл мэндийн үзлэг, угаалганд 1.5 сая толгой мал амьтан хамрагдахаас 1.3 сая толгой мал хамрагдаж, 84.8 -ийн гүйцэтгэлтэй. Боловсруулалт 580.0 мянган толгой мал хамрагдахаас 538,8 мянган толгой мал хамрагдаж 92.8 -н гүйцэтгэлтэй байна. Үхрийн гуурын боловсруулалтад 86.1 мянган үхэр хамрагдахаас 74.9 мянган толгой үхэр хамрагдаж 87.0 -н гүйцэтгэлтэй хамрагдаад байна. Туулгалт 804.6 мянган толгой мал хамрагдахаас 771.9 мянган толгой мал, амьтан хамрагдаж 95.9 -н гүйцэтгэлтэй байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бодисд зарцуулсан. | | | |
| 185 | | 5. Бэлчээрийн эрүүл ахуйг сайжруулах хүрээнд ариутгал, халдваргүйтгэл хийх | 2021 - 2024 | 38,0 сая | 3,6 | Аймгийн Засаг Даргын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/172 тоот “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт болон сэг зэм устгах, халдваргүйтгэлийн аяныг зохион байгуулах тухай” захирамжын хүрээнд зүй бусын хорогдлоор үхсэн 9779 хүүр сэг зэмийг цуглуулан нэгдсэн устгалын цэгт устгаж, устгалын цэгийн 87,0 мянган м/кв, нийтийн эзэмшлийн талбай-43.1м2, хашаа, хороо-660.4 м2, өтөг бууц-237.7м2, худаг, уст цэг-34.6м2, бэлчээр- 193.8 м2, агуулах, зоорь-74.6 м2, устгалын цэг-26.4м2 нийт 1357.6 м2 талбайд халдваргүйтгэл хийгээд байна. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/51, аймгийн Засаг даргын А/145 тоот захирамжийн хүрээнд Халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулж 13 суманд удирдах ажилтан 29, малын эмч 49, жолооч 18, туслах ажилтан 42, малчин 161 нийт 281 хүний бүрэлдэхүүнтэй 18 ажлын хэсэг гарч голомтын 94,3 мянган м/кв, 410 нийтийн эзэмшлийн 452,2 мянган м.кв талбай, 150 зоорь агуулахын 180,0 мянган м/кв, 600 худаг уст цэгийн 98,2 мянган м/кв, 1360 ш хашаа хорооны 954,7 мянган м/кв, бэлчээрийн 486,0 мянган м/кв талбай, 548,1 мянган м/кв өтөг бууц, нийт 2 сая 813.5 мянган м/кв талбайд халдваргүйтгэлийн ажлыг хийгээд байна. | 100 |
| 186 | 3.3.9. Мал эмнэлгийн лабораторийн орчин нөхцөлийг сайжруулж, хувийн хэвшлийн мал эмнэлгүүдэд стандарт мөрдүүлнэ. | 1. Мал эмнэлгийн газрын барилгад их засвар хийж, лабораторийг техник, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 55.6 сая төгрөг | Шимэгч судлалын лабораторийг бүрэн тоног төхөөрөмжөөр хангах | Мал эмнэлгийн газрын барилгын цахилгаан мантажны их засварт 12.0 сая төгрөг, дуудлага үйлчилгээний 4 машины гражын дээврийн засварт 6.0 сая төгрөг, мал эмнэлгийн газрын барилгын дээврийн их засварт 15.0 сая төгрөг, дуудлага үйлчилгээний машины сэлбэг 9,2 сая төгрөг нийт 42,2 сая төгрөгийн зардлыг улсын төсвөөр хийж гүйцэтгэсэн. Байгууллагын гадна гэрэлтүүлэгийг 10.0 сая төгрөгөөр орон нутгийн санхүүжилтаар, гадна тохижилтын ажлыг 3,6 сая төгрөгөөр хамтын сангаас санхүүжүүлж хийж гүйцэтгэсэн. МЭГ нь нийт 55,6 сая төгрөгөөр барилгын гадна засвар, тохижилтын ажлыг хийж, дуудлага үйлчилгээний машины сэлбэг хэрэгсэлийг засаж бэлэн байдлыг хангах ажлыг хийж гүйцэтгэсэн. | 100 |
| 187 | | 2. Сум дундын мал эмнэлэг, ариун цэврийн анхан шатны лаборатори байгуулах | 2021 - 2024 | 150,0 сая | Мал эмнэлгийн цогцолбор байгуулах | Сум дундын мал эмнэлэг, ариун цэврийн анхан шатны лаборатори байгуулах ажил төсөл хөтөлбөрөөр хийгдэхээр төлөвлөгдөн хэлэлцэгдэж байна. Мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагааг тавих шаардлагыг тогтоох, үнэлэх, дүгнэх стандартыг суманд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох, үйл ажиллагааны хүрээг тогтоох, үйлчилгээг тэгш хүртээмж, чанартай явуулах нөхцлийг хангах, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийхийг тус тус мөрдүүлэхээр төлөвлөн 2023 онд хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 188 | | 3. Цахим системийн ашиглалтыг чанаржуулж, мал эмнэлгийн бүх ажил үйлчилгээг нэгдсэн системд оруулах | 2021 - 2024 | 2,5 | Мал эмнэлгийн ажил үйлчилгээг мал эмнэлгийн нэгдсэн системд бүрэн оруулан гүйцэтгэлээр санхүүжүүлэх | Мал эмнэлгийн нэгдсэн цахим систем нь аймгийн хэмжээнд бүрэн нэвтрэн ашиглагдаж байгаа. Нэгдсэн цахим системийг мал эмнэлгийн газрын улсын байцаагч, 13 сумын мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нар, мал эмнэлэг үйлчилгээний 56 нэгжүүд бүрэн цахим системд шилжин 100 хувь ашиглаж байна. Цахим системд 13 сумын 12095 малчин өрхийн "малын А данс"-ны мэдээлэл бүрэн бүртгэгдсэн. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээболох гоц халдварт, халдвар өвчний дархлаажуулалт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, халдваргүйтгэлийн арга хэмжээг цахим системд төлөвлөн оруулснаар мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг цахим системээс мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч нар хяналт тавин ажиллах бүрэн боломж бүрдэн ажиллаж байна. | 90 |
| 189 | 3.3.10. Шинэ технологи, инновацын ололтод суурилсан эдийн засгийн үр ашигтай орон нутгийн эко бизнес, хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг хөгжүүлнэ. | 1. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг орон нутаг, улс, олон улсын түвшинд сурталчлан таниулах зорилготой цахим катологийг ашиглалтад оруулах | 2021 - 2024 | 2 сая.төг | 100 | Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь төслийн хүрээнд Зүүн бүсийн аймгуудын аж ахуйн нэгжид үйлдвэрлэж байгаа хүнсний болон бусад бараа таниулах зорилготой "Mon biz" каталоги системийг боловсруулан Жижиг дунд үйлдвэрийн газарт хүлээлгэн өгсөн. Цахим катологит орон нутгийн бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилан таниулах зорилгоор хөтлөн явуулж байна. | 100 |
| 190 | | 2. Хөнгөн үйлдвэр эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах гадаад, дотоодын зах зээлийг өргөтгөх ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | 5 сая.төг | 6.1 | Нэгдсэн Үндсэний Байгууллагын Ерөнхий ассемблейгаас жил бүрийн 06 сарын 27-ны өдрийг "Дэлхийн жижиг дунд үйлдвэрийн өдөр" болгон тэмдэглэдэг бөгөөд тус өдрийг тохиолдуулан жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчилан таниулах, зах зээлийг тэлэх борлуулалтыг дэмжих зорилгоор Жижиг дунд үйлдвэрийн газраас "Дэлхийн жижиг дунд үйлдвэрийн өдөр-2022" арга хэмжээг Улаанбаатар хотноо 2022 оны 06 сарын 24-өөс-27-ны өдрүүдэд Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. Энэ арга хэмжээнд Чамбай фейшн" оёдлын цех оёмол бүтээгдэхүүнээр амжилттай оролцсон. . 2022 оны 10 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 272240.3 сая төгрөг, хөнгөн үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2725,4 сая төгрөг буюу 1 хувь, хүнсний үйлдвэрлэлийн салбарын нийт үйлдвэрлэл 13859.5 сая төгрөг буюу 5 хувь байна. Дотоодын салбарын нийт үйлдвэрлэл 11967.4 сая төгрөг буюу 1 пунктаар өссөн байна. | 90 |
| 191 | 3.3.11. Оюуны өмчийн патент, чанар | 1. Бүтээгдэхүүн, үйлчилгээний оюуны өмчийн патент, чанар | 2021 - 2024 | 3 сая.төг | 3 | Засгийн газрын 2018 оны 09 дүгээр 05-ны өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан “Монгол Экспорт Хөтөлбөр”-ын зорилгын хүрээнд Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар, Сүхбаатар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | стандартын баталгаатай орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ. | стандартыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагын зөвлөн туслах үйлчилгээг бизнес эрхлэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах | | | | аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн салбар танхимаас зохион байгуулж буй "Бүс нутгийн брэнд бүтээгдэхүүн экспортын чиг хандлага" сэдэвт төр хувийн хэвшлийн хамтарсан сургалт 2022-09-28-29ний өдрүүдэд зохион байгуулагдсан. Энэхүү сургалтаар бараа бүтээгдэхүүнийг экспортлоход шаардлагатай цогц мэдээлэл авсан бөгөөд гадна орон нутгийн бизнес эрхлэгчдийн хувьд аливаа хуурамч бараа, бүтээгдэхүүн борлуулагдах, түүний улмаас борлуулалт буурч бизнес эрхлэгчийн нэр хүндийг алдагдуулах зэргээс урьдчилан сэргийлж, оюуны өмчийн эрхийн хамгаалалтын ач холбогдлыг таниулан сурталчлах, цаашлаад онцгой эрхтэй брэнд бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой сургалт болсон юм. Уг сургалтад Зүүн 3 аймгийн 120 бизнес эрхлэгчид төр, хувийн хэвшлийн байгууллагууд оролцсон болно. Оюуны өмчийн газар, МҮХАҮТ-тай хамтран Европын холбоонд Монголын анхны газар зүйн зааллтай бүтээгдэхүүнийг бүртгүүлсэн туршлагын талаарх онлайн сургалтад хамрагдсан. Тус сургалтад бараа бүтээгдэхүүний нэр хүндийг илтгэх тэмдэг болох газар зүйн заалтыг бүртгүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах, хяналт тавих талаарх мэдээллийг өгсөн. Сургалтад аймгийн ЗДТГазар, ХХААГазар, МХГазрын дарга, албан хаагчид хамрагдсан. “Мөнх-Аринги” ХХК, Мөнх сайн үүд ХХК, Чамбай фейшны бэлэг дурсгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэхээр материалыг МҮХАҮТ-ын патентын газарт хүргүүлсэн. “Мөнх-Аринги” ХХК, Мөнх сайн үүд ХХК, Чамбай фейшны бэлэг дурсгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэхээр материалыг МҮХАҮТ-ын патентын газарт хүргүүлсэн. | |
| 192 | | 2. Олон улсын стандарт нэвтрүүлэх ажлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах | 2021 - 2024 | ОНТ, Төсөл хөтөлбөр, Хувийн хэвшлийн ХО | 2 | Баруун-Урт, Түмэнцогт, Мөнххаан сумдын ЗДТГазар, Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс нь олон улсын ISO 9001-2016 стандартыг нэвтрүүлэхээр бэлтгэл ажлаа ханган ажиллласан. Өнөөдрийн байдлаар Баруун-Урт, Мөнххаан сумдын ЗДТГ нь олон улсын стандартыг нэвтрүүлсэн үлдсэн хоёр байгууллага нь нэвтрүүлхээр ажиллаж байна. Стандарт хэмжил зүйн хэлтэс нь олон улсын болон үндэсний стандартын мэдээллийг өгч арга зүйгээр холбон ажилласан. | 90 |
| | | | | 3 сая.төг | | Баруун-Урт сумын Дарьт шүтээн ХХК-ны Баян тал үйлдвэр нь 2022 онд олон улсын ISO:9001-2015 стандартыг нэвтрүүлэхээр Монсерфть ххк-тай гэрээ байгуулан бэлтэл ажлыг ханган ажиллаж байна. | |
| 193 | | 3. Орон нутгийн бүтээгдэхүүний тохирлын баталгаажуулалтыг | 2021 - 2024 | ОНТ, Төсөл хөтөлбөр | 10 | Аймгийн хэмжээнд 106 аж ахуйн нэгжид орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тохирлын баталгаажуулалтыг хийсэн. Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Сүхбаатар аймгийн Соёл урлагийн газрын удирдлагууд болон | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлж, холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч сургалт зохион байгуулах | | 3 сая.төг | | сумдын соёлын мэргэжилтэнүүдэд Барааны тэмдэг, газарзүйн заалтын тухай цахим сургалтыг МХАҮТанхимын бүтээгдэхүүний патент, барааны тэмдэг, газарзүйн заалтын газрын дарга х. Дүүрэнжаргалтай хамтран зохион байгуулсан. Энэхүү сургалтаар соёл урлагийн өвлөгдөх бүтээгдэхүүнийг судалдаг биет болон биет бус өв болох "Дарьганга хийцийг" газарзүйн заалтаар хэрхэн авч үлдэх яаж патенжуулах талаарх ойлголтыг өгсөн болно. Аймгийн ЗДТГ-тай хамтран "Бизнесийн дуу хоолой" өдөрлөгийг зохион байгуулж 9 сумын худалдаа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч 160 гаруй иргэдийг хамруулсан. | |
| 194 | | 4. Үйлчилгээний байгууллагын стандартын түвшнийг ахиулах зорилгоор 2 жилд нэг удаа мэргэжлийн байгууллагуудын хамтарсан аттестатчиллын шалгалтыг үе шаттайгаар зохион байгуулах | 2021 - 2024 | ОНТ<br>3 сая.төг | 60 | Аймгийн засаг даргын 2022.06.06-ны өдрийн А/294 дүгээр захирамжаар 2022 онд Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа 8 Зочид буудлыг мэргэжлийн байгууллагын хамтарсан аттестатчилалыг хийж стандарт түвшинг тогтоон хэрэгжилтийг хангаж ажилласан. Шалгалтын үр дүнгээр Стандартын хэрэгжилт 67.1 тай байсан бол шалгалтынн үүрэг даалгаврын үр дүнд нь 5 зочид буудал стандартын шаардлага ханган 3 зочид буудал нь тохирлын гэрчилгээ аван стандартын хэрэгжилт 85.9 болсон байна. | 70 |
| 195 | 3.3.12. Экспортын баримжаатай үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 1. Экспортын гэрчилгээтэй бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлж, стандартын бодлогоор дэмжих ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | ОНТ<br>10сая.төг | 5 | Баруун-Урт сумын "Дарьт шүтээн" ХХК-ний "Баян тал" махны үйлдвэр нь Иран улсад 160.0 тн хурганы мах, адуу үхэр, хонины 240.0 тн, нийт 400.0 тн мах экспортолсон. Дээрх үйлдвэр нь 2022 онд Улсын “Намрын ногоон өдрүүд“ үзэсгэлэн худалдаанаас “Шилдэг мах / хурга/ экспорлогч”-оор, “ Сүхбаатар хөгжил” арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан “ Эрүүл хүнс” үзэсгэлэн худалдаанд “Орон нутгийн бренд бүтээгдэхүүн”-ээр шалгарсан. /бренд бүтээгдэхүүний гэрчилгээ/ Улаанбаатар хот, Өмнөговь аймагт салбар агуулах, дэлгүүр нээж, нийслэлийн болон орон нутгийн хүн амын махны хэрэгцээг хангаж ажиллаж байна. | 100 |
| 196 | 3.3.13. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд олгосон санхүүжилтийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | 1. Сум хөгжүүлэх сан, ЖДҮ сан, Төсөл хөтөлбөрийн хүрээн дэх хөнгөлөлттэй зээл олголтыг орон нутгийн үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан олгож, ажлын байрыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 500.000.0 | | Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын дагуу Баруун-Урт сумын “Жаргал дата ХХК” хүлэмжийн аж ахуй 33,836,000 /гучин гурван сая найман зуун гучин зургаан мянган/ төгрөг, “Билэгт тусч хүү” эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 72,400,000 /далан хоёр сая дөрвөн зуун мянган/ төгрөг буюу нийт 106, 236,000 /зуун зургаан сая хоёр зуун гучин зургаан мянган/ төгрөгийн зээлийг олгосон. ЖДҮГазраас Баруун-Урт сумын 2 иргэн арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцлөөр авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Мөн “ Хийморь Сүхбаатар” Мах импекс ХХК өдөрт 200 бод, 1000 бог мал төхөөрөх хүчин чадалтай, экспортын чиг баримжаатай махны үйлдвэр шинээр байгуулагдаж нийт 10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Тус үйлдвэр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулагдсанаар 110 ажлын байр шинээр бий болно. ЖДҮГазраас Баруун-Урт сумын 2 иргэн арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцлөөр авч үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Нийт 489.4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 39 ажлын байр бий болсон. | |
| 197 | | 2. Мах, ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах аж ахуй нэгжийн санаачилгыг хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэмжих | 2021 - 2024 | "Дөрвөн гэгээн эрдэнэ" ХХК-ний өөрийн хөрөнгө 1,3 тэрбум төгрөг | | Баруун-Урт сумын "Дөрвөн гэгээн эрдэнэ" ХХК-ний Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-г АХБанкны төслөөр боловсруулсан. Тус компани нь 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр үйлдвэрийн барилгыг барьж, тоног төхөөрөмжийг БНХАУ-аас захиалаад байна. СХС-аас Асгат, Баруун-Урт, Уулбаян, Түмэнцогт сумдын 6 иргэн мах боловсруулах, эсгий үйлдвэрлэл, нэхий боловсруулах, суран эдлэлийн чиглэлээр нийт 86.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан.Малчдын цаг, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Share Mongolia, Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшаф, биологийн олон янз байдлын төсөлтэй хамтран “Ноосны зах зээлийн өдөрлөг”-ийн хүрээнд “Хонины ноос хяргах технологийн 5 хоногийн сургалтыг Мөнххаан сумын 2 багт зохион байгуулж 27 малчинг хамруулсан. Сургалтад хамрагдсан малчдад “Хяргагч машинаар хонь хяргах” гарын авлага, хонь хяргагчийн гэрчилгээ олгосон. "Ашид баянмөнх" хоршоонд хонь ноос хяргах машиныг иж бүрдлийн хамт олгосон. Мөн “ Хийморь Сүхбаатар” Мах импекс ХХК өдөрт 200 бод, 1000 бог мал төхөөрөх хүчин чадалтай экспортын чиг баримжаатай махны үйлдвэр шинээр байгуулагдаж нийт 10 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Тус үйлдвэр байгуулагдсанаар 110 ажлын байр шинээр бий болно. | 90 |
| 198 | 3.3.15. Бизнес эрхлэгчдэд бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх бизнес инкубаторын үйлчилгээг нэвтрүүлнэ. | 1. "Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх" аймгийн дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх | 2021 - 2024 | 1,6 сая.төг | | Жижиг дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөрийг орон нутагт 2021-2024 онд хэрэгжүүлэх 7 зорилт, 31 арга хэмжээтэй төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний биелэлт 65 хувьтай хэрэгжиж байна. | 70 |
| 199 | | 2. Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | 8,0 сая.төг | | Номин холдинг ХХК-ийн 30 жилийн ойн хүрээнд дотоодын жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих зорилгоор "21- АЙМАГ-21 БРЭНД" хөтөлбөрийн хүрээнд Халзан сумын "Таанын сорс” бүтээгдэхүүн шалгарч, Номин сүлжээ дэлгүүрийн байнгын ханган нийлүүлэгч болсон. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.11 Оюуны өмчийн патент, чанар стандартын баталгаатай орон нутгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, 3.3.11.1 Бүтээгдэхүүн үйлчилгээний оюуны өмчийн патент, чанар стандартыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагын зөвлөн туслах үйлчилгээг бизнес эрхлэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулах, 3.3.11.3 Олон улсын стандарт нэвтрүүлэх ажлыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах Засгийн газрын 2018 оны 09 дүгээр 05-ны өдрийн 278 дугаар тогтоолоор баталсан “Монгол Экспорт Хөтөлбөр”-ын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зорилгын хүрээнд Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар, Сүхбаатар аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн салбар танхимаас зохион байгуулж буй "Бүс нутгийн брэнд бүтээгдэхүүн экспортын чиг хандлага" Зүүн бүсийн анхдугаар чуулганы хүрээнд бизнес эрхлэгчдэд зориулж Экспортын кластерын боломж, Оюуны өмчийн эрхийн хамгаалалт, газар зүйн заалт зэрэг сургалтууд 2022 оны 09-р сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд уг сургалтад нийт 3 аймгийн 120 бизнес эрхлэгчид болон төрийн албан хаагчид оролцсон юм. Энэхүү сургалтаар бараа бүтээгдэхүүнийг экспортлоход шаардлагатай цогц мэдээлэл авахаас гадна орон нутгийн бизнес эрхлэгчдийн хувьд аливаа хуурамч бараа, бүтээгдэхүүн борлуулагдах, түүний улмаас борлуулалт буурч бизнес эрхлэгчийн нэр хүндийг алдагдуулах зэргээс урьдчилан сэргийлж, оюуны өмчийн эрхийн хамгаалалтын ач холбогдлыг таниулан сурталчлах, цаашлаад онцгой эрхтэй брэнд бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой сургалт болсон. . “Мөнх-Аринги” ХХК, Мөнх сайн үүд ХХК, Чамбай фейшны бэлэг дурсглаын бүтээгдэхүүнийг бүртгүүлэхээр материалыг МҮХАҮТ-ын патентын газарт хүргүүлсэн. | |
| 200 | | 3. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг өргөтгөх, харилцан туршлага солилцох зорилгоор гадаад, дотоодын үзэсгэлэн худалдаа, туршлага судлах аялал, бусад арга хэмжээнд дэмжин оролцуулах | 2021 - 2024 | Мерит төслийн санхүүжилт Зүүн бүсийн брэнд бүтээгдэхүүн, экспортын чиг хандлага-Аймгийн засаг даргын мөрийн хөтөл | | Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор АЗДТГ, Худалдаа аж үйлдвэрийн танхим, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагаас “Жижиг, Дунд Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, (ЖДБ)-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжиж буй Бэст төсөлтэй хамтран “Бизнес хөгжил-Автобустай аялал” арга хэмжээг Хэнтий аймагт зохион байгуулж, 40 бизнес эрхлэгч сургалтад хамрагдан, туршлага судалсан. Мерит төсөл орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой туршлага судлах, танилцах аялалд 2022 оны 09-р сарын 20-21-ний өдрүүдэд Сүхбаатар аймгаас төр хувийн хэвшлийн 5 иргэн хамрагдаж, Төв аймгийн Баянчандмань суманд Дорнод, Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнүүд туршлага судлах аялалд оролцсон. Тус арга хэмжээнд Баянчандмань суман дахь “Сүүн Далай оргил” хоршоо, “Чандмань” хүлэмжийн аж ахуй, “Чандмань” нойтон салфетаны, “МОН-ЭГГ” өндөгний үйлдвэрүүд болон Улаанбаатар хотын Цэвэр хөрсний шим дундын хоршооны тэргүүн туршлагатай танилцаж бүтээгдэхүүний уул уурхайд хэрхэн нийлүүлдэг, хүндрэл бэрхшээл, нутгийн захиргааны байгууллагатай хэрхэн хамтран ажилладаг, бүтээгдэхүүний чанар стандартад ямар сайн туршлага нэвтрүүлсэн зэрэг арга хэмжээтэй танилцаж санал солилцож ажилласан. Зүүн бүсийн брэнд бүтээгдэхүүн, экспортын чиг хандлага” сэдэвт бүсийн чуулганыг зохион байгуулж 120 гаруй бизнес | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | бөрийн үйл ажиллагааны зардал-8 сая.төг | | эрхлэгч, 11 суманд Малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж 1590 малчид оролцсон. | |
| 201 | | 4. Сүхбаатар хөгжил арга хэмжээний хүрээнд "Эрүүл хүнс", "Алтан намар","Сүхбаатарт үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулах | 2021 - 2024 | ######## | | Малчид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээллийг олон нийтэд танилцуулах, үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх, харилцан туршлага солилцуулах, аймгийн шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор Аймгийн засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн А/495 дугаар захирамжаар баталсан “Намрын ногоон өдрүүд - Үндэсний үйлдвэрлэл -2022” арга хэмжээний хүрээнд “Эрүүл хүнс”, “Алтан намар”, ”Сүхбаатарт үйлдвэрлэв” , “Шилмэл мал” үзэсгэлэн худалдааг 2022 оны 09 дүгээр сарын 28-29 өдрүүдэд 13 дахь жилдээ Баруун-Урт сумын төвд зохион байгуулж 10 номинациар шилдэгүүдээ тодруулж сумын дүнгээр Халзан сум тэргүүн байр, Мөнххаан сум дэд байрыг эзэлсэн. Сүхбаатар аймаг түүхэнд анх удаагаа үзэсгэлэн худалдааныхаа хүрээг тэлж Монгол Улсын зүүн бүс буюу Хэнтий, Дорнод, Сүхбаатар гэсэн 3 аймгийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэн танилцуулах зорилгоор хамтарсан брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг өргөн цар хүрээг хамруулж зохион байгуулсан. Нийт 13 сумын 125 үйлдвэр эрхлэгчид 110 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож нийт 131,648,000 /нэг зуун гучин нэгэн сая зургаан зуун дөчин найман мянга/ төгрөгний борлуулалтын орлого олсон байна. Үржлийн малын үзэсгэлэн, гойд ашиг шимт мал шалгаруулах, үнэ хаялцах дуудлага худалдаанд 8 сумын 20 иргэн аж ахуй нэгжийн 128 толгой мал оролцож 8-н төрлөөр 32 гойд ашиг шимт малыг шалгаруулж дүнг нэгтгэн гаргасан. 14 хурган хуц 4 ишгэн ухна борлуулж нийт 4,200,000 мянган төгрөгний борлуулалтын орлого олсон. | 100 |
| 202 | | 5. Бизнес эрхлэгчдэд инкубаторын үйлчилгээ үзүүлэх | 2021 - 2024 | | | "Сүхбаатар хөгжил-ҮТП" ОНӨААТГазрын бизнес инкубатор төвд сүүн бүтээгдэхүүн, нарийн боов, хэрчсэн гурил, хагас боловсруулсан бүтээгдэхүүний цех, оёдол зэрэг үйл ажиллагааг явуулж буй 7 үйлдвэр эрхлэгчдийг бойжуулах, түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлж байна. | 100 |
| 203 | 3.3.16. Орон нутгийн бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, хоршоодын | 1. Хоршоодоор дамжуулан хөдөө аж ахуйн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийг хийж, аймгийн | 2021 - 2024 | | | Жижиг, дунд үйлдвэрийн газар, ЗЗББУХ төсөл, Монголын ХАА-н хоршоологчдын үндэсний холбоотой хамтран Хоршоодтой зээлийн гэрээ байгуулах, хоршооны тухай хуулийг сурталчилан таниулах, загвар хоршооны үйл ажиллагаатай танилцах арга хэмжээнд орон нутгийн 2 хоршооны 8 төлөөллийг хамруулсан. /эм 6, эр 2/ Энэ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэн нийлүүлэлт, үйлдвэрлэл, борлуулалтын тогтолцоог кластерын системээр хөгжүүлнэ. | хэмжээнд хоршоодыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах | | | | хүрээнд хөдөө аж ахуйн биржийн ложистик төв, ‘Цэвэр хөрсний шим” дундын хоршоо, “Жаргалант сүү” загвар хоршооны үйл ажиллагаатай танилцаж, харилцан туршлага солилцсон. Мөн Монгол улсад хоршоолох хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газраас зохион байгуулсан хоршоодыг туршлага судлуулах аялал, сургалтад Түмэнцогт суманд мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Төгс лхүмбэ” хоршооны 3 гишүүнийг хамруулсан. Хоршооны тухай хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хөдөө аж ахуйн хоршоодын хөгжлийг эрчимжүүлэхээр Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндсэний холбоо, "Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөл"-тэй хамтран Түмэнцогт, Сүхбаатар, Мөнххаан сумдад хоршооны талаарх анхан шатны сургалтыг хоршоод болон иргэд зохион байгуулсан. Хөдөө аж ахуйн бирж, ХХААГ хамтран "Хоршооны хөгжлийг дэмжих жил -2022" ажлын хүрээнд хоршоодыг чадавхжуулах сургалтад 30 хоршоодын төлөөлөл, сумдын, хоршоо хариуцсан мэргэжилтнүүд оролцож “Хоршоо биржийн арилжаанд оролцох боломж, үр ашиг” сэдвээр мэдээлэл, танилцуулга, мэдээлэл хийсэн. Хоршоод биржийн байнгын бус гишүүнээр бүртгүүлж, гэрээ байгуулснаар өөрсдийн бэлтгэсэн түүхий эдээ биржээр дамжуулан арилжиж үндэсний үйлдвэрт чанар, стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг хангах боломжтой болсон. | |
| 204 | | 2. Загвар хоршоо байгуулах | 2021 - 2024 | 170.0 сая.төг | | Хөдөө аж ахуйн бирж, ХХААГ хамтран "Хоршооны хөгжлийг дэмжих жил -2022" ажлын хүрээнд хоршоодыг чадавхжуулах сургалтад 30 хоршоодын төлөөлөл, сумдын, хоршоо хариуцсан мэргэжилтнүүд оролцож “Хоршоо биржийн арилжаанд оролцох боломж, үр ашиг” сэдвээр мэдээлэл, танилцуулга, мэдээлэл хийсэн. Хоршоод биржийн байнгын бус гишүүнээр бүртгүүлж, гэрээ байгуулснаар өөрсдийн бэлтгэсэн түүхий эдээ биржээр дамжуулан арилжиж үндэсний үйлдвэрт чанар, стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг хангах боломжтой болсон. ЖДҮГ-аас Хоршооны улсын зөвлөгөөнийг Хэнтий аймгийн Баян-Овоо суманд зохион байгуулсан Загвар хоршооны туршлага судлах, хоршоологчдын чадавхжуулах арга хэмжээг. Тус арга хэмжээнд ҮХҮАлбаны дарга, Баруун-Урт сумын Алтанцацал хоршоо, Баянмөнх ундрах хоршоо, Түмэнцогт сумын Эв нэгдэл хамтын хоршоо, Түвшинширээ сумын Бат бэх найрамдал хоршоодын дарга, гишүүд оролцож туршлага судалсан. Мөнххаан сумын “Ашид баян мөнх” хоршоог загвар хоршоо болгон хөгжүүлэхээр 2021 онд ЖДҮГаас 110.0 сяа төгрөгийн хөнгөлөлттэй зээл, 2022 онд Орон нутгаас 45.0 сая төргөг, ДМХХТөслөөс 15.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн олгосон. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 205 | 3.3.17. Бизнесийн салбарын техник туслалцааны зөвлөх үйлчилгээг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. | 1. Бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг чанаржуулах, бизнес төсөл боловсруулах чадварыг дээшлүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай хамтран техник туслалцааны ажлыг нэвтрүүлэх | 2021 - 2024 | MERIT төслийн санхүүжилт | | MERIT төсөлтэй хамтран “Уул уурхайн компаниудад үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл солилцох, харилцан туршлага хуваалцах" уулзалт Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан. Уг уулзалтад Жижиг, дунд үйлдвэрийн газар, ШУТИС-Бизнесийн Удирдлага, Хүмүүнлэгийн сургууль, Дундговь, Дорнод, Төв, Сүхбаатар аймаг, орон нутгийн бизнес эрхлэгчид, уул уурхайн компанид үйлчилгээ үзүүлэгч аж ахуйн нэгжүүдийн 10 төлөөлөл оролцсон. Уул уурхайн компаниудад орон нутгийн аж ахуйн нэгжүүдээс нийлүүлж буй ажил үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Өмнөговь аймгийн Угтуул инвест, Эколожикал технологи, Ханбогд хурд ХХК-иуд өөрсдийн үйл ажиллагаа туршлага мэдээллээ хуваалцсан. Мөн "Жижиг дунд бизнес эрхлэгчдэд зориулсан МОДУЛЬ-III" сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад ШУТИС-ийн БАТС-ийн багш нар бизнесийн удирдлагын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, уул уурхайн бэлтгэн нийлүүлэгч болох боломжийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх мэдлэг чадварыг олгосон Сургалтад Эрдэнэцагаан, Сүхбаатар, Уулбаян, Түмэнцогт, Асгат, Баруун-Урт сумын ХАА-н тасгийн мэргэжилтэн, 32 бизнес эрхлэгчид оролцлоо. | 100 |
| 206 | 3.3.18. Бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлнэ. | 1. ТХХЗөвлөлийн үйл ажиллагааг өргөжүүлэн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | | Зүүн бүсийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангахад хувийн хэвшлийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар тогтоолоор ТХХЗөвлөлийн бүрэлдэхүүн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталсан. Төслийн багаас ТХХэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд ТХХХамтын ажиллагааны үр дүнд Сүхбаатар аймагт ноос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮГ боловсруулан "Дөрвөн гэгээн эрдэнэ" ХХК-д хүлээлгэн өгсөн. | 90 |
| 207 | 3.4.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулна. | 2. Аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн дунд хугацааны стратегийг боловсруулан, хэрэгжүүлэх | 2022 - 2024 | 10 сая | 50 | 2021 онд Монголиан гайд турс ХХК-тай хамтран Аймгийн аялал жуулчлалын нөөц даацын судалгаа хийсэн. Судалгааны баг тус аймгийн Сүхбаатар сумын Нийгмийн хонгор цогцолбор, Дарханхаан уул, Эрдэнэцагаан сумын Дугнагарын хүн чулуу, Жаргалантын ширээний цогцолбор, Бичигт хилийн боомт, Лхачинвандад уул, Зотол хаан уул, Егүзэр хутагтын хийд, Дарьганга сумын Талын агуй, Гөхлийн ширээний хүн чулуу, Бичигтийн шахаа, Хөргийн хөндий, Торой банди, Ганга нуур, Алтан овоо, Онгон сумын Шивээтийн хүн чулуу, Шар бүрд, Баяндэлгэр сумын Онгон таван булаг, Хужиртын хавцал, Түвшинширээ сумын Дэлгэрхаан уул, Халзан сумын Зэрлэг ан амьтан судлах кемп, Хатавчийн хавцал зэрэг газруудаар 7 хоног хээрийн, Уулбаян, Мөнххаан, Түмэнцогт, Асгат, Наран сумдаас утсаар мэдээлэл авч судалгаа хийсэн. Нөөц даацын судалгааг хийснээр аймгийн аялал жуулчлалын зорин очдог голлох газруудыг цаашид хархэн сайжруулах, бусад газруудыг зах зээлийн эргэлтэд оруулах, аялал жуулчлалын шинэ ямар нөөц боломж байгаа, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | амралтын газруудын нүхэн жорлонг хэрхэн өөрчлөх, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа, хүний нөөцийг хэрхэн чадавхжуулах, шинэ аяллын маршрутыг гаргаж, цаашид шинээр ямар төрлийн аяллуудыг хөгжүүлэх боломжтой талаар зөвлөмж боловсруулсан нь үр дүнтэй болсон. | |
| 208 | | 3. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ-д зөвлөх үйлчилгээний сургалт зохион байгуулж, стандартын түвшнийг нэмэгдүүлэх | 2022 - 2023 | 3.2 сая | 80 | Нью жуулчин турс ХХК-ны дэргэдэх Аялал жуулчлалын ур чадварын сургуультай хамтран аймгийн хэмжээнд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага /Жуулчны бааз, зочид буудал, ресторан, зоогийн газар /-ын албан хаагчдад зөвлөх үйлчилгээний сургалт зохион байгуулсан. Сургалтад 4 зочид буудал, 3 жуулчны баазад ажлын байран дээр зөвлөн туслах үйлчилгээг авсан ба дараах дутагдлууд гарсан. Үүнд: өрөөний цэвэрлэгээ үйлчилгээ, зочдын аюулгүй байдал, орны цагаан хэрэглэл, матраас, урсгал засвар, цэвэрлэгээний бодис, ариун цэврийн өрөө, байгууламж зэргийг сайжруулах гэх мэт. | 100 |
| | | | | | | Мөн аймгийн Засаг даргын 2022 оны А/294 тоот захирамжийн дагуу байгууллагуудын хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж төлөвлөгөөт шалгалт 1, гүйцэтгэлийн шалгалт 1, нийт 2 удаагийн нэгдсэн хяналт шалгалтыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Шалгалтад нийт 8 ААН хамрагдаж стандартын хэрэгжилт 67.1 хувьтай үнэлэгдэж 8 ААНБ -д улсын байцаагийн албан шаардлагыг хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилласнаас гүйцэтгэлээр 5 зочид буудал стандартын шаардлага ханган, 3 зочид буудал нь тохирлын гэрчилгээ авч хэрэгжилт 85.9 болсон байна. | |
| 209 | | 5. Аялал жуулчлалын бүс бүрд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, нүүдлийн соёл иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал, шувуу ажиглах, язгуур урлаг, өв соёлын арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | | | ХУНГИЙН БАЯР-2022" арга хэмжээ 10 дугаар сарын 21-нд Ганга нуурын хөвөөнд зохион байгуулагдсан. Энэ удаагийн арга хэмжээнд Дарьганга хошууны 6 сум гэгдэх Наран, Онгон, Баяндэлгэр, Асгат, Халзан сумдын Соёлын төв, соёлын биет бус өв тээгч нар оролцохоос гадна Дарьгангын намар фото зургийн уралдаан, Дарьганга бэлэг дурсгалын шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах уралдаан, Хунгийн баяр үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдсан. Энэхүү арга хэмжээг зохион байгуулснаар Дарьганга өв соёлыг олон нийтэд сурталчилсан, соёлын биет бус өв тээгч нар өөрсдийн авьяас чадвараараа бахархасан, гар урлалынхан бүтээгдэхүүнээ борлуулсан, 5000-6000 хүн шувуу харж эх орноороо бахархах зэрэг ач холбогдолтой арга хэмжээ болсон. | 100 |
| | | | | | | Агтана хүрээт хүлэгч эрсийн наадам энэ жил 4 жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. энэ удаагийн арга хэмжээнд 7 аймгийн 50 гаруй адуучин, 15 хос морьтон оролцож авхаалж самбаа, ур чадвараараа өрсөлдлөө. Арга хэмжээний үеэр Адуучин тэмцээн, хос морьтон, удамт монгол гүүний дуудлага худалдаа, хүлэг морь алдаршуулах, сур харваа зэрэг арга хэмжээ болсон. Агтана хүрээт хүлэгч эрсийн наадмыг үзэхээр 1500 орчим хүн хуран цугласан томоохон арга хэмжээ болсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 210 | | 6. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх гадаад жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх | 2022 - 2024 | | 1 | Цайны зам олон улсын аялал жуулчлалын холбооны хурал цахим хэлбэрээр зохион байгуулж, хуралд Монгол, Хятад, Орос гурван улсын салбарын дарга нар болон Нийслэлийн аялал жуулчлалын газар, Сүхбаатар аймаг, Өмнөговь аймаг, Дорнод аймаг, Дорноговь аймаг оролцож шинээр энэ удаагийн хурлаар Монгол улсын Хэнтий аймаг, Говьсүмбэр аймаг, ОХУ-ын Хабаровскийн хязгаар орон, Приморийн хязгаар орон зэрэг аймаг мужууд гишүүнээр элсэн орлоо. Мөн хурлаар холбооны дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах, соёлын солилцоо, эдийн засаг худалдааны солилцоог ахиулах тодорхой арга хэмжээнүүдийг хэлэлцсэн юм. Тус хуралд аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, АЗДТГ-ын Гадаад харилцаа, боомт хариуцсан орон тооны бус зөвлөх, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, мэргэжилтэн, Тал нутгийн өнгө аялал жуулчлалын холбооны тэргүүн нар оролцсон. | 100 |
| 211 | | 7. Эрдэнэцагаан суман дахь 80 ортой зочид буудлыг бүрэн ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулах | 2022 - 2024 | | | Тодорхой ажил хийгдээгүй байна. | 0 |
| 212 | 3.4.2. Аялал жуулчлалын маркетинг сурталчилгааг өргөжүүлнэ. | 1. Үйлчилгээний байгууллага, иргэдэд аялал жуулчлалын менежментийн талаар боловсрол олгох, тэдний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, үзэсгэлэнд оролцуулах | 2021 - 2024 | 9 сая | | Монголын Аялал Жуулчлалын Холбоо, Байгаль Орчин аялал жуулчлалын яамтай хамтран 2022 оны 10 дугаар сарын 28-аас 30-ний өдрүүдэд “International Travel Mart 2022” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг “Шинэ сэргэлт – Аялал жуулчлал” уриан дор 23 дахь жилдээ аялал жуулчлалын бизнес эрхлэгчид хоорондоо туршлага хуваалцах, туршлага судлах, харилцагчид хоорондын уялдаа холбоо, түншлэлийн харилцааг батжуулах, мэдээ мэдээллээр хангагдах, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, оновчтой гарц гаргалгааг эрэлхийлсэн олон талт боломжуудыг бий болгосон онцлогтой зохион байгуулагдсан. Тус үзэсгэлэнд Сүхбаатар аймгаас Аймгийн Засаг даргын тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Тал нутгийн өнгө аялал жуулчлалын холбоо, Мөнххаан сумын Аринги брэнд, Дарьганга сумын зураач Б.Энхмаа, Баруун-Урт сумын Баяншарга ХХК, Дөш брэнд, Мөнх сайн үүд ХХК, Чамбай брэнд, Улаанбаатар хотоос Агтана хүрээт төсөл хамтран оролцож бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчлан ажилласан. Үзэсгэлэнд 830 ширхэг брошюр, 100 ширхэг газрын зураг, 210 ширхэг товхимол тараагдсан. Тус үзэсгэлэнд 26 төрлийн нийт 130 гаруй ширхэг бүтээгдэхүүнээр оролцсон. | 100 |
| 213 | | 2. Аймгийн аялал жуулчлалыг сурталчилсан ном товхимол хэвлүүлж, | 2022 | | 800 | Аялал жуулчлалын газрын зургийг шинэчлэн хэвлүүлэхээр Улаанбаатар хотын Эм Пи Эм ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Газрын зураг нь Монгол, Англи хэл дээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах | | | | 2000 ш хэвлэгдэн гарна. Газрын зураг Англи хэл дээр хэвлэгдсэнээр гадаадын жуулчид мэдээллийг түргэн шуурхай авах боломж бүрдэнэ. | |
| 214 | | 3. Аялал жуулчлалын холбооны үйл ажиллагааг эрчимжүүлэх | 2022 - 2024 | 7.5 сая | | Сүхбаатар аймагт анх удаа төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Тал нутгийн өнгө аялал жуулчлалын холбоог 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус холбооны зүгээс бусад аймаг, нийслэлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээтэй танилцах, туршлага судлах, аймаг орон нутгаа сурталчлах хүрээнд Ай Ти Эм-2022 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцсон. Мөн холбооны гишүүдийг чадавхижуулах, аялал жуулчлалын мэдээ мэдээллээр хангах зорилгоор 2022 оны 11 сард Хэнтий аймагт зохион байгуулагдсан "Зүүн бүсийн аялал жуулчлалын зөвлөгөө"-нд оролцуулсан. | 90 |
| 215 | | 4. Орон нутгийн өв соёлыг сурталчлан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулж, тогтмолжуулах | 2021 - 2024 | | | Аймгийн хэмжээнд Аялал жуулчлалын 3 эвентийн хүрээнд 9 төрлийн арга хэмжээ зохион байгуулагдаж, нийт давхардсан тоогоор 4000 гаран дотоодын жуулчид оролцсон байна. Үүнд: | 100 |
| | | | | | | -Жил бүрийн 1 сарын 1-ний өдөр “Талын нар харах авто аялал”-д 1600 иргэд оролцож өв соёлыг дэлгэрүүлэх үүднээс залуучуудын дунд сээр цохих, уулын орой булаалцах, тэмцээн зохион байгуулсан. | |
| | | | | | | -“Агтана хүрээт хүлэгч эрсийн наадам” нь 4 дэх жилдээ амжилттай зохион байгуулагдлаа. Энэ жилийн онцлог нь Адуучин тэмцээн, хос морьтон, удамт монгол гүүний дуудлага худалдаа, хүлэг морь алдаршуулах, сур харваа зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулагдаж 1500 орчим жуулчид оролцсон байна. Мөн Адуучин тэмцээнд 7 аймгийн 50 гаруй адуучин, 15 хос морьтон оролцсон нь энэхүү эвент арга хэмжээ дотоодын болоод гадаадын жуулчдын хүлээлтийг үүсгэж орон нутгийн болоод ард иргэдийн оролцоо нэмэгдэж үр дүнгээ өгч байна. | |
| | | | | | | -ХУНГИЙН БАЯР-2022” арга хэмжээ 10 дугаар сарын 21-нд Ганга нуурын хөвөөнд зохион байгуулагдсан. Энэ удаагийн арга хэмжээнд Дарьганга хошууны 6 сум гэгдэх Наран, Онгон, Баяндэлгэр, Асгат, Халзан сумдын Соёлын төв, соёлын биет бус өв тээгч нар оролцсоноос гадна Дарьгангын намар фото зургийн уралдаан, Дарьганга бэлэг дурсгалын шилдэг бүтээгдэхүүн шалгаруулах уралдаан, Хунгийн баяр үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдсан. | |
| 216 | 3.4.3. Аялал жуулчлалын бүс нутаг дахь орчны бохирдлыг бууруулна. | 1. Аялал жуулчлалын бүс нутагт эко ариун цэврийн байгууламж /00/ байгуулах | 2022 - 2024 | 53,6 сая | 3 | БОАЖС-ын 2022 оны 06 дугаар албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах, аялал жуулчлалын бүс нутагт эко ариун цэврийн байгууламж байгуулах зорилтын хүрээнд Дарьгангын БЦГазар болох Ганга нуурт улсын төсвийн 43.6 сая төгрөг, Алтан Овооны энгэрт Дарьгангын БЦГХЗ-ны 10,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар эко ариун цэврийн байгууламж байгуулсан. | 100 |
| | | | | | | Мөн БОАЖС-ын 2022 оны Усан сан бүхий газарт ашиглаж буй нүхэн жорлонг цэгцлэх тухай 11 дүгээр албан даалгаврын хүрээнд аймгийн Засаг даргын 2022 оны А/523 дугаар захирамж гаргаж ажлын хэсэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулан, төлөвлөгөө гарган ажилласан. Аймгийн хэмжээнд усан сан бүхий газарт 7 сумын 40 гаруй ААНБ, 300 гаруй айл өрх хөрс бохирдуулагч нүхэн жорлонтой гэсэн судалгааг гаргаж айл өрх, ААНБ-уудад зөвлөмж нөлөөллийн ажил хийж байна. Уг ажлын хүрээнд "Хаягдал усыг дахин ашиглах шинэ дэвшилтэт техник технологи, эко ариун цэврийн байгууламж, ногоон зээл”-ийн талаар МХГ, Баруун-Урт сумын ЗДТГ, Дөрвөлж ОНӨК, мах боловсруулах үйлдвэрүүд, цэвэр усны үйлдвэр, ШТС, авто угаалга, амралтын газрын 28 ААН-ын төлөөллүүдэд сургалт зохион байгууллаа. Сургалтад ШУТИС-ийн доктор Д.Басандорж, докторантур Г.Ариунаа, “Эколос Алтай” ХХК уриалгаар оролцлоо. Сургалтаар ААНБ-ууд хаягдал усыг цэвэрлэх болон ашиглах арга замууд, эко био жорлонгийн талаар тодорхой ойлголттой болсон. | |
| 217 | | 2. Хог хаягдлыг бууруулах чиглэлээр мэдээллийн самбар байршуулж, нөлөөллийн ажил хийх | 2022 - 2023 | 4,0 сая төг | 3 3 | АЖ-ын бүс нутагт дахь Хог хаягдлыг бууруулах чиглэлээр аймгийн хэмжээнд 4 сумын 12 байршилд 12ш мэдээллийн самбарыг хийж байршуулсан. Үүнд: Асгат сумын Их ууланд 1 ш, Наран сум 6 ш, Баяндэлгэр 2 ш, Түвшинширээ сум 3 ш самбар тус тус хийлгэсэн. Мөн дотоод гадаадын жуулчдын аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 1000 ш гарын авлагыг хийлгэж хот хоорондын төв замд байрладаг постын дээр тараан ажиллаж байна. Тараах материалд уул овоонд хүндэтгэл үзүүлэх ёс, аяллын маршрут, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, зочид буудал, баазын утасны дугаар зэрэг мэдээлэл багтсан. | 100 |
| 218 | 3.6.1. Аймгийн төвийн болон сумдын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 1. Баруун-Урт хотын үерийн ус зайлуулах далан сувгийг барих | 2021 - 2024 | | | Монгол Улсын Барилга, хот байгуулалтын сайдаар ахлуулсан барилгын яамны ажлын хэсэг 2022 оны 9 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд ажиллах үеэрээ улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудтай танилцаж, орон нутгийн удирдлагуудын тавьсан Баруун-Урт сумын үерийн сувгийн ТЭЗҮ зураг төслийн зардлыг 2023 оны сайдын багцын хөрөнгөөр шийдвэрлэж өгөхөөр болсон. | 90 |
| 219 | | 2. Эрдэнэцагаан, Наран суманд үерийн ус зайлуулах далан сувгийг барих | 2022 - 2024 | | | Наран сумын үерийн усны далангийн ТЭЗҮ, ажлын зураг төсөл боловсруулах даалгавар гаргаж, зураг төсөл боловсруулах 150,0 сая төгрөгийн зардлыг аймгийн ИТХ-ын 2022 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн хуралаар батлагдсан 2023 оны аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулж ажилласан байна. | 50 |
| 220 | 3.6.2. Гэр хорооллыг дахин төлөвлөх замаар орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. | 1. Баруун-Урт хотын 3-р тойргоос дотогш дахин төлөвлөлт хийж, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлэх, барилгажуулах | 2021 - 2024 | | | Баруун-Урт сумын Амгалан гэр хорооллын байршлыг сонгож Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн дагуу "гэр хорооллын газрын дахин төлөвлөж барилгажуулах" төрлийн хүрээнд орон нутгийн төсвийн 80,0 сая төгрөгийн хөрөнгөөр эхэлсэн, гэрээний дагуу тухай байршлын иргэдтэй, ажлын хэсэгтэй уулзалтуудын 3 удаа зохион байгуулж, тандалт судалгаа, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд саналуудыг авч ажиллаж байна. Мөн шинэ суурьшлийн бүс буюу Баруун-Урт сумын нэгдүгээр багийн нутаг дэсвгэр цэцэрлэг, номын сан, музей, үйлчилгээ бүхий 960 айлын орон сууцны | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хорооллын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар батлуулж, тус сумын наймдугаар баг Хайлааст үүдэнд шнээр үйлдвэрлэлийн бүсийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг хэрэгжүүлж ажиллаж байна. Эдгээрийг хэрэгжүүлсэнээр Амгалан хороолол дахин төлөвлөтөнд урьдчилсан байдлаар 1,1 га-д 150 айл нийтийн орон сууц, 2,6га-д 65 айлын амины орон сууц, 1,7га-д ногоон байгууламж, тохижилт талбай, нийгмийн үйлгээтэй, 1-р багт 960 айлын орон сууцны хороолол, 8-р багт үүссэн үйлдвэрлэл, гахай тахиа аж ахуйн цэгцэлж, сумын төсөөс барилгын материалын үйлдвэр, мах, ноос, тавилга гэх мэт үйлдвэрүүдийг шилжүүлэх зэрэг барилгажилтийн ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөлөсөн ажиллаж байна. | |
| 2 2 1 | | 2. Сумдад гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, орон сууц барих | 2022 - 2024 | | 150 | Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж төлөвлөлтийн дагуу, инженерийн шугам сүлжээний найдвартай, төвлөрсөн хангамжинд тулгуурлан газар олголтыг хийж, орон сууцжуулах ажлыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 9 сумд газар зохион байгуулалт, газар чөлөөлөлтийн чиглэлээр ИТХ-аар хэлэлцүүлсэн тогтоол гаргаад байна. | 70 |
| 2 2 2 | | 3. Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон сууцны барилга, хотхон, хороолол барих ажлыг сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | Баруун-Урт сумын 2 дугаар баг Товчоо орчмын газар чөлөөлөлтөд хамруулах 960 айлын орон сууцны хороолол хэсэгчилсэн төлөвлөгөөг ММ архетоктур ХХК-аар гүйцэтгүүлэн ажиллаж байна. Мөн Барилга, хот байгуулалтын сайдын багцаас 960 айлын орон сууцны хорооллын шугам сүлжээний асуудлыг шийдвэрлүүлэн ажиллаж уг ажилтай холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, газар чөлөөлөлтөд хамрагдах иргэдийн судалгааг гарган иргэд олон нийттэй уулзалт зохион байгуулж, хөрөнгийн үнэлгээчин шалгаруулан хөрөнгийн үнэлгээ хийлгүүлж, иргэдтэй уулзалт хийн газар чөлөөлөх үнэлгээг харилцан тохиролцож ажиллаж байна. Хөрөнгийн үнэлгээний компанитай гэрээ байгуулан 9 айлын газар үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг гаргуулахаар хамтран ажиллаж байна. 1 иргэний өмчлөлийн газар болон үл хөдлөх хөрөнгийг чөлөөлөхөөр болж газар чөлөөлөх гэрээг хийхээр харилцан тохиролцоод байна. | 50 |
| 2 2 3 | | 4. Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд хэрэгжиж буй 960 айлын орон сууцны барилгын инженерийн шугам сүлжээний ажлыг тухайн газар нутгийн онцлогт тохируулан судалгаа шинжилгээ хийн (№ЗД-019/2022) зургийн даалгаврыг боловсруулан холбогдох мэргэжилтэнгүүдээр хянуулан Аймгийн Засаг дарга баталсан . Зураг төслийг “Сивил инженеринг консалтинг” ХХК СИК-06/2022 шифтэй гүйцэтгэн баталлуулан. “Төсөвт төсөл”ХХК түлхүүр гардуулах нөхцөлтэй шугаман, сүлжээ барилга угсралтын ажлыг эхлсэн. 2022 онд дулаан дамжуулах төв,цахилгаан дамжуулах төвийг барилга угсралтын ажлыг гүйцэтгэж илд, далд ажлын актыг баталгаажуулаад байна. Шинээр ашиглалтад орж буй орон сууцны барилгын талбайн тодорхой хувиар түрээсийн орон сууцны санд авч байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 224 | | 5. Боловсрол хорооллын доторх тохижилтын ажлыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлж дуусгах | 2021 - 2022 | | | Баруун-Урт сумын 7-р багийн нутаг дэвсгэр боловсрол хорооллын дунд хүүхдийн тоглоомын талбай, тохижилт, ногоон байгууламж барих ажлыг ОНХС хөрөнгө оруулалтаар 160 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер зарлаж Шинэ-Соёл ХХК шаргарч тус ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор болорвсрол хорооллын зам дагуу Шаргын мод ХХК 1200 ш Хайлаас тарьж усалгаа арчилгааг хийж гүйцэтгүүлж байна. Ирэх оны төсөвт шинээр баригдсан сургууль цэцэрлэгийн урд талаар зам тавих ажлыг зураг төсвийг хийлгэн төсөвт тусгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Шинээр тус хорооллын эргэн тойронд тарьсан хайлаас модыг тэгшлэх ажлыг хийж гүйцэтгэсэн ба хорооллын барилга байгууламжийн дунд цамхагт гэрэлтүүлгийг байршуулах ажлыг Уртын гэгээ ОНӨААТҮГазар хийж гүйцэтгэсэн. | 70 |
| 225 | 3.6.3. Гэр хорооллыг төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбоно. | 2. Баруун-Урт хотын гэр хорооллын айл өрхийг хэсэгчлэн дулаан хангамжид холбох | 2021 - 2022 | | 1 | Баруун-Урт сумын 6 дугаар багийн Дөрвөлжийн энгэрийн эхний 2 эгнээг дулаан хангамжинд холбох нөхцлийг бүрдүүлэхээр зураг төслийн ажлыг "Ричвелл инженеринг" ХХК-аар гүйцэтгүүлсэн ба ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулахаар тендер шалгаруултын шатанд явж байна. Эко хороолол шинэ суурьшлын бүсэд байрлах айл өрхүүд инженерийн шугамд бүрэн холбогдсон.Тус сумын 1-р багийн амгалан хорооллыг дахин төлөвлөлтөд оруулах төслийн хүрээнд гэрээний дагуу Ланд овер ХХКомпани хэсэгчилсэн төлөвлөгөөний ажлыг хийж гүйцэтгэж байгаа ба иргэдийн санал асуулга болон дахин төлөвлөлтийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэн зургийн ажлыг даалгаварыг боловсруулан ажиллаж байна. | 70 |
| 226 | | 3. Сумдад хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан инженерийн шугам сүлжээний өргөтгөл хийх | 2022 - 2023 | | | МУ-ын ЗГ-ын 161 дүгээр тогтоолийн хэрэгжилтийг хангуулах, сумдын хөгжлийн ерөнхий төлөлөгөөний дагуу Онгон, Дарьганга сумдын төвлөрсөн дулаан хангамжийн системийг өргөтгөх, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ тавих ажлыг, мөн Мөнххаан, Баяндэлгэр сумын төвд шинээр бий болгох инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийн даалгаврыг боловсруулан бэлтгэл ажлыг хангаж байна. Баруун-Урт, Эрдэнэцагаан сумдад шугам сүлжээний өргөтгөл хийгдээд байна. | 70 |
| 227 | 3.6.4. Орон нутгийн барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | 1. Барилгын материалын лабораторийн барилгыг ашиглалтад оруулах | 2022 | | 1 | 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтар тусгуулахаар саналаа хүргүүлсэн. | 50 |
| 228 | | 2. Барилгын салбарт эрчим хүчний хэмнэлттэй, ногоон бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын үйлдвэрлэлийг дэмжих | 2021 - 2024 | | | 2022 оны 06,28 ны өдрийн албан хүсэлтээр Баянбумбат констракшн ХХК эрчим хүчний хэмнэлттэй, эко ногоон барилга, амины орон сууцны барилга барьдаг, хамтран ажиллах саналаа ирүүлж судлан ажиллаж байна. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 229 | 3.6.5. Аймгийн хэмжээнд хаягжилтын нэгдсэн системийг бүрдүүлнэ. | 1. Барилга байгууламж, үл хөдлөх хөрөнгө, гудамж зам талбайг хаягжуулах | 2021 - 2024 | | | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 74,8 сая төгрөгөөр 10181 нэгж талбарт 10869 хаягийн тэмдэг тэмдэглэгээ хийсэн байна. “Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх жагсаалт гаргах” ажлын удирдамжийн дагуу 2020 оны 04 дугаар сарын 24-ний өдөр Сүхбаатар аймгийн засаг даргын 290 дугаар захирамж /Хавсралт 1/-аар Ажлын хэсэг байгуулагдаж Ажлын хэсгийн даргаар Аймгийн ЗДТГ-ын дарга, гишүүдээр ГХБХБГ-ын Газрын удирдлагын хэлтсийн дарга, ГХБХБГ-ын кадастрын мэргэжилтэн, Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн, Баруун-Урт сумын газрын даамал, нарийн бичгийн даргаар ГХБХБГ-ын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн нар ажилласан. Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд Хаягийн мэдээллийн системийг ашиглан зам, гудамж, талбай, нэгж талбар, үл хөдлөх хөрөнгөнд хаяг, нэр, дугаар олгох, засварлах, өөрчлөлт хийх ажлыг зохион байгуулж дуусгах чиглэлийн дагуу аймгийн газрын даргын Ажил эрчимжүүлэх тухай 2021.02.09-ний өдрийн А/06 дугаар тушаал батлуулан хэрэгжүүлэн ажиллалаа. Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн системийн хаягжуулалтын ажлын явц хянасан нэгж талбар 81.2 -тай, хянасан барилга 71.9 -тай байна. | 90 |
| 230 | | 2. Аймаг, сумын төвийн хаягжуулалтын ажлыг стандартын дагуу хэрэгжүүлж, төлөвлөлтийн дагуу эгнээ гудамжны эмх цэгцийг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах | 2021 - 2024 | | | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 74,8 сая төгрөгөөр 10181 нэгж талбарт 10869 хаягийн тэмдэг тэмдэглэгээ хийсэн байна. “Хаягийн мэдээлэл шалгах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх жагсаалт гаргах” ажлын удирдамжийн дагуу 2020 оны 04 дугаар сарын 24-ний өдөр Сүхбаатар аймгийн засаг даргын 290 дугаар захирамж /Хавсралт 1/-аар Ажлын хэсэг байгуулагдаж Ажлын хэсгийн даргаар Аймгийн ЗДТГ-ын дарга, гишүүдээр ГХБХБГ-ын Газрын удирдлагын хэлтсийн дарга, ГХБХБГ-ын кадастрын мэргэжилтэн, Улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн, Баруун-Урт сумын газрын даамал, нарийн бичгийн даргаар ГХБХБГ-ын геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн нар ажилласан. Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний дагуу харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд Хаягийн мэдээллийн системийг ашиглан зам, гудамж, талбай, нэгж талбар, үл хөдлөх хөрөнгөнд хаяг, нэр, дугаар олгох, засварлах, өөрчлөлт хийх ажлыг зохион байгуулж дуусгах чиглэлийн дагуу аймгийн газрын даргын Ажил эрчимжүүлэх тухай 2021.02.09-ний өдрийн А/06 дугаар тушаал батлуулан хэрэгжүүлэн ажиллалаа. Аймгийн хэмжээнд хаягийн мэдээллийн системийн хаягжуулалтын ажлын явц хянасан нэгж талбар 81.2 -тай, хянасан барилга 71.9 -тай байна. Бүх сумдын Засаг даргад 2023 оны төсөвт хаягжуулалтын ажлыг хаягын стандарт журмын дагуу шинээр хийлгэх талаар чиглэл хүргүүлэн ажиллалаа. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 231 | 3.6.6. Газар өмчлөлийг эрчимжүүлнэ. | 1. Дэд бүтцийн хангамжид тулгуурлан иргэнд газар өмчлүүлэх боломжтой газрын нөөцийг тогтоож газрыг өмчлүүлэх | 2021 - 2024 | | | 2022 онд сумдад тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Сүхбаатар аймгийн хэмжээнд 1239 нэгж талбар 103.57га газрыг өмчлүүлэхээр тусгагдан батлагдсан. 2022 оны 11 дүгээр сарын 23-ний байдлаар 224 нэгж талбарын 19.74 га газрыг өмчлүүлээд байна. | 90 |
| 232 | 3.6.7. Нийт нутаг дэвсгэрийг бүх төрлийн масштабын байр зүйн зурагтай болгоно. | 1. Баруун-Урт хот, Эрдэнэцагаан, Дарьганга, Онгон, Мөнххаан сумд, Бичигт боомтын 1:100 000-ны байр зүйн зургийг боловсруулах | 2021 - 2022 | | | Салбарын яам, газраас Засгийн газрын үйл ажиллагааны хөтбөрт тусгагдсан зорилт арга хэмжээг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр боловсруулах ажлыг хийж гүйцэтгэх тухай албан бичгээр жил бүр ирүүлээд байна. Баруун-Урт сум болон бусад сумдад үе шаттайгаар 1:500, 1:1000-ны байр зүйн зургийг боловсруулах ажлыг хийхээр санал оруулдаг. Хасагдаад хэрэгжихгүй байгаа мөн 2023 онд яамнаас албан бичиг ирсэн орон тугийн төсөвт саналаа гарган ажиллаж байна. | 50 |
| 233 | | 2. Газар зүйн нэрийн тодруулалтыг хийх | 2021 - 2022 | | | Газар нэрийн тодруулалтын ажил гэрээний дагуу хугацаандаа нийт сумдын нутаг дэмсгэрээр ажиллаж газрын нэрийн тодруулалтыг хийж, жагсаалтыг гаргаж сумдын багийн болон ИТХ-аар хэлэлцүүлж нэгтгэгдсэн ажил дууссан. 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн аймгийн ИТХ-аар батлуулахаар бэлтгэл ажил хангаан ажиллаж байна. | 100 |
| 234 | 3.6.8. Барилгуудыг паспортжуулалт, гэрчилгээжүүлэх ажлыг эрчимжүүлж, иргэдийн аюулгүй ажиллах, амьдрах баталгааг хангана. | 1. Төрийн болон орон нутгийн өмчийн барилгуудыг паспортжуулах, гэрчилгээжүүлэх | 2021 - 2024 | | | Аймгийн засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг Шадар сайдын тушаалын дагуу барилгыг паспортжуулж, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулж судалгааг ГХБХБГ-тай хамтран гаргаж нийт 22 барилгад гэрчилилгээ олгуулах тухай саналыг холбоглох дүрэм журмын хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | 70 |
| 235 | | 2. Хувийн хэвшлийн барилгуудыг паспортжуулах, гэрчилгээжүүлэх | 2021 - 2024 | | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж ашиглалтад орж буй барилга байгууламжийг мэргэжлийн хяналтын байцаагчид хүсэлт хүргүүлэн паспортжуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Хот байгуулалтын цахим сисемд 403 барилга байгууламжийг бүртгээд байна. | 90 |
| 236 | 3.6.9. Барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэлтийг тогтоож, чанарыг дээшлүүлнэ. | 1. Төрийн болон орон нутгийн өмчийн барилгуудын газар хөдлөлтөд тэсвэрлэх чанарыг тогтоох | 2021 - 2023 | | | Орон нутгийн гамгийн эрсдлийг бууруулах зардлаас 60,0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөдсөн барилгуудад үзлэг хийж, газар хөдлөлтөд тэсвэрэх чадвар мөн барилгын ашиглалтыг төлөв байдалд үнэлгээ дүгнэлт өгөх ажлыг төсөвт багтаан 9 барилгад хэрэгжүүлэхээр ажлын даалгаврыг гарган баталгаажуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шатанд байна. | 70 |
| 237 | | 2. Нийтийн орон сууцуудын газар хөдлөлтөд тэсвэрлэх байдлыг тогтоож, төлөвлөлт хийх | 2021 - 2023 | | | Орон нутгийн гамгийн эрсдлийг бууруулах зардлаас 60,0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөдсөн барилгуудад үзлэг хийж, газар хөдлөлтөд тэсвэрэх чадвар мөн барилгын ашиглалтыг төлөв байдалд үнэлгээ дүгнэлт өгөх ажлыг төсөвт багтаан Баруун-Урт сумын төвийн Одкон хотхон, Залуус хотхоны дурааараа давхар нэмсэн 6 давхар 2 орон сууцны барилгад хэрэгжүүлэхээр ажлын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даалгаврыг гарган баталгаажуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шатанд байна. | |
| 238 | | 3. Газар хөдлөлтийн байнгын ажиллагаатай зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах | 2021 - 2024 | | | 2021 онд аймгийн Засаг даргын Захирамжаар ажлын хэсэг шинэчлэн зохион байгуулагдаж Аймгийн Онцгой байлдлын газар, ГХБХБГ-ын дарга, зөвлөлийн нарийн бичгийн дарга нарт зөвлөмж чиглэлийг өгч хамтран ажиллаж байна. | 100 |
| 239 | 3.6.10. Сум, суурин газрын төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна. | 1. Халзан, Мөнххаан, Сүхбаатар, Асгат, Онгон, Наран, Уулбаян, Баяндэлгэр сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах | 2021 - 2024 | 140,0 сая | | Асгат, Онгон сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгийг сумын ОНХС-ийн хөрөнгөөр шийдвэрлэж аймгийн ЗДТГ болон мэргэжлийн яам, агентлагаар зургийн даалгаврыг хянуулж батлуулан тендерийг зарлаж Асгат суманд Нью урбанизм, Онгон сумын ...................... ХХК-иуд шалгарч гэрээ байгуула ажил эхлээд байна. Халзан, Мөнххаан сумдын хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2021 онд "Инженер геодези" ХХК гүйцэтгэхээр сонгон шалгаруулалт болж 2022 оны ажил гүйцэтгэх гэрээг сунган ажиллаж байна. Мөн Сүхбаатар сумын хотын хөгжлийн төлөвлөгөөг "Ланд овнер" ХХК гүйцэтгэн ажиллаж байна. | 90 |
| 240 | | 2. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тодотгох ажлыг хэрэгжүүлэх | 2021 - 2022 | | | Дорнод монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөл болон аймгийн төсвийн хамтарсан санхүүжилтээр аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээний гэрээ 580,591,000 төгрөгөөр тендер шалгарч “Газар дэлхий” ХХК-тай гэрээ хийгдсэн. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан байгуулагдсан аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийг 2 удаа хуралдуулсан. Тус хурлаар төсөл болон гүйцэтгэгч компаниуд аймаг сумын төлөвлөлтийн бодлогын баримт бичгийн ажлын явцыг танилцуулж ажлын хэсэгт мэдээлэл өгч ажилласан. Дээрх ажлын хүрээнд төсөл болон зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанитай байнга хамтран ажиллаж мэдээ мэдээллээр хангаж хурал, хэлэлцүүлэг, сургалт, уулзалтанд цахимаар болон танхимаар оролцох, мөн холбогдох орон нутгийн төлөөлөл болон сумдын газрын даамлуудыг хамруулан ажиллаж байна. Ажил гүйцэтгэгч компанийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, хамтран ажиллах чиглэлээр сумдын Засаг дарга нарт газрын даргын 1/59 тоот албан бичгээр чиглэл хүргүүлсэн байна. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж байгаатай холбогдуулан орон нутгийн төлөөллүүд болон ажлын хэсгийн хамтын оролцоо мэдээллээр хангах, чадавхижуулах үүднээс салбар дундын олон талын оролцоот газрын харилцаа зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу суурь судалгаа болон эхлэлийн шатны ирүүлсэн тайланг хянан холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна. 06 дугаар сарын 09-нөөс аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хээрийн судалгааны ажил эхлэхтэй холбогдуулан | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сумдын газрын даамлууд болон сумын ажлын хэсгийн оролцоог хангуулахаар төлөвлөн ажиллаж байна. | |
| 241 | | 3. Онгон, Мөнххаан, Уулбаян, Түмэнцогт, Наран, Асгат, Халзан сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | | | Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар сумдын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг Дорнод бүсийн хуурай хээрийн ландшафт төслийн санхүүжилттэй хамтран хийж гүйцэтгэж байна. Мөн бусад нийт сумдын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлтийн төслийн 100 хувийн санхжүүжилтээр боловсруулагдаж байна. | 100 |
| 242 | 3.6.11. Аймаг, сумдын төвийн хүн амыг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан ундны усаар хангана. | 1. Баруун-Урт хотын хүн амын ундны ус цэвэршүүлэх тоног төхөөрөмжийн технологийн шинэчлэлтийг хийж хэвийн ажиллагааг хангах | 2021 - 2022 | | 1 | АХБ-ны төслийн 560,0 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдэх ажлын гүйцэтгэгч шалгарч ажил эхлээд байна. | 70 |
| 243 | | 2. 1000м3, 2000м3 усан сан, өргөлтийн насос станц №3, №5-ын битүүмжийг сайжруулж, шугам сүлжээг шинэчлэн, усны алдагдлыг бууруулах | 2022 - 2023 | | | Дээрх ажлыг зураг төслийн дагуу гүйцэтгэж байгаа бөгөөд Дөрвөлж ОНӨҮГ өөрийн хөрөнгөөр ТАА-н 134, 135 гүний худгаас №5 цэвэр усны станц хүртэлх 600 гаран метр шугам сүлжээний угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна. 1000м3, 2000м3 усан сангийн бусад станцын битүүмжийг сайжруулж усны алдагдлыг бууруулах ажлыг зураг төслийн дагуу хийх хөрөнгийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | 70 |
| 244 | | 4. Цэвэр усны хайгуул хийж, гүний худгийн тоог нэмэгдүүлэх | 2022 | | 1 | Асгат 1, Мөнххаан 2, Наран цагаан энгэрт 1, Сүхбаатар 4, Түвшинширээ 1, Уулбаян 1, Эрдэнэцагаан суманд 6 гүн өрмийн худаг тус тус гаргасан | 100 |
| 245 | | 5. Ундны усны эх үүсвэрийн гүний худгуудыг хашаажуулах | 2022 | | 1 | Асгат 3, Баяндэлгэр 2, Дарьганга 2 сэргээн засварласан, Мөнххаан 4, Наран сум хашаатын булгийг хашаажуулсан, Сүхбаатар сум ус цэвэршүүлэх үйлдвэр, Түвшинширээ Даравгай худаг, Халзан сум, Эрдэнэцагаан сум бүрэн хашаажуулж, хамгаалалтын бүсийн тэмдэг тэмдэглэгээ байршуулсан. Хэрэгжилт 100 хувь | 100 |
| 246 | | 7. Зөөврийн ус түгээх цэгүүдийг төвлөрсөн шугамд холбох | 2022 | | 3 | 2022 онд Амгалан хорооллын айл өрхүүдийн дундах зөөврийн худаг, цагдаагийн газрын зүүн талын зөөврийн усан санг дөрвөлж ххк төвлөрсөн шугамд холбосон. 2020 оноос хойш нийт 13 зөөврийн усан санг төвлөрсөн шугамд холбоод байна. | 100 |
| 247 | | 10. Сумдын төвийн хүн амын ундны усны эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж тавих | 2021 - 2024 | | | Ус хангамж ариутгах татуургын ашиглалтыг сайжруулах зохицуулах зөвлөлтэй хамтран нийтийн төв, суурин газрын буюу сумдын төвийн ундны усны эх үүсвэрүүдэд шинжилгээ хийж боловсруула авсан, түүний дагуу сумдад ундны усны чанар аюулгүй талаар чиглэл өгч сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ундны усны эх | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмжийг суурилуулах зөвлөмж өгч ажилласан. | |
| 4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛ | | | | | | | |
| 248 | 4.1.1. Аймгийн хэмжээнд удирдлагын мэдээллийн нэгдсэн цахим программыг нэвтрүүлнэ. | 1. Sukhbaatar.mn болон сумдын вэб сайтыг шинэчлэн,төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 100 | Байгууллагын цахим хуудасны аюулгүй байдлыг хангах чиглэлээр өгөгдлийн санг 3 удаа, сайтын кодыг 3 удаа тус тус нөөцлөлт хийж ажилласан. Цахим хуудсанд 10 дугаар сард дизайн төрлийн түүлсийн шинэчлэлт хийсэн. Веб сайтын нүүр хуудсанд шинээр гарсан хууль, авилгын эсрэг видео булан болон өргөдөл гомдол хүлээн авах цэсийг шинэчлэн засварлалаа. Цахим хуудсанд цаг үеийн болон урьдчилан сэргийлэх 480 мэдээллийг нийтэлж давхардсан тоогоор 15000 гаруй хүнд хүргэж ажилласан. Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны хүрээнд erp.e-mongolia.mn системийг Аймгийн хэмжээнд 13 сумын цэцэрлэг, сургууль, эрүүл мэндийн төв, сумын тамгын газар, соёлын төв, ИТХурал зэрэг нийт 78 төсөвт байгууллага, төвийн 14 агентлаг, 22 төсөв байгууллагуудад тус тус нэвтрүүлж ажиллалаа. Тус системд шинээр хүсэлт гаргасан төрийн аудитын газрын эрхийг нээлгэж, холбогдох заавар зөвөлгөөг өгч ажилласан. Аймгийн хэмжээнд нийт 115 байгууллага нэвтэрч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Дотоодын удирдлагын нэгдсэн системд 4-р улиралын байдлаар нийт удирдах албан тушаалтан 269, гүйцэтгэх албан тушаалтан 1952, туслах албан тушаалтан 545 тус тус бүртгэгдсэн байна. Имонгол академиас систем ашиглаж байгаа байгууллагуудтай гэрээг шинэчлэн батлах ажлыг эхлүүлээд байна. | 90 |
| 249 | | 2. "Төрийн мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй мэдээлэх зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах " | 2021 - 2023 | | | Төрийн мэдээллийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй мэдээллэх зорилгоор орон нутгийн BBS телевиз болон SB инфо сайттай хамтран ажиллах нийт 20 сая төгрөгийн гэрээ байгуулан ажиллаж байна. Тус гэрээний хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Цаг үеийн болон төр засгаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар давхардсан тоогоор мэдээ 600 гаруй Цаг үеийн болон тэмдэглэлт ойн баярын арга хэмжээний талаар ярилцлага 250 Орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын талаар цуврал сурвалжилга 155 "Төрийн мэдээллийн цаг" дугаарыг 24 дугаар бэлтгэхээс 26 дугаар бэлтгэж иргэд олон нийтийг мэдээллээр хангаж ажиллав. | 100 |
| 250 | | 3. Төрийн архивд хадгалагдаж байгаа сан хөмрөгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж стандартын шаардлага хангасан тавиур, шүүгээ, тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | | | Архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулахын тулд аваарын гарцын хаалгыг бүргэд хаалга шинээр хийж. 2022 онд нөхөн бүрдүүлэлт хийх графикийн дагуу Хун Ша И Жань ХХК-ны 2007-2020 оны 14, Уулбаян сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2006-2014 оны 61 зэрэг 6 байгууллагын байнгад хадгалагдах 257 хадгаламжийн нэгжийг төрийн архивт татан аваад байна. Мөн шинээр баригдсан ба засвар, өргөтгөл хийгдсэн барилгуудыг хүлээн авах комисст Архивын тасгийн дарга томилогдож зураг төсөв, холбогдох баримт материалыг архивт хүлээн авах ажлыг орон нутагт зохион байгуулж ирлээ. Энэ онд Сүхбаатар сумын Хаан банкны тооцооны төв, Баруун- | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Урт сумын 3.3 км зам гэх мэт 4 барилга, засварын ажлын 137 хадгаламжийн нэгжийг хүлээн авч хадгаламжийн нэгжийн бүртгэл үйлдэж, заавар журмын дагуу хүлээн авлаа. Нөхөн бүрдүүлэлтээр ирсэн 6 байгууллагын 257 хадгаламжийн нэгжийг хамгаалалтын 10 см-ийн нуруутай хайрцагт хайрцаглаж хадгалаaад байна. | |
| 251 | | 4. Төрийн архивд хадгалагдаж байгаа баримтуудыг цахимд шилжүүлэх ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | | | Төрийн архивт хадгалагдаж байгаа захирамжлалын баримт бичгийн 85 хувийг цахим хэлбэрт шилжүүлэн цахим мэдээллийн сан үүсгэж эх баримтыг ашиглалтаас чөлөөлж байгууллага, иргэдэд захирамжлалын баримт бичигтэй холбогдолтой лавлагаа, мэдээллийг тухай бүр нь олгож чирэгдэлгүй үйлчилж байна. Энэ онд Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар 2006-2013, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн 2012-2015, Хун Ша И Жан ХХК-ны 2007-2020, Уулбаян сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2006-2010 онуудын 191 хадгаламжийн нэгжийн 7746 хуудас баримтыг скайнердаж, photoshop-оор засварласан ба 88 хадгаламжийн нэгжийн 7788 хуудас баримтыг програмд оруулж, цахим холболт хийсэн. | 70 |
| 252 | 4.1.2. Төрийн байгууллагын ажиллах нөхцөл, техник технологийг сайжруулна. | 1. Аймгийн Засаг даргын Тамгын газар болон сум бүрд цахим сургалтын танхим байгуулж, төрийн албан хаагчийн цахим хурал, шалгалт, сургалт зохион байгуулах орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | | | Аймгийн ЗДТГ-ын 201 тоот уулзалтын өрөөнд 60 инчийн смарт дэлгэцийг байрлуул, цахим хурал, сургалт, уулзалтын үед тогтмол ашиглаж байна.<br>Баруун-Урт, Онгон, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан зэрэг 8 сум орон нутгийн төсөв болон хандив тусламжаар цахим хурал, өрөөний тоног төхөөрөмжөөр хангагдан үйл ажиллагаандаа ашиглаж байна. | 70 |
| 253 | | 2. "Төрийн албан хаагчийн ёс зүй, чадавхжуулах сургалт, арга хэмжээг үе шаттай зохион байгуулах " | 2021 - 2024 | | | 2022 оны эхний хагас жилд аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргаар батлуулсан удирдамжийн дагуу хамтарсан ажлын хэсэг сумдад ажилласан. Энэ үеэр сумдын нийт 620 төрийн албан хаагч нарт "Төрийн албаны шинэтгэл, төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж, сумдын төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 2022 оны 2 дугаар сард болсон аймгийн "Төрийн албаны удирдах ажилтны зөвлөгөөн" -ний үеэр Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун болон Маргаан хянах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ бусад референт нарын хамтаар ирж аймгийн төрийн байгууллагын удирдах албан тушаалтан нарт сургалт, семинар зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн энэ үеэр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс тус зөвлөгөөнд оролцсон нийт 120 орчим удирдах албан тушаалтан нарт, 3 дугаар сард зохион байгуулсан аймгийн соёлын байгууллагын 110 орчим албан хаагч нарын, аймгийн мал эмнэлгийн салбарын 160 орчим албан хаагч нарын, аймгийн мэргэжлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналтын салбарын 90 орчим албан хаагчдийн тус тус уулзалт зөвлөгөөний үед “Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг чадавхжуулах нь” сэдэвт сургалт зохион байгуулж арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн аймгийн Засаг даргын захирамжаар баталсан “Зөв хандлага-эерэг нөлөө” аян зохион байгуулж, аяны хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээг эелдэг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх чиглэлээр байгууллага бүр идэвх санаачилга гарган ажиллахыг уриалсан. Аяны хүрээнд аймгийн төрийн байгуулагууд байгууллагын ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулах, төрийн албан хаагчийн ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн талаар байгууллага дотроо судалгаа авах, судалгааны үр дүнд шинэлэг бүтээлч ажил зохион байгуулах, байгууллагын албан хаагчийн ажлын байрны чиг үүргийн талаар олон нийтэд зориулсан, соён гэгээрүүлэх контент, бүтээл, мэдээ мэдээлийг түгээх, угтах үйлчилгээний соёл болон иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх тал дээр идэвхтэй ажилласан үр дүнтэй ажил боллоо. 2022 оны 06 дугаар сард аймгийн төрийн байгууллагын болон сумдын Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн бодлого хариуцсан мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй 18 төрийн албан хаагчийг Төрийн албаны зөвлөлд “Төрийн албаны шинэтгэл, Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад хамрууллаа. Аймгийн төрийн байгууллагын нийт албан хаагч, сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдыг Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж байгаа 7,4,10 сургалтад тогтмол хамруулж байна. | |
| 254 | | 5. Сумдын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг тогтмол зохион байгуулах | 2021 - 2024 | | | Иргэний улсын бүртгэгч нарын нийт 1973 хөтөлсөн бүртгэлд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 1019, хуулийн этгээдийн өдөр тутмын түүвэрчилсэн хяналтаар 253 хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьсан байна. 2022 оны 06 сарын байдлаар хэлтсийн шилэн дансны хөтлөлт, 04 сарын санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт, үнэт цаасны тайлан гаргалт нэгтгэлийг хянан шалгасан. 2020 оны баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар, хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгжийн жагсаалтыг бүрэн гүйцэт тоолон хадгалах хугацааны нэрийн жагсаалт үйлдэн 3295 хуудас баримт бичгүүдийг устгасан актыг 2022.03.22 өдөр 161 тоот албан бичгээр дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Бүртгэлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавин холбогдох албан хаагчийг арга зүйн удирлагаар дээд шатны байгууллагын зүгээс ханган ажиллаж хэвшсэн. | 90 |
| 255 | | 6. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг өргөтгөх | 2021 - 2024 | | | Төрийн үйлчилгээг цахимаар дамжуулан иргэдэд түргэн шуурхай үзүүлэх ажлын хүрээнд нэгдсэн төвийн үйчилгээний ажилтныг мэргэжил арга зүйн зөвлөгөө мэдээллээр хангаж, нэгдсэн төвийн үйлчилгээний компьютерт засвар үйлчилгээг 1 удаа үзүүлж, холбогдох програм хангамжийн тохиргоог бүрэн хийж гүйцэтгэсэн. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цахим үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хүргэх ажлыг шат дараалалтай зохион байгуулж байна. Нийт цаасан суурьт гарын авлагыг 230 иргэнд, олон нийтийн цахим сүлжээгээр имонголиа системтэй холбоотой видео, зурган мэдээллийг давхардсан тоогоор 5000 гаруй иргэнд тус тус хүргэж ажилласан. 2022 оны 11 дүгээр сарын байдлаар төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан 1592 иргэнд оператор болон портал чиглэлээр үйлчилгээг үзүүлээд байна. | |
| 256 | | 7. Хил хамгаалах, Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны материаллаг баазыг бэхжүүлэх | 2021 - 2024 | 110.400.000 төгрөг - ЗДҮАХХЗардал | | Аймгийн хил хамгаалах туслах хүчний зөвлөгөөнийг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж хилийн 0146, 0184 дүгээр ангиудтай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна.Хил хамгаалах туслах хүчний зөвлөгөөний үеэр 0146, 0184 ангиудын захирагч нараас гаргасан хүсэлтийн дагуу хилийн өргөст утсан торыг стандартад нийцүүлэн трубаны шонтой торон саад шинээр хийх, засварлах ажилд тус бүр 10,10-н километр газар байгуулах тооцооллыг ирүүлсний дагуу 140 сая төгрөгийн төсөв хөрөнгийг шийдвэрлэж, хилийн ангиуд руу эрхийг шилжүүлж одоогоор 70 сая төгрөгийг шийдвэрлэж гүйцэтгэл 100 хувьтай байна. Мөн цагдаагийн газраас зохион явуулж буй Устгал, Мал мах нэгдсэн арга хэмжээний хүрээнд Засаг даргын үйл ажиллагааны зардлын сангаас 12.000.000 төгрөг шийдвэрлэж өгсөн. Мөн хамтран ажилладаг байгууллага болох аймгийн шүүхийн хамгаалалтын хашаа, автомашины зогсоол зэргийг барих ажилд 20.000.000 сая төгрөг шийдвэрлэсэн. Аймгийн прокурорын газарт 3.000.000, тагнуулын хэлтэст 5.000.000 сая төгрөгний материаллаг баазыг нэмэгдүүлэх чиглэлээр шийдвэрлэж өгсөн. Мөн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар, Тагнуулын газраас зохион явуулсан Тэсэрч дэлбэрээх бодисын эргэлтэд хяналт тавих ажилд 400.000 төгрөгийг шийдвэрлсэн байна. | 90 |
| 257 | | 9. Шүүхийн шинжилгээний албыг бичиг баримтын болон галт зэвсгийн шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангах | 2021 - 2024 | 4.0 сая төг-АЗҮАХХЗардал | | Аймгийн Засаг дарга 4 сая төгрөг, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдын хурлаас 2 сая төгрөг, Баруун-Урт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх шийдвэр гарсан. Тус албаны лабораторийн барилга барихаар тусгагдсан тул аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд инженерийн шугам сүлжээ бүхий 2343 м/кв газрыг тус шүүхийн шинжилгээний албанд олгох тухай аймгийн Засаг даргын энэ оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/192 дугаар захирамжийг үндэслэн, газрын гэрчилгээ /000002819/, гэрээ /02201-2021/00049/, кадастрын зургийг хийлгүүлж, байгууллагын нэр дээр шилжүүлэн авсан. Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан лабораторийн барилгыг улсын төсвийн хөрөнгөөр 2023 онд санхүүжүүлэхээр болсонтой холбогдуулан барилгын зураг төслийн ажлыг “ББСМО” ХХК-аар лабораторийн барилгын зургийг гүйцэтгүүлж, хангагч байгууллагаас | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | техникийн болон геологийн дүгнэлт гаргуулж, зургийг Барилгын хөгжлийн төвд магадлалд оруулахаар хүргүүлээд байна. | |
| 258 | | 12. Хил хамгаалахад туслах хүчний гишүүдийн зөвлөгөөнийг жил тутам зохион байгуулах | 2021 - 2024 | | | Аймгийн хил хамгаалах туслах хүчний зөвлөгөөнийг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж хилийн 0146, 0184 дүгээр ангиудтай 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |
| 259 | | 14. Өөрийн аймгийн хилийн хэсгийн өргөст утсан торыг стандартад нийцүүлэн шинэчлэх ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах | 2021 - 2024 | | | Хил хамгаалах туслах хүчний зөвлөгөөний үеэр 0146, 0184 ангиудын захирагч нараас гаргасан хүсэлтийн дагуу хилийн өргөст утсан торыг стандартад нийцүүлэн трубаны шонтой торон саад шинээр хийх, засварлах ажилд 2 ангид тус бүр 10,10-н километр газар инженер техникийн ажил явуулах тооцооллыг ирүүлсний дагуу 140 сая төгрөгийн төсөв хөрөнгийг шийдвэрлэж, хилийн ангиудруу эрхийг шилжүүлж одоогоор 70 сая төгрөгийг шийдвэрлэж инженер техникийн ажил гүйцэтгэл 100 хувьтай байна. | 100 |
| 260 | 4.1.3. Төрийн байгууллагад ISO олон улсын стандартыг нэвтрүүлж, үйлчилгээний чанарыг сайжруулна. | 1. Сумдын Засаг даргын Тамгын газарт "ISO 9001:2015" олон улсын Чанарын менежментийн тогтолцоо стандартыг нэвтрүүлж, баталгаажилт хийлгэх | 2021 - 2024 | | | Төрийн байгууллагын бүтээмж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу 2020 оноос Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж улмаар 2020 онд Баталгаажилтын байгууллагаас “Баталгаажилтын гэрчилгээ”-г хүлээн авч, магадлах 1-р аудитад 2021 онд амжилттай шалгагдсан. Түүнчлэн аймгийн сумд, агентлаг байгууллагууд уг стандартыг нэвтрүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлж сумдаас Баруун-Урт, Мөнххаан сумын ЗДТГ, агентлагаас НДХ баталгаажилтын гэрчилгээг тус тус авсан бол ХХҮГ, СХЗХ зэрэг байгууллагууд нэвтрүүлж хэрэгжүүлэх шатанд явж байна. | 100 |
| 261 | | 2. Төр, орон нутгийн бодлого, шийдвэрийн талаарх иргэдийн сэтгэл ханамжийн түвшнийг тодорхойлох хэрэглэгчийн үнэлгээ, судалгааг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлэх | 2021 - 2024 | | | 2021 онд тус судалгааг авч үр дүнг тооцсон. 2022 онд хэрэглэгчийн үнэлгээ судалгааны ажлын гүйцэтгэгчээр Хараа хүрэхгүй НҮТББ шалгарч Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 302-р тушаалаар баталсан удирдамжийг үндэслэн 162 асуулга бүхий ҮСХ-оос санамсаргүй түүврийн аргаар сонгон ирүүлсэн 800 өрхөөс судалгааг 2022.11.18-нд авч дууссан. 2023 оны 1 дүгээр сарын 10-ны дотор дүгнэлт тайланг хүлээлгэн өгөхөөр нэгтгэл, дүн шинжилгээ хийх шатандаа явж байна. | 100 |
| 262 | 4.2.1. Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллах | 1. Аймгийн хэмжээний төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | | Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг боловсруулах суурь судалгааг Мерит төслийн санхүүжилтээр 90,0 сая төгргөөр хийж гүйцэтгэсэн. Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн төсөл боловсруулагдаж дуусаад аймгийн ИТХ-аар оруулж баталхад бэлэн болсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 263 | нөхцөлийг бүрдүүлнэ. | 2. Төрийн албан хаагчдыг орон сууцжуулах, орон сууцны нөхцөлийг сайжруулах | 2021 - 2024 | | | Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн төсөлд орон сууцжуулах талаар тодорхой заалт, санхүүжилтийг тусган 2023 он хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж аймгийн ИТХ-аар батлуулсан. | 70 |
| 264 | 4.2.2. Төрийн албаны хүний нөөцийг бэлтгэж чадавхжуулна. | 1. Төрийн албан хаагчдыг Засгийн газрын болон гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | | Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах хүсэлтэй албан хаагчдын судалгааг гарган нийт 150 гаруй албан хаагч хүсэлтээ ирүүлснээс х Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Улсын төсвийн санхүүжилтээр -8, байгууллагын зардлаар 18 албан хаагч, давтан мэргэшүүлэх сургалтад 18 албан хаагч, мэргэшүүлэх сургалтад 38 албан хаагч, мэргэшүүлэх богино хугацааны сургалтад 150 албан хаагчийг хамруулан сургалтын явцад хяналт тавьж байна. Аймгийн хэмжээнд онлайн, танхим хосолсон хэлбэрээр сургалтыг үе шаттай зохион байгуулж агентлаг төсөвт байгууллагаас 250, сумдын төрийн албан хаагч 220, ЗДТГ-ын 220 албан хаагчдыг хамруулсан. Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах хүсэлтэй аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын саналыг авч нэгтгэн мэдээллийн дата үүсгэсэн. 2023 оны сургалтын хөтөлбөр агуулгад уг сургалтыг нэмж тусгах саналаа өгсөн. | 100 |
| 265 | | 2. Төрийн албан хаагчдыг үе шаттай мэргэшүүлэх сургалтад хамруулах | 2021 - 2024 | | | | 100 |
| 266 | 4.2.3. Хүний эрхийг дээдэлсэн хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчил шийдвэрлэлтийн хувийг нэмэгдүүлнэ. | 1. Хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг дээдлэх хандлага, дадлыг төлөвшүүлэх сургалт сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг иргэд болон төрийн албан хаагчдад зориулан үе шаттайгаар зохион байгуулах. | 2021 - 2024 | - | | - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 2022 оны 05 сарын 23-26-ны өдрүүдэд сумдын иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, мэдээлэл хүргэв.<br>- Аймгийн Засаг даргын 2022 оны 05 сарын 19-ний А/266 дугаар захирамжаар 2022 оны 05 сарын 21-23-ны өдрүүдэд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн Д.Ундрааг урьж “Хамтарсан баг” болон Хамгаалах байрны мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа.Сургалтад тус аймгийн 22 хамтарсан багийн 140 гишүүд, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, аймгийн Прокурорын газар, Хууль, эрх зүйн хэлтэс, Нэгдсэн эмнэлэг зэрэг төрийн байгууллагын удирдлагууд хамрагдсан. - Монголын Хуульчдын холбоотой хамтран иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа буюу “Хуульчийн Про Боно өдөр”-ийг 05 сарын 01-ний өдөр зохион байгуулж, өдөрлөгт хуулийн байгууллагуудаас гадна бусад төрийн болон төрийн бус байгууллагууд оролцон иргэдэд газар дээр нь төрийн үйлчилгээг үзүүлэх, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар гарын авлага түгээх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдэд салбарын мэдээллийг түгээх, хууль тогтоомжийг сурталчилж ажиллав. - Аймгийн багийн засаг дарга нарын сургалтын үеэр тус хэлтсээс Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн талаар 67 багийн засаг дарга нарт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээлэл өгсөн. - Сумдын хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн болон эрх зүйн хөтчөөр бэлтгэгдсэн иргэдийг чадавхжуулах зорилгоор Зөвшөөрлийн тухай /Шинэчилсэн найруулга/, "Шүүхэд хандах эрх", "Хохирогч төвтэй хандлага", "Хууль зүйн туслалцааны төвийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль" сэдвүүдээр цахим сургалт зохион байгуулж нийт 24 албан хаагч оролцсон. - Иргэн таны хууль, эрх зүйн мэдлэгт-Сүхбаатар аймаг Хууль, эрх зүйн хэлтэс нэртэй фэйсбүүк хуудсаар өдөр бүр хууль, эрх зүйн шинэ мэдээллийг хүргэв | |
| 267 | | 2. Хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, оролцогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж, эрхийг нь хамгаалахад мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах | 2021 - 2024 | | | “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 45 дугаар тогтоолын хавсралтын 5.3.10-д заасан “Нийгмийн зорилтод бүлгийн иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх хөтөлбөр”, Хууль зүй, дотоод хэргийн сайд Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу Хууль зүйн туслалцааны төвийн Сүхбаатар аймаг дахь салбарын үйл ажиллагааг дэмжиж, Засаг даргын тамгын газрын байрны 3-р давхарт үйл ажиллагаа явуулж байсныг тус байрны 1 давхарт 115 тоот өрөөнд байрлуулан, стандартын шаардлага хангасан ажлын өрөө тасалгаа, тог цахилгаан, интернэт зэргээр хангаж, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн. Ингэснээр үйлчилгээний хүртээмж сайжирч, иргэд үйлчилгээ авахад илүү хялбар, түргэн шуурхай болсон. Тус салбар нь 2022 оны 11 дүгээр сарын 24-ний байдлаар 280 иргэнд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгч, эрүүгийн 52 хэргийн 57 холбогдогчид /насанд хүрээгүй 2, эмэгтэй 6, хөгжлийн бэрхшээлтэй 1, бичиг үсэггүй 22 хүн/ өмгөөллийн үйлчилгээ үзүүлээд байна. Шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн эрүүгийн 215 хэргийн 43 хэрэг буюу 20 хувьд улсын өмгөөлөгч оролцсон бөгөөд үүнээс 14 хэрэг /32 хувь/ нь хүнд гэмт хэрэг эзэлж байна. Энэ онд шүүхийн болон шүүхийн өмнөх шатанд 4 хүнд холбогдох 3 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн. Хууль зүйн туслалцааны төвийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлснээр тодорхой төрлийн эрүүгийн болон зөрчлийн хэргийн хохирогч, зарим төрлийн иргэний болон захиргааны хэргийн маргааны нэхэмжлэгчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хуульзүйн боломж бий болсон бөгөөд энэ талаарх мэдээллийг орон нутгийн иргэдэд сурталчилан ажиллаж байна. Үүний хүрээнд 12 эрүүгийн хэргийн хохирогчид хууль зүйн зөвлөгөө өгсөн. | 100 |
| 268 | 4.2.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх | 1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | | | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 27 арга хэмжээг тусган аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг жил бүрийн 02 дугаар сарын 09-ний дотор АТГ-т тайлагнаж хэвшсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 269 | төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг иргэд, олон нийтийн оролцоотой төлөвлөн, хэрэгжүүлж шударга байдлын үнэлгээг нэмэгдүүлнэ. | 2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай, Төрийн албаны тухай хуулиудын холбогдох заалтуудын хэрэгжилтэд хяналт тавих | 2021 - 2024 | | | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай, Төрийн албаны тухай хуулиудын холбогдох заалтуудын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдүүдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг(ХАСУМ)-ийг хянасан дүгнэлт АТГ-ын албан тоотоор ирсэнийг орон нутгийн албан ёсны вэб сайт sukhbaatar.gov.mn-д байршуулж хэвшсэн. Дээрх хуулийн дагуу шинээр томилогдсон албан хаагчдаас ХАСУМ, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд www.meduuleg.iaac.mn-д системээр дамжуулан АТГ-т гаргаж хэвшсэн. | 90 |
| 270 | 4.3.1. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг өргөжүүлнэ. | 1. Аймаг, сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, камержуулах ажлыг үе шаттай зохион байгуулж, камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх | 2021 - 2024 | 881.000.000 Улсын төсөв | | Аймаг орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 оны 3 дугаар улирлаас Баруун-Урт сумын 9 дүгээр багт, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 60.0 сая төгрөгийн өртөг бүхий теле хяналтын камерыг суурилуулахаар зураг төсөвийг гарган ажиллаж байна. Одоогоор ашиглаж байгаа нийт 115 ширхэг теле хяналтын камерыг нэгдсэн системд холбон хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд Баруун-Урт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тогтоол гаргуулан теле хяналтын камерыг хариуцах байгууллагыг тогтоож урсгал засварын хөрөнгийг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Теле хяналтын камераар энэ онд 230 зөрчил илрүүлж хариуцлага тооцон ажилласан. Энэ онд аймгийн төвд нийт 9.2 км газарт хатуу хучилттай зам тавьсан бөгөөд замын дагуу орчин үеийн гэрэлтүүлэг сайтай гэрлийг тавьж байршуулсан. Мөн Баруун-Урт сумын 5 дугаар багийн нутагт шинэээр гэрэлтүүлэг тавьж ажилласан. Мөн аймгийн 80 жилийн ойг тохиолдуулан байгууллага, аж ахуй нэгжийн гадна гэрэлтүүлгийг сайжруулж аймгийн өнгө үзэмж, соёлыг дээшлүүлж ард иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан. | 90 |
| 271 | | 4. Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Баруун-Урт, Чингис хот чиглэлийн замд "дундаж хурд тодорхойлох" технологи, туршлагыг судалж нэвтрүүлэх | 2022 | | 1 | Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Баруун-Урт, Чингис хот чиглэлийн замд "дундаж хурд тодорхойлох" чиглэлээр хяналтын постны үйл ажиллагааг эрчимжүүлж постоор дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг шалгаж гарсан цаг минутыг постод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид дамжуулж явсан цаг минутыг тодорхойлж ажиллаж байгаа бөгөөд цаашид орчин үеийн техник технологийн шийдлийг нэвтрүүлж ажиллахаар улсын чанартай А2001 авто замд дундаж хурд хэмжих теле камерийн үнийн санал техникийн нөхцөлийг “Оргил делта” трейд ХХК-с авч 126,522,000₮ төгрөг шийдвэрлүүлхээр болж 2023 оны орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт тусгуулахаар саналыг хүргүүлээд байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 272 | | 6. Аж ахуйн нэгж, байгууллага, ялангуяа шатахуун түгээх станц, барьцаалан зээлдүүлэх, интернет тоглоомын газар болон томоохон худалдаа, үзвэр, үйлчилгээний газрууд, гудамж талбайн хяналтын камерын системийг цагдаагийн газрын нэгдсэн сүлжээнд холбох | 2021 - 2024 | 881.000.000 - Улсын төсөв, 5000.0- АЗДҮАХЗардал | | Баруун-Урт сумын 2, 7 дугаар баг, орон сууцны хороолол “Талын технологи” компаниар 18 ширхэг 360 градусын PTZ камер, 8 ширхэг чиглэлийн камер суурилуулж хяналтыг Баруун-Урт сумын нэг цэгийн үйлчилгээний төвд, мөн Баруун-Урт сумын замын хяналтын постод 3 ширхэг теле хяналтын камер шинээр суурилуулж, цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны хяналтын төвтэй тус тус холбосон. Баруун-Урт сумын авто замын гэрлэн дохиотой 7 уулзварын теле хяналтын камержуулалтын техникийн тодорхойлолтыг гаргуулан, гүйцэтгэлийн ажлыг “Иносолюшн” ХХК нь гэрлэн хөдөлгөөнт 7, чиглэлийн 28 ширхэг камер суурилуулан цагдаагийн газрын жижүүрийн шуурхай албаны хяналтын төвтэй тус тус холбосон. Ингэснээр гудамж талбай, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг цагдаагийн байгууллагын хяналтад авч ажиллаж байна. Аймгийн засаг даргад телехяналтын камерын шилэн кабелийн түрээсийн төлбөр шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг холбогдох тооцоо судалгааны хамт хүргүүлсний үр дүнд түрээсийн төлбөрт 5 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлсэн. | 90 |
| 273 | | 8. Хүн, мал тээврийн хэрэгслийн мэдээллийг шалгах цахим төхөөрөмжөөс хайлт хийх, илрүүлэх зэрэг цахим мэдээллийн санд суурилсан бүртгэл хяналтын системийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрэн сурвалжлах, зарлан мэдээлэх, ажилд өргөнөөр нэвтрүүлж, ашиглах хүртээмжийг нэмэгдүүлэх. | 2021 - 2024 | | | Цагдаагийн байгууллага, Мал эмнэлгийн ерөнхий газартай хамтран малын гарал үүслийн гэрчилгээ шалгах https://vet.certificate.mn сайт болон гар утасны аппликейшн, цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал, эд зүйлтэй танилцах гар утасны Police SOP аппликейшн, эрэн сурвалжлах зарлан мэдээлэл фэйсбүүк дотоод хаалттай группт зэргийг өдөр тутмын үйл ажиллагаандаа өргөнөөр ашиглаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллаж байна. | 100 |
| 274 | | 9. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж болох “Дроны эргүүл”-ийг бий болгож, эмзэг цэгүүдийг хянаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх | 2021 - 2024 | 5.000.0 | | Аймгийн цагдаагийн газарт Evo-2 маркийн 2020 онд үйлдвэрлэсэн бүрэн цэнэгээрээ 30 минут ажиллах, дээд өндөр 800М, Level 7 буюу 10м/с-12,5м/с салхинд нисэх чадалтай, далайн түвшинээс 5000М өндөрт нисэх сэнстэй, 58 Gb хүртэл SD card дэмждэг, дээд хурд 68км/цаг хурдлах хүчин чадал бүхий дроныг шийдвэрлэж өгсөнөөр аймгийн төвийн гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж талбай багуудын нутаг дэвсгэрт эргүүл, хяналтын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна. Мөн энэ хугацаанд хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан олон нийтийг хамарсан Улсын баяр наадам, Сар шинэ, жагсаал цуглаан, хурдан морины уралдааны хамгаалалтын үед нийтийн хэв журам зөрчиж болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор зарим цэг, байршилыг хяналтад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авах, өрнөсөн үйл явдалыг баримтжуулах, аливаа үйл явдалыг сэргээн дүрслэх нотлох баримт бүрдүүлэх зорилгоор ашигласан нь үр дүнтэй, сэжиг бүхий этгээдүүдийн сэтгэл зүйд шууд нөлөөлж, гаргах байсан үйлдэл, зорилгыг нь хязгаарласан урьчилан сэргийлэх чухал арга хэмжээ болсон. | |
| 275 | 4.3.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд олон нийтийн оролцоог хангана. | 1. Аймгийн хэмжээнд гаралт ихтэй зарим төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дэргэд Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Архидан согтуурахтай тэмцэх, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх дэд зөвлөлүүдийг байгуулж ажиллуулах | 2021 - 2024 | | | Аймгийн ГХУСАЗСЗөвлөл 2022 оны 03 дугаар сард хуралдаж 2022 онд хийх ажлын төлөвлөгөөг баталж тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын захирамжаар “Зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөл”, “Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөл”, “Архидан согтуурахтай тэмцэх ажлыг зохицуулах дэд зөвлөл”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах дэд зөвлөл”-үүдийг тус тус байгуулсан. Зөвлөлүүд чиглэл чиглэлийн дагуу үйл ажиллагааны ажлыг төлөвлөж ажиллаж байна. | 100 |
| 276 | | 3. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдсан “Түр хамгаалах байр”-ны урсгал зардлыг шийдвэрлэх | 2021 - 2024 | 90.000 .0- ОНТ | | Ази номхон далайн бүс нутгийн цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжаар Хууль зүй дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкны хамтарсан төслийн дагуу 253.6 сая төгрөгийн санхүүжилтээр нэг удаа 8 хүн хүлээн авах боломжтой 177 мкв талбай бүхий түр хамгаалах байр байгуулагдсан. Барилга байгууламжийг ашиглалтад 2022 оны 07 дугаар сарын 02-ны өдөр оруулж үйл ажиллагааг явуулж байна. 2022 онд аймгийн орон нутгийн төсвөөс Хамгаалах байрны үйл ажиллагааны зардалд 90.000.000 сая төгрөг батлуулж шийдвэрлэсэн.Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон 27 гэр бүлийн 43 хохирогчийг цагдаагийн газрын дэргэдэх “Түр хамгаалах байр”-д хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс насанд хүрсэн эмэгтэй 21, эмэгтэй хүүхэд 13, эрэгтэй хүүхэд 10 байгаа бөгөөд 35 хохирогчид холбон зуучлах үйлчилгээ, 13 хохирогчид хүүхэд хамгааллын үйлчилгээ, 22 хохирогчид нийгмийн халамжийн үйлчилгээ, давхардсан тоогоор 57 хохирогчид төрөл бүрийн сургалтын үйлчилгээ, 50 хохирогчид сэтгэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зүйн үйлчилгээ, 19 хохирогчид эмнэлгийн үйлчилгээ тус тус үзүүлсэн ба тухай бүрт Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн холбогдох мэргэжилтнүүдтэй холбогдон мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч ажилласан. | |
| 277 | | 4. Өсвөр үеийнхэн, ерөнхий боловсролын сурагчдыг хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, уруу татагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохих мэдлэг олгох, хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг сурталчлах чиглэлээр "Үзүүлэн кабинет" байгуулах. | 2021 - 2024 | | | Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хууль зүйн туслалцааны төвийн Сүхбаатар аймаг дахь салбарын улсын өмгөөлөгч нартай хамтран ерөнхий боловсролын 1, 2, 3, 4 дүгээр сургуулийн ахлах ангийн 920 сурагчдад хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, уруу татагдахаас урьдчилан сэргийлэх яриа таниулга хийсэн. Мөн хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, уруу татагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зохих мэдлэг олгох, хар тамхи, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг сурталчлах чиглэлээр энэ оны 04 дүгээр улиралд багтаан Боловсрол, соёлын газар, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн төв, Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран "Үзүүлэн кабинет" байгуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажилласан. Ерөнхий боловсролын 1 дүгээр бүрэн дунд сургуулийн 1 кабинетад хар тамхи, мансууруулах бодис хэрэглэх, уруу татагдахаас урьдчилан сэргийлэх, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг сурталчлах үзүүлэн самбар байрлуулан ажиллаж байна. | 90 |
| 278 | | 6. Баруун-Урт хотын төв болон хот хоорондын төв магистрал замуудын тэмдэг, тэмдэглэгээнд үзлэг, шалгалт хийж, стандартад нийцүүлэн засаж өөрчлөх, шинээр нэмэгдүүлэх | 2021 - 2024 | 27 сая төгрөг | | Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 2022 онд 27 сая төгрөг шийдвэрлүүлж Баруун-Урт сумын төвд шинээр 96 ширхэг замын тэмдэг суулгуулах ажилд "Наран булаг Сүхбаатар принтринг" ХХК шалгарч ажлыг хэрэгжүүлсэн. Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохицуулах салбар зөвлөлөөс "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" нэгдсэн арга хэмжээний хүрээнд улсын чанартай А2001 авто зам дагуу "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" гэсэн агуулга бүхий зурагт самбар 18 ширхэгийг байршуулан гарч болзошгүй зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэн ажилласан, Сүхбаатар аймгийн "Талын зам" ТӨХК-д цагдаагийн газрын замын цагдаагийн тасгаас энэ онд 4 удаа албан мэдэгдэл хүргүүлж Улсын чанартай А2001 авто замд тэмдэг, замын эвдэрсэн хэсэг үзлэг тооллго хамтран зохион байгуулж илэрсэн зөрчилд засвар үйлчилгээг хийлгэн ажилласан. Мөн зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор улсын чанартай А2001 авто замын 10 километр тутамд нийт 17 ширхэг хэвтээ хурд сааруулагчийг байршуулсан. Мөн аймгийн төвийн сургууль, цэцэрлэгийн ойролцоох замуудад 7 ширхэг хурд сааруулагчийг шинээр хийж байршуулсан. | 100 |
| 279 | | 8. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга | 2021 - 2024 | | | Шинээр батлагдсан хууль тогтоомж, хуулийн төслийн хэлэлцүүлгийг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулахад албан бичиг тоотоор хандсан байгууллага болон дээрээс үүрэг чиглэл өгсөн тухай бүр хамтран ажиллаж, хариуцан зохион байгуулж байна.Тухайлбал сургалт, хэлэлцүүлгийн байраар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй хамтран тогтмол зохион байгуулах, мэдээлэх. | | | | тухай бүр хангах, орон нутгийн BBS телевизэд зар мэдээллийг үнэ төлбөргүй явуулж өгөх, нийтлэг үйлчилгээ ОНӨҮГ-аас сургалтын цайны завсарлагыг зохион байгуулах, хэвлэл мэдээллийн ажилтан сургалт, мэдээллийн үед зураг авч мэдээлэл бэлтгэх аймгийн албан ёсны сайт sukhbaatar сайт дээр байршуулах зэрэг дэмжлэгийг тогтмол үзүүлэн ажиллаж байна. Мөн аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтсүүд, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, албад, босоо удирдлагатай агентлагуудаас салбарын хууль, тогтоомжуудаа тухай бүр сурталчлан таниулах нөлөөллийн ажлуудыг төрөл бүрийн арга хэлбэрээр зохион байгуулж хэвшсэн ба жил бүр тус яаманд хүргүүлдэг эрх зүйн ажлын тайлан, мэдээнд нэгтгэн тайлагнаж байна. Эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 280 | | 9. Хүүхдийг багаас нь зөв хүн болгон төлөвшүүлэх, хууль дээдлэх, эрх зүйн боловсрол олгох, аливаа асуудлыг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, соёл, харилцааны ур чадвар олгоход чиглэсэн цогц арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | | | Тус аймгийн нутаг дэвсгэрт эхний хагас жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой нийт 10 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 6 нэгжээр буюу 30.7 хувиар буурсан байна. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль хүчний байгууллагатай хамтран хамтарсан багийг чадавхижуулах сургалт 3, гэмт хэрэг зөрчил үйлдэгдэж болзошгүй, иргэд нь байнгын архидан согтуурдаг орон сууц, нийтийн байрны оршин суугчдад 2, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн шүүхийн шийтгэврээр баривчлагдсан иргэдэд 30 удаа тус тус сургалт зохион байгуулсан. Аймгийн Засаг даргад хүргүүлж Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 19-ний А/266 дугаар захирамжаар 2022 оны 05 сарын 21-23-ны өдрүүдэд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн Д.Ундраага урьж “Хамтарсан баг” болон Хамгаалах байрны мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа.Сум сумандаа чадавхжсан хамтарсан багийн гишүүд дээрх чиглэлийн сургалтуудыг сургуулийн сурагчдад сургалт, мэдээлэл, зөвлөмж хлбэрээр тогтмол зохион байгуулж хэвшсэн. | 90 |
| 281 | | 10. Тухайн хүн гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, түүний зан үйл, ёс суртахуунд нөлөөлж, хандлагыг өөрчлөх замаар гэмт үйлдлээс сайн дураараа татгалзах нөлөөллийн арга хэлбэрийг үе шаттай хэрэгжүүлэхэд гэр бүл, ойр дотны хүмүүсийн | 2021 - 2024 | | | Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн алба хаагч нар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 2022 оны 05 дугаар сарын 23-наас 26-ны өдрүүдэд сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааг шалган мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн бөгөөд сум тус бүрийн онцлогт тохируулан иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, аль болох гэмт хэрэг, зөрчлөөс сайн дураараа татгалзах нөлөөллийг хүргэж ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг нь хаалттай хаалганы цаана байнгын шинжтэй үйлдэгдэж байдаг бөгөөд ноцтой хохирол учрахаас өмнө зөрчлийн шатанд нь таслан зогсоож илрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор “Хяналт” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжлэгийг авч хамтран ажиллах. | | | | ажилласан. Арга хэмжээний хүрээнд иргэдийн дунд байнгын архидан согтуурдаг, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэж болзошгүй гэр бүлийн судалгааг “Хамтарсан баг”-ийн гишүүдтэй хамтран гаргаж, өнөөдрийн байдлаар 58 гэр бүлд “Зөвлөн туслах гэр бүл”-ийн хувийн хэрэг нээж, ар гэрийн, найз нөхдүүдийн тусламж дэмжлэгтэйгээр нөлөөлж гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлж нөлөөлөлийн арга хэмжээг авч ажиллаж байна.Сумдад үйлдэгдэж байгаа гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх бууруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийг хамгаалах “Үжин” төвийн тэргүүн, хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүн Д.Ундраа болон аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүдтэй хамтран Асгат, Уулбаян сумдын хамтарсан баг, хүүхэд хамгааллын багийн ажилтай танилцан хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эцэг эх,ар гэрийхэнд зан үйл, ёс суртахуунд нөлөөлөх замаар зөвлөмж өгч ажилласан. | |
| 282 | | 11. Гэмт хэрэг үйлдэж болзошгүй нөхцөлд байгаа болон хорих ял эдлээд суллагдсан этгээдэд хяналт тавих, нийгэмд дасан зохицох, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах | 2021 - 2024 | | | Цагдаагийн газраас энэ оны 11 дүгээр сарын байдлаар нийт 100 ялтанд хяналт тавин ажилласанаас шүүхээс тэнсэн суллагдсан ялтан урьд оны үлдэгдэл 4, энэ онд нэмэгдсэн 42, хугацаа дууссан 6, үүнээс 2 ялтан дахин гэмт хэрэг үйлдэж хорих ялаар солигдсон, нутаг дэвсгэрийн харъяаллаар шилжүүлсэн 2, нас барсан 1 ялтан байгаа бөгөөд одоо хяналтанд байгаа 35 ялтан байна. Харин хорих ангиас тэнсэн суллагдсан урьд оны 14, энэ онд нэмэгдсэн 9, хугацаа дууссан 14, харъяаллаар шилжүүлсэн 1, одоо 8 ялтанд хяналт тавин ажиллаж байна. Мөн жирэмсэн, 3 хүртэлх настай хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 1, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн 4, үүнээс харъаллаар шилжүүлсэн 1 байна. Одоогийн байдлаар нийт 47 ялтанд захиргааны хяналт тогтоон ажиллаж байна. Хяналтанд байгаа хүмүүст тавих хяналтыг сайжруулах талаар аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Прокурорын байгууллагатай хамтран улирал бүр 1 удаа зөвлөгөөн зохион байгуулж, хяналтад байгаа этгээдийн зан үйлд нөлөөлөх сургалт, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээ, сургалтыг сар бүр аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, “Насан туршын боловсрол” төрийн бус байгууллага зэрэгтэй хамтран үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. | 100 |
| 283 | 4.3.3. Мал хулгайлах гэмт хэргийг иргэдийн оролцоо, дэвшилтэт технологи ашиглан | 1. Аймгийн хэмжээнд 2018 оноос батлан хэрэгжүүлж буй “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх | 2021 - 2024 | 10.000.0- ЗДҮА ХХЗардал | | Аймгийн хэмжээнд 2018 оноос батлан хэрэгжүүлж буй “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр Тус цагдаагийн газраас 2022 онд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор “БОД”, “ДАЙЧИЛГАА” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулснаар Баруун-Урт, Мөнххаан, Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан сумдын нутаг дэвсгэрээс 2021 оны 03 дугаар сараас 2022 оны 02 дугаар сарын хугацаанд 17 удаагийн үйлдлээр иргэдийн 77 бод, 92 бог малыг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | илрүүлэлтийг нэмэгдүүлнэ. | | | | | хулгайлж бусдад 160.600.000 /нэг зуун жаран сая зургаан зуун мянган/ төгрөгний хохирол учруулсан 17 холбогдогчтой хэргийг илрүүлж, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлсэн. Мөн улсын хэмжээнд энэ оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 1 сарын хугацаатай зохион байгуулагдаж байгаа “Мал мах-2022” нэгдсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт зохион байгуулж энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, шийдвэрлэлтийг ахиулахаар зорилгоор аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн сангийн зардлаас 10.000.000 сая төгрөгийг шийдвэрлэж дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Энэ оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар нууц далд аргаар үйлдэгдсэн мал хулгайлах нийт-48 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 27 гэмт хэргийг илрүүлсэн нь хэргийн илрүүлэлт 56,6 хувьтай байна. | |
| 284 | | 2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг татан оролцуулах, тэдний дэмжлэг туслалцааг авах зорилгоор "Малын хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх сан” -г үүсгэн байгуулах | 2021 - 2024 | | | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 08 дугаар тогтоолоор Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сан”-г шинээр байгуулан ажиллаж байгаа боловч сангийн хөрөнгө шийдвэрлэгдээгүй тул одоогоор үйл ажиллагаа хэрэгжээгүй болно. | 50 |
| 285 | | 3. Малчдын бүлгийн ахлагч, гишүүдийг олон нийтийн байцаагчаар томилж, урамшуулал олгох | 2021 - 2024 | | | Аймгийн хэмжээнд нийт 16 малчдын бүлэг, холбоо байдаг бөгөөд тэдний үйл ажиллагааг дэмжиж Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээ мэдээлэл солилцох тэдний хараа хяналтыг сайжруулах хариуцлагатай байх зорилгоор цагдаагийн газраас уулзалт, яриа хийж хамтран ажиллаж байна. | 100 |
| 286 | 4.3.4. Орон нутгийн гамшгаас хамгаалах техник тоног төхөөрөмжийг шинэчилж, гамшгийг даван туулах, дасан зохицох | 1. Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зориулан машин, техник тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх<br>хүрээнд шуурхай албаны автомашиныг шийдвэрлэх | 2022 | | 48 | Япон Улсын Токүшима мужийн Анан хот болон Ава хотын захиргаанаас Монгол Улсын Онцгой байдлын байгууллагад буцалтгүй тусламжаар гал түймэр унтраах, зориулалтын Toyota Land Cruiser маркын 1 ширхэг автомашиныг 2021 оны сүүлээр хүлээж авсан ба Дарьганга сумын Засаг даргад түлхүүрийг гардуулсан. | 90 |
| 287 | чадавхыг бэхжүүлнэ. | 5. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, гамшгийн | 2021 - 2024 | | | Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйл, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/125 дугаар тушаал “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар суманд гамшгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Сүхбаатар аймагт гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх зардлыг шийдвэрлэх | | | | эрсдэлийн ерөнхий үнэлгээг сумын засаг даргын тамгын газарын ажилтан нартай хамтран зохион байгуулсан.<br>Сүхбаатар аймгийн ИТХ-аар Баруун-Урт суманд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд 70 сая төгрөг төсөвлөн аймгийн засаг даргаар ажлын даалгаварыг батлуулсан ба тендэр зарлахад “Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний үндэсний төв” ХХК шалгарч ажлыг эхлүүлсэн. | |
| 288 | | 6. “Аймгийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт, аргазүйн танхим” байгуулах | 2021 - 2024 | | | Баруун-Урт сумын 1 дүгээр багт байрлах Грийн таун хотхон 1 давхарт үйлчилгээний нэгдсэн төвийн сургалтын танхимын асуудлыг шийдвэрлүүлээд байна. 2023 онд аймгийн Засаг даргын нөөц сангаас техник хэрэгслийг шийдвэрлүүлхээр ажиллаж байна. | 50 |
| 289 | 4.4.1. Тэргүүлэх салбарт гадаадын хөрөнгө оруулалт татах, төсөл хөтөлбөр, буцалтгүй тусламжийн тоог нэмэгдүүлнэ. | 1. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй хамтран ажиллах боломжтой олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн нарийвчилсан судалгааг гаргаж хамтын ажиллагааны уулзалтуудыг зохион байгуулах | 2021 - 2024 | | | Америкийн Нэгдсэн Улсын (АНУ) Элчин сайдын яамны (ЭСЯ) Олон нийттэй харилцах албаны (ОНХА) Дэд дарга Сүхбаатар аймгийн Засаг даргатай албан ёсны уулзалт хийн соёл боловсролын салбар дахь хамтын ажиллагааны талаар ярилцаж, Сүхбаатар аймагт америкийн соёл мэдээллийн төв байгуулах саналыг тавьж хийж хэрэгжүүлэх ажил дээр хамтран ажиллахаар боллоо. БНХАУ-аас Замын-Үүдэд суугаа Ерөнхий консул Ли Яньжюнь, консул 2-р нарийн бичгийн дарга Улаанбагана, атташе Б.Билэгбадраа нартай уулзалт зохион байгуулж цаашид хамтран ажиллахаар ярилцлаа. БНХАУлсаас Замын -Үүдэд суугаа Ерөнхий консулын газар Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газарт шинэ корона вирусийн цар тахалтай тэмцэхэд зориулан 7,800.00 ам.долларыг хандивлав. Канад улсын элчин сайдын яамны канад сан Сүхбаатар аймгийн нийгэм олон нийт, хүүхэд, эмэгтэйчүүдэд зориулан үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллагуудтай уулзалт хийж Охид эмэгтэйчүүдийг чадавхжуулах, Хүний эрх, хүүхэд хамгаалал, хүчирхийллийн эсрэг, Эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх, зохистой ажлын байр болон манлайлал, Ядуу эмзэг зорилтот бүлэгт чиглэсэн эдийн засгийн өгөөжийг тогтвортой байлгах, Залуусын манлайллын төсөл хэрэгжүүлдэг талаар танилцуулга мэдээлэл өгч, санал бодлоо солилцлоо. Япон улсын Засгийн газрын 2022 оны "Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж"-ийн хөтөлбөрийн хүрээнд "Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын төсөл"-д 238,923 ам долларын буцалтгүй тусламж үзүүлсэн. | 90 |
| 290 | | 2. Олон улсын төсөл хөтөлбөрөөс санхүүжилт татах чадавхыг бэхжүүлэх | 2021 - 2024 | | | Хууль зүй дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктай хамтран цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийн цогцлоох Японы сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2019-2023 онд хэрэгжүүлж буй “G9198/G9221-MOH” төслийн хүрээнд “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дэмжих | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэгдсэн сургалт зохион байгуулах | | | | хөтөлбөр” Сэлэнгэ, Увс, Сүхбаатар аймаг, Сонгинохайрхан, Налайх дүүрэгт амжилттай хэрэгжиж байна. Хөтөлбөрийн эхний шатанд Сүхбаатар аймгийн 27 эмэгтэй хувь хүний хөгжил, санхүү, хууль эрх зүйн мэдлэг олгох, бизнесийн төлөвлөгөө боловсруулах, чадавх бэхжүүлэх сургалтад хамрагдаж, олж авсан мэдлэг, туршлагадаа үндэслэн өрхийн эдийн засгийг дэмжих бичил бизнес эрхлэх төслийг боловсруулсан. Хөтөлбөрийн 2 дахь шатанд сургалтад хамрагдсан эмэгтэйчүүдээс 26 эмэгтэй өөрсдийн санаачилсан бичил төслийн саналыг боловсруулан ирүүлж, 26 нь төслөө өөрийн биеэр сонгон шалгаруулах ажлын хэсэгт амжилттай танилцуулсан байна. Сонгон шалгаруулалтаар хамгийн өндөр оноо авч шалгарсан 10 эмэгтэйд бичил төсөл хэрэгжүүлэх батламжийг өнөөдөр гардууллаа. Төсөл хэрэгжүүлэхээр сонгон шалгарсан 10 эмэгтэйн төслийн хамрах хүрээ, ирүүлсэн саналыг үндэслэн хүн тус бүрд 2500 ам.доллар хүртэлх тэтгэлгийг буцалтгүй тусламж хэлбэрээр олгох бөгөөд төслийг цаашид бие даан амжилттай хэрэгжүүлэх, өрхийн эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор дараагийн шатны санхүү, маркетинг, гарааны бизнес эрхлэх чадавх бэхжүүлэх сургалтыг зохион байгуулах юм. | |
| 291 | | 3. KOICA олон улсын байгууллагатай хамтран Солонгос улсаас сайн дурын ажилтан ажиллуулах үйл ажиллагааг зохион байгуулах | 2021 - 2024 | | 1 | Монгол улсын улаан загалмайн нийгэмлэг, аймгийн Улаан загалмайн нийгэмлэг, БНСУ-ын олон улсын нээлттэй эмч нарын нийгэмлэгтэй хамтран хөдөөгийн хүн амд тусламж үзүүлэх зорилгоор Сүхбаатар суманд чих хамар хоолой, шүд, уламжлалт, дотор, гэмтэл, мэс засал, сувилахуйн зэрэг 7 төрлөөр нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг нийт давхардсан тоогоор 1353 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлсэн.<br>БНСУ-ын олон улсын нээлттэй эмч нарын нийгэмлэг урилгаар БНСУ-д Сүхбаатар сумын Засаг даргын орлогч, Эрүүл мэндийн төвийн дарга нарыг “koreon open doctor” эмнэлэг дээр 5 хоногийн хугацаатай туршлага судлан ажилласан. Засаг даргын санаачлагаар БНСУ-ын Южин Оптикал эмнэлгийн эмч нар 2023 оны 5 сард аймгийн 1000 иргэнд нүдний иж бүрэн оношлогоо, шинжилгээ хийж үнэ төлбөргүйгээр нүдний шилээр хангах хэлэлцээрийг хийж үзлэгийн бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.Уг шинжилгээ оношлогоонд 40-өөс дээш насны алслагдсан нутгийн иргэд, ХБИ, харааны бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулахаар төлөвлөөд байна. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 292 | | 4. БНТУ-ын Самсун мужтай харилцааг сэргээж, албан ёсны хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах | 2022 - 2024 | | 1 | БНСУ-ын олон улсын нээлттэй эмч нарын нийгэмлэг урилгаар БНСУ-д Сүхбаатар сумын Засаг даргын орлогч, Эрүүл мэндийн төвийн дарга нарыг "koreon open doctor" эмнэлэг дээр 5 хоногийн хугацаатай туршлага судлан ажилласан. Засаг даргын санаачлагаар БНСУ-ын Южин Оптикал эмнэлгийн эмч нар 2023 оны 5 сард аймгийн 1000 иргэнд нүдний иж бүрэн оношлогоо, шинжилгээ хийж үнэ төлбөргүйгээр нүдний шилээр хангах хэлэлцээрийг хийж үзлэгийн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.Уг шинжилгээ оношлогоонд 40-өөс дээш насны алслагдсан нутгийн иргэд, ХБИ, харааны бэрхшээлтэй хүүхдүүдийг хамруулахаар төлөвлөөд байна.<br>- Унтуулгын аппарат-1<br>- Хагалгааны дүүжин гэрэл-1<br>- Түлэгч аппарат-1<br>- Хагалгааны ор-1<br>- Мэдээгүйжүүлгийн эм, тарианы шүүгээ-1<br>- Монитор-1<br>- Унтуулгын аппарат-1<br>- Хагалгааны ширээ-2<br>- С-арм аппарат-1<br>- Тархины цахилгаан бичлэгийн аппарат-1<br>Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, харилцааг шинэ шатанд гаргах ажлыг 2023 онд зохион байгуулахаар төлөвлөж байна. | 70 |
| 293 | 4.4.2. БНХАУ-ын аймаг, хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллана. | 1. БНХАУ-ын Шилийн гол аймаг, Хөлөнбуйр аймаг, Тунляо, Улаанхад хотуудтай хамтарсан зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | | | БНХАУ-аас Замын-Үүдэд суух ерөнхий консул Ли Яньжюньтай цахимаар 1 удаа, биечлэн 2 удаагийн албан ёсны уулзалт хийсэн. Уулзалтын үеэр Сүхбаатар аймгийн зүгээс хөдөө аж ахуй /мах/ , газар тариалангийн салбарт БНХАУ-тай хамтран ажиллах, мөн өөрийн орон нутагт ажиллах нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх чиглэлээр хамтран ажиллах санал тавьсан.<br>Энэ онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөнбуйр хот хоорондын хамтын ажиллагааны цахим уулзалтыг 1 удаа зохион байгуулсан. Тус уулзалтын үеэр нийгэм, эдийн засаг, бизнес, худалдааны салбарт хамтын ажиллагааг эрчимжүүлж, харилцан ашигтай харилцааг эхлүүлэхээр болсон.<br>МОНГОЛ-ОХУ-БНХАУ хоорондын бүс нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих, сурталчлах хуралд Монгол улсын Дорнод аймаг, Сүхбаатар аймаг, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс, ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар, БНХАУ-ын Хөлөнбуйр хотын төлөөлөгч нар оролцсон. Хурлаар хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хамтран ажиллах талаар санал солилцож 3 улсын 41 төсөл танилцуулагдсан. | 70 |
| 294 | | 2. БНХАУ-ын Ляонин мужтай хамтын ажиллагааг сэргээж | 2022 - 2024 | | | БНХАУ-ын Ляонин мужийн Жинжоу хот дахь "Зүүн хойд хуурай газар-Далайн шинэ суваг байгуулах төсөл"-ийн удирдагч нарын хооронд зөвлөлдөх хурлыг зохион байгуулсан. Тус уулзалтын үеэр 2 аймгийн дарга оролцогч нарыг болон орон нутгийн талаар товч танилцуулсан. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | санамж бичгийг шинэчлэн байгуулах | | | | 2022 оны 2-р сард өвлийн олимпын үеэр БНХАУ-ын төрийн зөвлөлийн ерөнхий сайд Ли Кэчян болон Монгол улсын ерөнхий сайд Оюун-Эрдэнэ нар уулзаж зүүн хатавч боомт болон бичигтийн боомтыг төмөр замаар холбох тохиролцоонд хүрсний дагуу Жинжоу боомтоос эхлээд БНХАУ-ын Ляонин муж, ӨМӨЗО, Хятад-Монголын хилийн Зүүн хатавч боомт, Бичигт боомт, Баруун-Урт хот, Монголын зүүн хэсгийн Чойбалсан хот гэсэн чиглэлийн төмөр зам цаашлаад Оросын Сибирийн төмөр замтай холбогдож Европт хүрэх зорилгын талаар санал бодол солилцсон. БНХАУ-ын Зүүн хойд далайд шинэ суваг барих ажлын хүрээнд Монгол улсаас хүрэн нүүрс, малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд, цайр гэх мэт бүтээгдэхүүн. Мөн БНХАУ-аас импортолж болох бараа бүтээгдэхүүнийг төмөр зам болон авто замаар хэрхэн тээвэрлэх талаар ярилцаж тус ажлыг яаралтай шийдвэрлэж өгөхийг 2 улсын Засгийн газартаа уламжлахаар болсон. | |
| 295 | | 6. БНХАУ-ын ӨМӨЗО-ны хил орчмын аймаг, хошуутай хамтран бизнес эрхлэгчдийн уулзалт, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах | 2022 - 2024 | | | Цайны зам олон улсын аялал жуулчлалын холбооны хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдаж, хуралд Монгол, Хятад, Орос гурван улсын салбарын дарга нар болон Нийслэлийн аялал жуулчлалын газар, Сүхбаатар аймаг, Өмнөговь аймаг, Дорнод аймаг, Дорноговь аймаг оролцож шинээр энэ удаагийн хурлаар Монгол улсын Хэнтий аймаг, Говьсүмбэр аймаг, ОХУ-ын Хабаровскийн хязгаар орон, Приморийн хязгаар орон зэрэг аймаг мужууд гишүүнээр элсэн орлоо. Мөн хурлаар холбооны дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах, соёлын солилцоо, эдийн засаг худалдааны солилцоог ахиулах тодорхой арга хэмжээнүүдийг хэлэлцсэн ба тус хуралд аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, ХБТХОХ, БОАЖГ-ын дарга, мэргэжилтнүүд оролцсон байна. | 50 |
| | | | | | | "Шинэ сэргэлт-Аялал жуулчлал" уриан дор зохион байгуулагдсан ITM-2022 MONGOLIA олон улсын үзэсгэлэн Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэгчид буюу Баруун-Урт сумаас "Чамбай" брэнд, "Чулуун дарь овоо" ХХК, "Мөнхсайн үүд" ХХК, "Дарьганга кэтеринг" ХХК, "Дөш" брэнд, Улаанбаатар хотоос Агтана хүрээт төсөл, Дарьганга сумаас Зураач Б.Энхмаа, Мөнххаан сумаас "Аринги" брэнд болон аймгийн Засаг даргын Тамгын газар, "Байгаль орчин аялал жуулчлалын газар", "Тал нутгийн өнгө" аялал жуулчлалын холбоо хамтран аймаг орон нутгийн өнгө төрх, соёлыг илэрхийлсэн гар урлал, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлчилгээгээр оролцож аймаг орон нутгаа сурталчиллаа. | |
| 296 | 4.4.3. ОХУ-ын хил орчмын муж хотуудтай хамтын | 1. Өвөр Байгалийн хязгаартай хамтын ажиллагааг сэргээж, санамж бичиг байгуулах | 2022 - 2024 | | | Бүс нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжих, сурталчлах цахим хуралд Монгол улсын Дорнод аймаг, Сүхбаатар аймаг, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс, ОХУ-ын Өвөр байгалийн хязгаар, БНХАУ-ын Хөлөнбуйр хотын төлөөлөгч нар оролцсон. Хурлаар хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хамтран ажиллах талаар санал | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг өргөжүүлнэ. | | | | | солилцож 3 улсын 41 төсөл танилцуулагдсан ба тус аймгаас “Дулааны аргаар мах боловсруулах”, “Сүүний чиглэлийн үхрийн ферм”, “Борц үйлдвэрлэх”, “Арьс, нэхий боловсруулах бүтээгдэхүүний бага оврын үйлдвэр” гэсэн 4 төсөл танилцуулагдаж хамтран ажиллах санал тавьсан. | |
| 297 | 4.4.4. Нэгдсэн Үндэсний Байгууллагын "Тогтвортой хөгжлийн зорилт - 2030" хөтөлбөрийн хүрээнд "Орон нутагт тогтвортой хөгжлийн зорилтыг нутагшуулах нь" төслийг хэрэгжүүлнэ. | 1. Монгол дахь Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр түүний салбар төслүүдтэй орон нутгийн түвшинд хамтран ажиллах уулзалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | | | НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран 2021-2028 онд Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймагт хэрэгжүүлж буй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөл хэрэгжихээр болсон ба төслийн нэгж Сүхбаатар аймгийн орон нутгийн засаг захиргааны болон мэргэжлийн байгууллага хамт олонд төслийн танилцуулгыг хийлээ. Мөн оролцогч талуудад төслийн хэрэгжилтийн уялдааг хангах, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлд зөвлөмж өгч, цаашид тус орон нутгийн уур амьсгалын өөрчлөлт, байгаль хамгааллын чиглэлээр хамтран ажиллах чиглэлд санал солилцжээ. Уг төсөл нь үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй. Нийт 4 аймгийн 68 сумын хөгжлийн төлөвлөгөө, 4 аймагт 2500 га газрыг ойжуулах, 88 булаг хамгаалах, 18 ус хураах байгууламж байгуулах, 285 худаг гаргах, сэргээн засварлах, 2890 га хадлан бэлчээрийн нөөц газар байгуулах, 48 малын тэжээлийн агуулахын барилга байгууламж баригдах ажил төслийн бичиг баримтад төлөвлөгдөн, 300 малчдын хоршоо бүлэг нөхөрлөл хамрагдаж үүний 50 нь гэрээ хэлцлээр баталгаажсан байх ба төслөөс шууд үр дүн хүртэгчид 130 мянган хүн, шууд бусаар үр дүнг хүртэгчид 800 мянган хүн хамрагдах учиртай ийм үр дүн энэхүү төслөөс хүлээгдэж байгаа юм. Үүнээс Сүхбаатар аймагт хүрэх үр дүнгийн тооцооллыг хүргэвэл, 300 га-д татмын ойн нөхөн сэргээлт хийнэ. 300 га талбайд бэлчээр хамгаалах ажил хийгдэнэ. 9 ширхэг өвс тэжээлийн агуулах барина. 20-оос доошгүй булаг хашиж, хамгаална. 70 гаруй худаг гаргах, засварлана. 4 ширхэг хөв барина. Хуучин ашиглаж байсан усалтын системийг сэргээхээр төлөвлөөд байна | 90 |
| 298 | | 3. “Тогтвортой хөгжлийн зорилт”-ыг нутагшуулах төслийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулах | 2022 - 2024 | | | Монгол дахь Нэгдсэн үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сан, хүүхдийг ивээх сантай хамтран ажиллах санал бүхий албан бичгийг хүргүүлсэн. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд хэрэгжиж буй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” хөтөлбөр тус аймагт 2021-2028 онд хэрэгжихээр болсон ба уг хөтөлбөрийн хүрээнд 2021 онд судалгаа хийсэн ба түүний үр дүнг танилцуулах уулзалт, сургалтыг зохион байгуулсан. НҮБ-ын Хүүхдийн Сан, Монгол Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны суурь баримт бичиг болох Улс орны хөтөлбөрийн (2023-2027) баримт бичгийг 2022 оны 5 дугаар сард Монгол Улсын Засгийн газар, 9 дүгээр сард Нью-Йорк дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн Удирдах Зөвлөл тус тус баталсан. Таван | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жилийн хугацаанд хэрэгжих тус хөтөлбөрийг улс орны хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй уялдуулсны зэрэгцээ үндэсний болон орон нутгийн түвшин дэх төрийн болон төрийн бус байгууллагууд, хүүхэд залуус, бусад холбогдох талуудтай зөвшилцөж боловсруулсан билээ. | |
| | | | | | | Улс орны хөтөлбөрийн баримт бичиг батлагдсантай холбоотойгоор Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн Сан ирэх таван жилийн Үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулж байгаа бөгөөд хүүхдийн эрхийг хангах чиглэлээр аймагт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, ололт амжилт, тулгарч буй асуудлууд, тэргүүлэх чиглэлүүдийн талаар санал солилцсон. | |
| 299 | 4.4.5. "Их түмэн санаачилга" бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд зүүн бүсийн хэмжээнд хамтран оролцоно. | 1. БНСУ, Япон Улсын муж, хотуудтай хамтын ажиллагаа тогтоох | 2022 - 2024 | | | Япон Улсын Засгийн газрын 2022 оны “Өвсний үндэс - Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж”-ийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих “Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн засварын төсөл”-ийн буцалтгүй тусламжийн гэрээнд Элчин сайд Х.Кобаяши болон Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат нар гарын үсэг зурав. Уг төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Ерөнхий боловсролын сургуулийн Б байрны дээвэр, гадна фасад, дотор засал (дээвэр, хаалга, цонх, шал, халаалт болон агааржуулалтын систем), цахилгааны засвар зэрэг ажлууд хийгдэж тус сургуульд эрүүл, аюулгүй сургалтын орчинг бүрдүүлэх юм. Уг төсөл нь Өвсний үндэс буцалтгүй тусламжийн 584 дэх, Сүхбаатар аймагт хэрэгжих 14 дэх төсөл болж байгаа бөгөөд батлагдсан төслийн санхүүжилтийн дээд хязгаар нь 238,923 ам.доллар (743,530,700 орчим төгрөг) юм. | 90 |
| | | | | | | Аймгийн Засаг дарга Япон, Солонгос улсад ажиллах үеэрээ Сүхбаатар аймгаас ажиллах хүч гаргах, хамтран ажиллах саналыг илэрхийлээд байна. Мөн БНСУ-ын нүдний эмч мэргэжилтнүүдийн багийг 2023 онд ажиллуулж, хараны бэрхшээлтэй 1000 иргэнийг нүдний үзлэг оношлогоонд хамруулах саналыг тавьж шийдвэрлүүлсэн ба тус улсын Южин Оптисал эмнэлгийн захирал И САНГ ХУ –аар ахлуулсан хараа зүйн чиглэлийн нарийн мэргэжлийн эмч нар ирж албан уулзалт хийсэн. 2023 оны 2-р улиралд БНСУ-ын нүдний нарийн мэргэжлийн 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг ирж үзлэг оношлогоо хийж, зөвлөгөө өгөхөөр боллоо. | |
| 300 | | 2. "Их түмэн санаачилга" бүс нутгийн хамтын ажиллагааны хорооны уулзалтад идэвхтэй оролцож, тэргүүлэх салбарт хамтарсан төслийн санал боловсруулах | 2022 - 2024 | | | 2022.09.06-нд "Их түмэн санаачилга" Зүүн хойд Азийн орон нутгийн хамтын ажиллагааны хорооны 10 дахь хурал болсон. Хурлаар өнгөрсөн хугацаанд хийгдсэн ажлын танилцуулга, Корона вируст халдварын үеийн болон дараах үеийн сорилт, арга хэмжээ мөн зүүн хойд бүсийн тээврийн хөгжлийн талаар хэлэлцсэн. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 301 | 4.5.1. Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч хүмүүжлийг төлөвшүүлнэ. | 1. Аймгийн хэмжээний ЕБ-ын 10 сургуульд цэрэг дайчдын "Алдарын танхим" байгуулах | 2021 - 2024 | 4 сая | | Ерөнхий боловсролын 10 сургуульд цэрэг дайчдын ‘’Алдрын танхим’’ байгуулахаар тусгаснаас 2021 онд Баруун-Урт сумын ерөнхий боловсорлын хоёрдугаар сургууль, Түвшинширээ сумын сургуульд байгуулсан, 2022 онд Баруун-Урт сумын ерөнхий боловсорлын нэгдүгээр сургууль, Эрдэнэцагаан сумын сургуульд байгуулхаар 2022 оны 11 дугаар сарын 11 А/585 дугаар захирамж гарч цэрэг дайчдын ‘’Алдрын танхим’’ байгуулагдаж байна. | 100 |
| 302 | 4.5.2. Дайчилгааны төлөвлөгөөг шинэчилж, томилгоот бүрэлдэхүүнийг чадавхжуулна. | 1. Дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэх сургалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | - | | Аймгийн ‘’Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг бие бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө’’, ‘’Орон нутгийн цэргийн бэлтгэлийг хангах, байгуулах төлөвлөгөө’’, ‘’Цэргийн штабыг байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө’’-г шинэчилэн боловсруулж батлуулж сумдын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна | 100 |
| 303 | | 2. Цэргийн штаб, анги салбарын сургалтын нэгдсэн төвийг байгуулах | 2021 - 2024 | - | | Аймгийн иргэдийн хурлаар дайчилгааны бэлтгэл нөөцийг бүрдүүлэх хөрөнгийг үе шаттайгаар суулгаж батлуулсан. Сургалтын төв байгуулах тусгай хэрэгцээний газрыг холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлсэн | 30 |
| 304 | 4.5.3. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу нөөц бүрдүүлнэ. | 1. Орон нутгийн томилгоот нэгж, түүний удирдлага, бие бүрэлдэхүүний сургалтыг үе шаттай зохион байгуулах. | 2021 - 2024 | | | Сүхбаатар аймгийн Засаг дарга Батлан хамгаалахын сайдтай байгуулсан 2022 онд хамтран ажиллах гэрээний 4.2 дахь заалтыг хэрэгжүүлэн, цэргийн штабын 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, томилгоожуулах, томилгоог тодотгох арга зүй сэдвээр 13 сумын ЗДТГ-ын дарга, 67 багын дарга нарт сургалт явуулсан. | 70 |
| 305 | | 2. Орон нутгийн хамгаалалтын техник хэрэгсэл, бараа материалын нөөцийг бүрдүүлэх | 2021 - 2024 | | | Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж 2021 онд 2,5 сая төгрөг төлөвлөснөөс 2.2 сая төгрөгийн өртөг бүхий хээрийн хувцас 20 ширхэг, гутал авч нөөц бүрдүүлээд байна. Мөн Өсөх дэлгэр ундрах дэлгүүртэй хүнс, бараа материалаар нөхөн хангах гэрээ байгуулсан. | 70 |
| 5. ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ | | | | | | | |
| 306 | 5.1.1. Байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн талаарх боловсролыг дээшлүүлнэ. | 1. Иргэдэд байгаль хамгаалах, ногоон хөгжлийн боловсрол олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | 11,4 сая төгрөг | | 2022 онд аймгийн хэмжээнд байгаль орчны тэмдэглэлт өдрийг тохиолдуулан нийт 6 удаагийн 28 арга хэмжээг зохион байгуулж 275 ААНБ, 19336 иргэн хамрагдсан байна. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад нийт 11,4 сая төгрөг зарцуулаад байна. - Тайлангийн хугацаанд Байгаль орчны салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийн 4 удаа зохион байгуулсан. Нээлттэй хаалганы өдөрлөгийн үеэр тарьц суулгац-2022 үзэсгэлэн худалдаа-2, тэмцээн уралдаан-9, хэлэлцүүлэг-3, ТВ нэвтрүүлэг-8, гарын авлага зөвлөмж-6566 иргэнд өгч ажилласан. Дээрх арга хэмжээг БОАЖГ, УЦУОШГ, БНМТСГ-ын захиргаа, Дөрвөлж компани, Сүхбаатар ТҮОНӨААТҮГ, Сүхбаатар ойжуулалт сум дундын ойн анги, Шаргын модот ХХК, Ойжуулалт хайлааст ХХК, Мяндарт, Талын жимс зэрэг газруудтай хамтран зохион байгууллаа. - Мөн 13 сумын байгаль хамгаалагч нар орон нутагтаа байгаль орчныг хамгаалах, Тогтвортой хөгжлийн боловсролын зорилтыг хэрэгжүүлэх, экологийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр нийт давхардсан тоогоор 44 удаагийн арга | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээ зохион байгуулж 9194 орчим хүн хамруулж 8 төрлийн 5278 ш гарын авлагыг иргэдэд тарааж, 16 ш мэдээллийн самбарыг шинээр хийн байршуулж, орон нутгийн төсвөөс 5145927 төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: сургалт - 19 өдөрлөг-24 хэлэлцүүлэг-3 тэмцээн уралдаан-11 ТВ болон цахим орчинд 172 мэдээлэл тавьж 11277 хүний хандалт авсан байна | |
| 307 | | 2. ЕБС-ийн Эко клубүүдийг чадавхжуулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх | 2022 - 2024 | орон нутаг-13000.0 | | Аймгийн 16 ЕБС-ийн эко клубийн дунд байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн боловсролыг дэмжих зорилгоор " ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД – ЭКО КЛУБИЙН ОРОЛЦОО" сэдэвт нийт 13 сая төгрөгийн санхүүжилттэй төслийн уралдааныг зарлаж уралдаанд нийт 9 төсөл ирүүлснээс: | 100 |
| | | | | | | 1- р байр Уулбаян сумын ЕБС-ийн "Орчноо ногооруулъя" төсөл 6000000 төгрөг, 2- р байр Баруун –Урт сумын 4 дүгээр ЕБС-ийн "Холивол хог-Ангилбал баялаг" төсөл 3000000 төгрөг, 3- р байр Баруун –Урт сумын 3 дугаар сургуулийн "Холивол хог-Ангилбал мөнгө" төсөл 2000000 төгрөг, 4- р байр Дарьганга сумын ЕБС-ийн "Өнөөдрийн хог маргаашийн баялаг" төсөл 2000000 төгрөг тус тус шалгарч хамтран ажиллах гэрээг байгуулан төслийн үр дүнд дараах ажлууд сургуулиуд дээр хийгдлээ. Үүнд: | |
| | | | | | | -сургалт нөлөөлийн ажил СӨБ-ын 257 хүүхэд, ЕБС-ын 2797 сурагчдад сургалт | |
| | | | | | | -ялган ангилах хогийн сав гадна талд-4ш | |
| | | | | | | -хог хаягдал ашиглан бүтээл хийх тэмцээн, уралдаан-6 | |
| 308 | | 3. Жил бүр 3-аас доошгүй сумын Улсын тусгай хамгаалалтад авах газруудын судалгааг гаргаж, аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, Засгийн газарт уламжлах | 2021 - 2024 | | | Түвшинширээ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 сарын 30 өдрийн 08 дугаар тогтоолоор 7370 га газрыг дурсгалт газрын ангиллаар тусгай хамгаалалтад авч Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын хэлтэст бүртгүүлээд байна. | 70 |
